

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY



Өсөлт бас дахин өсөлт

Эдийн засгийн хурдацтай
хөгжлийг Лондоны бирж
алдахыг хүсдэггүй

Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн сэтгүүл

2011. 12 сар. №10

www.mongolianeconomy.mn

2012 он ИХ ӨСӨЛТИЙН ЖИЛ



Naran Motors Co.,Ltd



Sheer
Driving Pleasure

www.bmw.mn



PRINCIPLES OF LEADERSHIP.

BMW 7 Series. Inspired by the core principles that take leaders from success to success.



СОЁЛЫН ӨВИЙГ ДЭЭДЛЭГЧ МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН ОЮУ ТОЛГОЙ КОМПАНИ



Оюу Толгой
компани
Монголын говь
нутаг, үндэстэн
ястны эх түүх,
эрдэм соёлын
өвийг хамгаалах,
өвлүүлэхэд хувь
нэмрээ оруулсаар
байна

Харилцагчдынхаа итгэлээр БИД МАНЛАЙЛДАГ

The Banker сэтгүүл Голомт банкийг “МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ БАНК”-аар дахин шалгаруулсанаа 2011 оны 11-р сарын 30-ны өдөр Лондон хотноо албан ёсоор зарлалаа.



Голомт банк олон улсад нэр хүнд бүхий “The Banker” болон “Euromoney” сэтгүүлүүдээс “МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ БАНК” шагналыг зэрэг хүртсэн амжилтаар 2012 оноо угтаж байна.

*Бидний амжилтын хөтөч болсон
ХАРИМЦАГЧ ТАНДАА БАЯРЛАЛАА!*

www.golomtbank.com

SWAROVSKI



Swarovski boutique #1

4 давхар, Наран Плаза төв, Чингисийн өргөн чөлөө-29

Swarovski boutique #2

2 давхар, Сентрал Тауэр, Сүхбаатарын талбай

Swarovski Crystal Forest boutique

1 давхар, Наран Молл, Сөүлийн гудамж 42/1

Утас: 328841



Гутланд уяатай төсөв

Таван ам бүлийн хүртэж буй эх орны хишиг 105 мянган төгрөг тэдний хагас сарын хүнсийг даадаг.....16



Өсөлт бас дахин өсөлт



Монгол Улсыг хөгжиж буйд итгэхийн тулд чанарын өөрчлөлтийг харах хэрэгтэйг Ц.Батсүх багш зөвлөлөө.18

Сангийн сайд Д.Моломжамц агсныг дурсахуй



Тэрбээр эдийн засаг, нийгмийн байдал хүнд, ороо бусгаа үед 26-хан насандаа Сангийн сайдын хүндхэн албыг авчээ.....25

Эдийн засаг

- 8 2012 он сав саалиар бялхах уу?
- 10 С.Баярцогт
- 14 Монголын эдийн засгийн 2011 оны онцлох таван үйл явдал
- 16 Гутланд уяатай төсөв
- 18 Өсөлт бас дахин өсөлт
- 22 20 дугаар тогтоол давтагдах уу? Үгүй, гэхдээ...
- 23 Эдийн засгийн өнгө
- 25 Сангийн сайд Д.Моломжамц агсныг дурсахуй
- 28 Нийгмийн хөгжлийн загвар ба Монгол орон
- 30 Монголын олон их, дээд сургуульд хэн багшлах юм бэ?
- 31 Монголд хөрөнгө оруулахад учирч болох улс төрийн эрсдэлүүд-III
- 33 Цахим матаас
- 34 2011 оны дэлхийн шилдэг зургууд
- 36 Өрнөдийн тухайд тогтворгүй, дорнодын тухайд тодорхойгүй

Ногоон эдийн засаг

- 38 “Ногоон эдийн засгийн өсөлт” ногоон хөгжлийн төлөө
- 43 НҮБ-ын тогтвортой хөгжил сэдэвт бага хурлын тухай

Хөрөнгийн зах зээл

- 44 Б.Болд: Залуучууд ирээдүйд тэтгэврийн хуримтлалаа өөрсдөө бүрдүүлэх хэрэгтэй

47

Бизнес

- 49 Хөгжлийн төлөө хэрхэн түншлэх вэ
- 51 “Урт нэртэй” хуулийг удган бөөгөөс асуух ёстой юу
- 54 Шинэ жилийн дурсамжууд
- 56 Компанийн тухай шинэ хуульд хүмүүс ам сайтай байна
- 60 Нэг өдөр
- 62 Шинэ санаа яаж төрдөг вэ?
- 64 Таны амьдралд өөрчлөлт авчирсан номоо нэрлэхгүй юү?

Б.Болд: Залуучууд ирээдүйд тэтгэврийн хуримтлалаа өөрсдөө бүрдүүлэх хэрэгтэй



Залуу хүмүүс илүү эрсдэлтэй хөрөнгө оруулалтыг сонгож болох юм. Гэхдээ энэ нь гүйж очоод л эрсдэлтэй хувьцаа авна гэсэн үг биш..... 44

“Урт нэртэй” хуулийг удган бөөгөөс асуух ёстой юу



...“Урт нэртэй” хуулийн хэрэгжилт “нинжа” нарын тоог хэдэн мянгаар нэмэгдүүлж байгаль орчны асуудал бүр ч хүндэрч, хяналтаас гарах магадлал өндөр гэдгийг ч олон хүн сануулж байлаа.....51



Онцлох сэдэв

2012 он сав саалиар бялхах уу?

И.Отгонжаргал

Улаанбаатар хотын гудамж талбай шинэ жилийн гоёлоо зүүсэн нь өмнөхөөсөө ч илүү гоёмсог харагдана. 2011 он Монголын эдийн засаг, бизнесийн салбарт өсөлт авчирсан жил байсан нь их хотын шинэ жилийн уур амьсгалын өнгө төрхөөс илт. Та анзаараарай, өмнө нь “Улсын их дэлгүүр”, “Худалдаа хөгжлийн банк”, “Бишрэлт” их дэлгүүр зэрэг хотын төвийн тоотой хэдхэн газарт байрлах томоохон байгууллагуудын гаднаа зассан гацуурыг харж, хооронд нь харьцуулж баясдаг байсаан, нийслэлчүүд. Гэхдээ жилээс жилд их хотын гудамж талбай дахь ганган гацуурын тоо нэмэгдсээр ирсэн. Харин энэ жил

байгууллагуудын гаднах шинэ жилийн гоёлд шинэчлэл гарчээ. “Central tower”, “Grand plaza”, “Maxmall” зэрэг өндөр барилгын гаднах даруухан хэрнээ сүрлэг гацууруудаас ажихад туулай жилийн турш эдийн засгийн макро түвшинд бишгүй дуулдсан сайн мэдээнүүд микро түвшинд буюу үйлдвэр аж ахуйн нэгжүүдээс эхлээд өрх гэрийн амьдралд ийн тусгалаа олсон байж ч болох талтай юм байна даа гэж таамаглахад хүрв. Зөвхөн хотын төвийн шинэхэн сүндэрлэсэн барилгууд төдийгүй хотын хамгийн баруун захад шахуу байрлах “Teso” компанийнхан ч хашаандаа “Maxmall”-ынхоос дутахааргүй сүрлэг гацуур ▶

сүндэрлүүлсэн байна лээ. Хажууд нь өөрийн бүтээгдэхүүн болох “Милко” сүүнийхээ том гэгч нь хайрцгийг байрлуулсан нь утга дүйгээд тун чиг зохицолдолгоотой байв. Түүнчлэн бүсгүйчүүдийн шинэ жилийн гоёлоо хайх дэлгүүрийн тоо ч ганцхан жилийн дотор хэд хэдээрээ нэмэгдсэн. Ая тухтай боловсон орчин, барааныхаа сонголттой уялдуулсан харьцангуй өндөр өртөгтэй дэлгүүрүүдээр хэсэж, худалдан авалт хийх хүний тоо ч мэдэгдэхүйц нэмэгдсэн.

ДНБ-ий хэмжээ 7,810.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 31.4 хувиар нэмэгдсэн нь макро эдийн засагтай холбоотой сайн мэдээнүүдийн нэг. Уг өсөлтөд үйлчилгээний салбарын өсөлт болон бүтээгдэхүүний татварын хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Үйлчилгээний салбар энэ онд 29.0 хувь, 2005 оныхтой харьцуулахад 20.1 хувиар өссөн тухай Сангийн яамнаас гаргасан “Монгол Улсын 2011 оны макро эдийн засгийн байдлын хүлээгдэж буй гүйцэтгэл, 2012 оны хандлага” тайланд дурджээ.

Монгол Улс хөгжиж байна, эс хөгжиж байна, эдийн засгийн өсөлт сайн байна, сайнгүй байна гээд л санал шүүмжлэл байнга гардаг. Тиймээс “Mongolian Economy” сэтгүүл арав дахь дугаартаа Монголын эдийн засгийн 2011 оны байдлыг дүгнэн авч үзэж, ирэх оны төлөвийг урьдчилан харуулах чиглэлд ажиллаж, олон нийтлэл, ярилцлага бэлтгэн хүргэж байна.

Юуны өмнө нэгэн оныг үдэж, нэгэн шинэ жилийг угтах баярын дугаар учраас Монголын эдийн засагт 2011 онд болсон онцлох үйл явдлуудаас шүүн тунгааж тавыг нь онцлон хүргэж буйгаа тэмдэглэе.

“Төв Азийн Кувейт”, “Азийн дараагийн бар”, “Чоно эдийн засаг”, “Нүүрсний Саудын Араб” зэрэг сайныг зөгнөсөн нэршил олон дуулдах нь таатай. Гэхдээ Монгол орныг “Minegolia”, “Moncoalia” хэмээн уурхай, нүүрстэй холбон хочлох нь ч бий. Ийн сайн, саараараа дуудуулж, дэлхийн анхаарлын төвд ороод буй Монголын эдийн засгийн салбарт удахгүй үдэх гэж буй онд улс орны болоод өрх гэр, иргэдийн амьдралд онцгой нөлөөлөхүйц ямар онцлог үйл

явдлууд болсон бэ гэдгийг Та манай энэ дугаараас сонирхон уншаарай.

Европын Холбооны улсыг эдийн засаг, санхүүгийн хувьд тун хүнд байдалд оруулж, тэвдүүлээд буй 2011 он талын Монголын хувьд нийгэм, эдийн засгийн илүү таатай байдлыг бий болгосон гэж үзэж болно. Дэлхийд ч төдийлэн дуулдаад байдаггүй эдийн засгийн огцом өсөлт гараад зогсоогүй гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ гэрлийн хурдаар өсөж оны төгсгөлд гурван тэрбум ам.долларт хүрэх урьдчилсан мэдээлэл нэлээд эрт цацагдаж амжсан. Ашигт малтмалаар баян Монгол Улс уул уурхайн түүхий эдийн хамгийн том зах зээл болох Хятадтай хил залгаа оршиж байгаагаараа өнөөдөр дэлхийд танигдаж чадлаа. Тийм болохоор эрдэс баялгийн салбарт тун богино хугацаанд төсөөлж ч байгаагүй их хэмжээний хөрөнгө оруулалт орж ирж “Халуун мөнгө”, “Голланд өвчин” гэсэн эдийн засгийн аюул дагуулах магадлалтай дэлхийд зартай нэр томъёотой ч нүүр тулаад амжлаа. Тиймээс эрдэс баялгийн орлогоо хэрхэн зөв зүйтэй хуваарилах вэ, эдийн засгаа төрөлжүүлж, уул уурхайгаас бусад салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татаж эрчимтэй хөгжүүлэх хэрэгтэй талаар яриад суух биш, ирэх онд ямар нэгэн алхам хийнэ гэж найдъя.

Зөвхөн эдийн засгийн хувьд төдийгүй бизнесийн салбарт ч хурдтай хөгжил, шинэ үзэгдлүүд гарсан он байлаа. Гадаадын хөрөнгө оруулалтаар босч, цаашдаа бие дааж гадагшаа хөрөнгө оруулах нь элбэг гаднын туршлагыг нэвтрүүлэх цаг хугацаа Монголын бизнесмэнүүдэд тун ойрхон байгаа Гадаадын хөрөнгө оруулалтын газрын орлогч дарга З.Баттүшиг манай сэтгүүлд ярилцлага өгөх үеэрээ онцолж байсан. Тэгвэл гадаадын хөрөнгө оруулалтаар анх бий болж хөл дээрээ тогтсон бизнесийг эргүүлээд монголчууд худалдаж авах үйл явц энэ онд эрчимтэй явагдлаа. Тухайлбал, “Скайтел”, “Юнител” гээд үүрэн телефоны компаниуд үндэсний бизнесмэнүүдийн мэдэлд ирсэн.

Мөн Гэнэтийн ашгийн 68 хувийн татвар авах ёсгүй хэмээн эсэргүүцэн Монголын Засгийн газрыг олон улсын Арбитрын шүүхэд өгөөд ялагдсан

С.В.Паушокийн “Алтан Дорнод Монгол” компанийг саяхан монгол залуус дааж давшгүй өрнөөс нь айхгүй худалдан авлаа. Тэд өөрсдийн мэдлэг чадвар, менежментэд итгэн цөөнгүй жил “Муу нэртэй луу данстай” явсан “Алтан Дорнод Монгол”-ыг тодорхой хугацааны дараа салбартаа дээгүүрт жагсах үндэсний томоохон компани болгож чадна гэдгээ ч хэвлэлээр зарласан. Мөн энэ онд шил толь болсон оффисын зориулалттай тэнгэр баганадсан барилга өмнөхөөс олон ашиглалтад орсон ч цэцэглэж буй бизнесийн салбарын эрэлтийн хаана нь ч хүрэлцэхгүй байгаа билээ. Ам метр нь 40-50 ам.долларын үнэтэй ч байсан хүүе хаая гэхийн зууртгүй дуусаж, пиг дүүрчихээд байгаа. Энэ нь Оюутолгой, Тавантолгой гэсэн дэлхийд толгой цохих ордууд эдийн засгийн эргэлтэд орж байгаатай ч холбоотой нь мэдээж. Монголын огцом өсөлттэй эдийн засаг, уул уурхайн салбарын хөгжлөөс дотоодын гэхээсээ илүүтэй гаднын хөрөнгө оруулагчдын олох ашиг орлого арвин байгааг энд бас тэмдэглэхэд илүүдэхгүй биз ээ.

Эдийн засгийн өсөлт, инфляцийн гааралт, шинэхэн батлагдсан төсвийн халуун тоонууд манай шинэ дугаарын бас нэгэн чухал сэдэв болон орлоо. Үсрэнгүй хөгжил, их өсөлтийн тухай үнэн худал нь мэдэгдэхгүй зүйл ам уралдуулан ярих болсон энэ цагт ард түмний олонх нь учрыг нь олж хужрыг нь тунгаахыг хичээж буй. Тэгвэл манай сэтгүүлчийн бичсэн “Өсөлт өсөлт бас дахин өсөлт” гэсэн гарчигтай материалаас эдийн засгийн өсөлт, инфляцийн галзууралтай холбоотой эргэлзэж тээнгэлзэж, мэдэхийг хүсэж явдаг асуултдаа бодитой хариулт олж болох юм.

Түүнчлэн УМС компанийн эдийн засагч, Санхүүгийн зах зээлийн холбооны Боловсролын хорооны дарга Л.Бямбаа манай сэтгүүлийн “Шинжээч бичиж байна” буланд дэлхийн эдийн засаг, санхүүгийн 2011 оны байдлыг дүгнэж, ирэх оны төлөвийг шинжлэн бичсэн нь уншигч танд чухал ач холбогдолтой мэдээлэл байх болов уу.

2011 онд эдийн засгийн өсөлт, улсын хөгжилтэй холбоотой олон сайхан үйл явдал өрнөсөн бол 2012 он сав саалиа баялхаагаад айсуу. ■

Эрсдэл дагуулсан ирэх оны төсөв

“Сонгуулийн жил болохоор төсөв тэлж, зарлага нэмэгддэг”, “УИХ-ын гишүүн амласан бол заавал биелүүлдэг”, “Төсвийн орлого нэмэгдэж байвал зарлага мөн л өсдөг” гэв үү. Ийм жишгээр л ирэх 2012 оны төсөв УИХ-ын гишүүдийн бараг л 100 хувийн дэмжлэг аваад “ногоон гэрлээр” батлагдлаа. Цаг хугацаандаа ч төсвийн хэлэлцүүлэг амжив. Анх удаагаа төсвийг бараг нэг их наяд төгрөгөөр танасан түүхэн үйл явдал өнгөрсөн 11дүгээрсарын 30-нд зэрэг тохиож хамтарсан Засгийн газрыг магнайг тэнийлгэсэн. Яагаад түүхэн үйл явдал гэж, баярлаад байх төсөв биш хэмээн УИХ-ын гишүүн Р.Амаржаргал ихэд ундууцсан.Тэрбээр сонгуулийн дараа шинэ Засгийн газар 2012 оны төсөвт тодотгол хийж, хөрсөнд буулгана байх гэв. Харин Сангийн сайд С.Баярцогт “2012 оны төсөв нь 2008 онд байгуулагдсан хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг биелүүлэхэд чиглэсэн төсөв боллоо” хэмээн онцоллоо.

Гэхдээ анх долоон их наяд төгрөгийг давсан зарлагатай төсөв оруулж ирсэн нь хэний хүсэл сонирхол байв.Мэдээж төсөв бол УИХ-ын гишүүдийн өөрсдийнх нь бүтээл.“Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үндсэн зарчим, зорилго алдагдаж байна” хэмээн Монголын нээлттэй нийгэм форумын эдийн засгийн судлаач Н.Дорждарь манай сэтгүүлийн аравдугаар сарын дугаарт энэ тухай дэлгэрэнгүй бичсэн билээ.ОУВС, Дэлхийн банк аль аль нь Монгол Улсын 2012 оны төсвийн зарлагыг хараад, нүд нь орой дээрээ гарсан. Нэгдсэн төсвийн орлого 2012 онд 5.8 их наяд. Орлого саваа дүүргэж буй нь сайн хэрэг. Харин олсныхоо хэрээр үрээд байвал маргааш нь юугаар амьдрах вэ.

Зарлага

Ирэх он бол сонгуулийн жил. Дөрвөн жилийн өмнө амласан сонгуулийн амлалтаа биелүүлэхэд ердөө зургаахан сар үлдлээ. УИХ-д анх оруулж ирсэн улсын нэгдсэн төсвийн орлогыг 600 тэрбум, зарлагыг 900 тэрбум төгрөгөөр танан баталсан. Үүнийг

оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ. УИХ-д анх орж ирсэн нэгдсэн төсөв 2012 онд 7.2 их наяд төгрөгийн зарлагатай байсанд Монголбанк тэвдэж, эдийн засагчид учирч болох эрсдэлийг чамгүй тоочсон билээ. Энэ бүхний эцэст төсөв 6.3 их наяд төгрөгийн зарлагатайгаар “үүнээс цааш газар үгүй” гээд цэглэв. Нэг



Монголбанкны Ерөнхийлөгч Л.Пүрэвдорж дүгнэхдээ “Хэдийгээр УИХ төсвийн зарлагыг танаж, багасгасан ч төсөв том хэвээр. 2012 оны төсвийн бүтэц ирэх жилүүдийн хөгжилд тун таагүй хандлагыг үүсгэж байгаа” гэсэн юм.Түүнчлэн зарлагыг нэг их наяд төгрөгөөр бууруулбал инфляцийг нэг оронтой тоонд барина гэж Монголбанк мэдэгдээгүй болохыг ч нэмж хэлэв. Тэгэхээр төсвийн хэлэлцүүлэгт Төвбанкны байр суурь төдийлэн жин дараагүй бололтой.

Сонгуулийн төсөв гэсэн тайлбартай 2012 оны төсөв ирэх

үгээр хэлбэл, шинэ конторын барилга барих, тоног төхөөрөмж худалдаж авах, автомашины парк шинэчлэлд зориулах хөрөнгө оруулалтын зардлаас нийтдээ 200 орчим тэрбум төгрөгийг танаж бууруулсан. Өөрөөр хэлбэл ирэх онд 1,3 их наяд төгрөгийг шинээр хөрөнгө оруулалтад зарцуулахаар төлөвлөж, төсвийн 30 гаруй хувийг бэлэн мөнгөөр тараахаар боллоо.

“Хүний хөгжил санг”-ийн иргэн бүрийн 21000 мянган төгрөг ирэх оны тавдугаар сараар дуусгавар болох бөгөөд зургадугаар сард буюу сонгуулийн өмнөхөн 23 мянган ▶

▶ төгрөг тараахаар 2012 оны төсөвт суулгажээ. Нийтдээ 692 тэрбум төгрөгийг 2012 онд иргэдийнхээ гарт бэлнээр өгч, сонгуулийн амлалтаа 100 хувь биелүүлэхээр улс төрчид чармайж, харин эдийн засаг чардайж байгааг МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн захирал Ц.Даваадорж хэлсэн юм. Эдийн засагчид 2012 оны төсвийг ерөнхийдөө халамжаар гулгисан төсөв хэмээн цоллож буй. Төсвийн зарлага 6,3 их наяд төгрөг буюу ДНБ-ий 39 хувьтай тэнцэж байгааг ч тэрбээр учирласан.

Орлого

Төвбанкнаас сануулсаар байхад өндөр зарлагатай төсөв баталсны хариуцлагыг хэн хүлээхвэ. Одоогийн нөхцөлөө засаж явахгүй бол Грек, Италийн араас орж мэдэхийг Төвбанкны Ерөнхийлөгч мэдэгдсэн. Тиймээс мөнгөний хатуувтар бодлого баримтлахаас аргагүйд хүрснээ Л.Пүрэвдорж тайлбарласан. Угтаа төсвийн бодлого хатуу, мөнгөний бодлого зөөлөн байх нь үр дүнтэй болохыг мэргэжилтэнүүд ярьсаар байгаа боловч УИХ-ын гишүүд урсгал сөрсөөр.

Тогтворжуулалтын санд ирэх онд 322.4 тэрбум төгрөг нэмж хадгалахаар болжээ. Үүнээс илүү их хөрөнгийг нөөцлөх хэрэгтэй гэсэн Олон улсын байгууллагын зөвлөмжийг энэ удаад улстөрчид уландаа гишгэв. Ирэх оны төсөв Монголын эдийн засагт ямар бэлэг барих бол. Энэ оны арваннэгдүгээр сарын байдлаар улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 62 мянгад хүрч, өнгөрсөн оныхоос 22 мянгаар өссөн байна.

Тогтворжуулалтын санд төвлөрөх орлогын 44.1 хувь нь зэс, үлдэж буй 55.9 хувь нь нүүрсний үнийн өсөлтөөс хамаарах ажээ. Гэтэл зэс, нүүрсний үнэ дэлхийн зах зээлд хэрхэх нь одоогоор тодорхойгүй байна. Харин “Саалийн үнээ” хэмээн нэрийдэх Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ирэх онд 499,2 тэрбум төгрөгийг төсөвт нийлүүлэхээр болсон байна.

Төсвийн алдагдал 483,7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий гурван хувьтай

тэнцэж байгаа аж. МҮЭ-ийн Ерөнхийлөгч С.Ганбаатар “Улсын нэгдсэн төсвийн урсгал зардалд асар их мөнгө тавьж байгаа нь сонгуулийн мөнгө босгох гэсэн арга. Харин хөрөнгө оруулалтын зардалд олигтой мөнгө тавьсангүй. Сургуулийн барилга засах хөрөнгө оруулалт мөн үү. Нефть, зэс боловсруулах үйлдвэр баривал энэ жинхэнэ хөрөнгө оруулалт болно” хэмээн бухимдангуй ярилаа. Бодит эдийн засагт оруулж буй хөрөнгө оруулалт ажлын байр бий болгосон тохиолдолд төсвийн хөрөнгө оруулалт болж чаддаг ажээ.

Өндөр зарлагатай төсвийг баталахаас өмнө дэлхийн эдийн засагт эрсдэл ойрхон буйг Монголбанкны Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтсийн захирал С.Болд тэмдэглээд “Ихэнх улс ирэх оны төсвөө танаж, бүсээ чангалж байхад манай Засгийн газар ийм өндөр зарлагатай төсөв баталж байгаа нь илүү их эрсдэлийг эдийн засагт авчирч болзошгүй” хэмээн сануулсан билээ.

Цалингаа яаж үрэх вэ

Төрийн 150 гаруй мянган албан хаагчийн цалин ирэх онд 53 хувиар нэмэгдэнэ. Тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ ч мөн адил энэ хэрээр өснө. Дор бүрнээ л иргэд цалингаа хэрхэн үрэх тухай төлөвлөгөө зохиож байгаа байх. Ирэх оны төсвөөс 400 гаруй тэрбум төгрөгийг зөвхөн цалин тэтгэврийн нэмэгдэлд зарцуулахаар болсон нь амлалт хэрэгжиж буйн шинж. Боловсролын сайд ирэх онд их наяд 100 тэрбум 421 сая төгрөгийг салбартаа зарцуулна. Төсвийн нийт хөрөнгийн 20-иос доошгүй хувийг боловсролын салбарт зарцуулдаг байсан бол өдгөө 33 хувьд хүрчээ.


Харин Монгол Улсын иргэн болж төрсний үнэ цэнэ, утга учир болохуйц нийт иргэдэд 2012 оны хоёрдугаар сарын 1-ний дотор “Эрдэнэс-Тавантолгой” ХХК-ны нэг бүрийн 1000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нэг сая төгрөгийн хувьцааг эзэмшүүлэх гэнэтийн шийдвэрийг төрийн түшээд төсөв хэлэлцэх үеэр гаргаад ирлээ. Засгийн газрын

39дүгээр тогтоолд өөрчлөлт оруулж, аж ахуйн нэгжид олгох “Эрдэнэс Таван толгой” компанийн 10 хувь буюу нэг сая төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааг олгохоор тогтоов. Ингэснээр иргэн бүр 1072 ширхэг хувьцааг эзэмших эрхтэй боллоо. “Эрдэнэс-Тавантолгой” компанийн хувьцаагаа олон улсын зах зээл дээр нээлттэй арилжиж эхэлсэн эхний өдөр хүртэл хугацаанд Монгол Улсын иргэн өөрийн эзэмшиж буй хувьцааг зөвхөн Засгийн газарт нэрлэсэн үнээр нь худалдах бололцоогоор хангах зорилгоор 342 тэрбум төгрөгийг төсөвт багтаажээ. Иргэдийн хувьд нэг сая төгрөгөө бэлэн мөнгөөр нь авах, хувьцаа хэлбэрээр нь эзэмших хоёр сонголттой.


Ирэх оны дөрөвдүгээр сарын сарын 1-нээс 80 мянган төгрөгөөр, аравдугаар сарын 1-нээс 23 хувиар төрийн албан хаагчдын цалин нэмнэ. Тэтгэврийг ирэх оны эхний хагаст буюу гуравдугаар сарын 1, тавдугаар сарын 1-нд нэмэхээр болов. Мөн 2011-2012 төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургуулийн оны сургалтын төлбөрт 170 гаруй мянган оюутан бүрт 492 мянган төгрөгөөр тооцож дэмжлэг олгохоор болсон билээ.

“Төсвийн орлого учиргүй их нэмэгдэж, эдийн засаг өсөж байгаа нь Засгийн газар сайндаа бус зах зээлийн эрэлт дагасан нүүрсний олборлолт нэмэгдэж буй автоматоор эдийн засаг өсөхөд нөлөөлж байгаа”-г Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Б.Түвшинтөгс тайлбарласан. Ирэх оны төсөв эдийн засгийг эвдэж мэдэхийг эдийн засагчид хэлсэн ч улстөрчид ийн үл тоов.


Уул уурхайн салбарын томоохон татвар төлөгчдийн татварын орлого /тэрбум төгрөг/




ДНБ ба Нэгдсэн төсвийн нийт орлогын өсөлт



Уул уурхайн салбараас орох татварын орлого /бүтээгдэхүүний төрлөөр/



Уул уурхайн салбарын томоохон татвар төлөгчдийн татварын орлого /тэрбум төгрөг/



2012 онд төсвийн ерөнхийлөн захирагч нарт дор дурдсан төсвийг зарцуулахаар боллоо

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга	6,120.1
2.	Монгол Улсын Их Хурлын дарга	17,569.2
3.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	546.6
4.	Улсын дээд Шүүхийн Ерөнхий шүүгч	1,791.0
5.	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	19,085.0
6.	Улсын ерөнхий прокурор	17,437.4
7.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	1,313.3
8.	Монгол Улсын Ерөнхий Сайд	94,208.8
9.	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд	48,473.9
10.	Монгол Улсын Шадар сайд	107,078.4
11.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	50,774.6
12.	Гадаад харилцааны сайд	38,457.6
13.	Сангийн сайд	432,386.6
14.	Хууль зүй, дотоод хэргийн сайд	256,198.9
15.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	100,214.3
16.	Батлан хамгаалахын сайд	155,277.0
17.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	1,100,421.4
18.	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд	765,927.8
19.	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд	234,523.9
20.	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	674,834.3
21.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	239,187.4
22.	Эрүүл мэндийн сайд	484,117.4
23.	Төрийн албаны зөвлөлийн дарга	512.7
24.	Сонгуулийн ерөнхий хорооны дарга	19,387.8
25.	Хүний эрхийн Үндэсний комиссын дарга	437.7
26.	Монгол Улсын Ерөнхий аудитор	1,251.3
27.	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1,548.7
28.	Үндэсний статистикийн хорооны дарга	5,663.3
29.	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга	869.7
30.	Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн дарга	6,291.6
31.	Авлигатай тэмцэх газрын дарга	7,996.2

МЭНДЧИЛГЭЭ



Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал ялж, тусгаар тогтносон Монгол улс байгуулагдсанаар анх үүссэн таван яамны нэг бол Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яам билээ. Монгол Улсын Сангийн яам үүсэн байгуулагдсан цагаасаа эхлэн улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, төр, засгийн санхүү, эдийн засгийн шинэ бодлогод нийцүүлэн улсын сан хөмрөгийг арвижуулах, нийгэм-эдийн засгийн хөгжлийг түргэсгэх, ард иргэдийн аж байдлыг сайжруулах, улмаар гааль, татвар, санхүү, бүртгэлийн шинэ тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх үйл хэрэгт идэвхийлэн хүчин зүтгэж ирснийг энэ өдөр тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Санхүү, эдийн засгийн албаны 100 жилийн түүхийн зарим гол үйл явдлыг эдүгээ эргэн дурсахад бахархалтай байна.

Монгол Улс 1911-1921 онд төрийн тусгаар тогтнолоо сэргээж, улмаар улс гэрээ төвхнүүлэх, ялангуяа санхүү, эдийн засаг, аж ахуйгаа бэхжүүлэх үйл хэрэгт хүн бүр хүчин зүтгэж, улсын сан хөмрөгийг бүрдүүлэхийн төлөө бүхий л нөөц бололцоогоо шавхан дайчилж, төрийн гааль, татварын орлогын баазыг зохих ёсоор арвижуулж, газрын хэвлийн баялгийг түрээсэлж мөнгө, санхүүгийн хэрэгцээт эх үүсвэрийг бүрэн бус боловч хангах эхлэлийг тавьсан байна.

Монгол Улсын анхны ардчилсан хөгжлийн үеийн санхүү, эдийн засгийн үндэс суурийг 1921-1960 онд тавьж, Ардын засгийн газраас "Эдийн засгийн үндсэн бодлого" баримт бичгийг 1923 онд баталж, түүнд хувьсгалын эхний жилүүдэд баримтлах санхүүгийн бодлогыг тодорхойлсон байна. МОНГОЛ УЛСЫН АНХДУГААР ҮНДСЭН ХУУЛИЙГ 1924 онд баталж, улсын ба орон нутгийн төсөв зохиох, батлах, түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тогтоосон төдийгүй улсын төсвийг 1923 оноос, орон нутгийн төсвийг 1927 оноос эхлэн зохиох болсноор улсын төсвийн нэгдсэн тогтолцоо бүрэлдэж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажлыг сайжруулах эхлэл тавигджээ.

Улмаар 1940 онд Монгол Улсын хоёрдугаар үндсэн хуулийг баталж, улс орны нийгэм, эдийн засгийг төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх эрх зүйн үндсийг хуульчилсан байна. Улс ардын аж ахуйн салбаруудыг 1941 оноос эхлэн нэг жилийн төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх журамд шилжүүлж, улс, хоршооллын үйлдвэр, аж ахуйн газар бүр үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөө зохиож, улмаар санхүү, төлөвлөгөөний төв байгууллагад хургуулэн хянуулах замаар улсын төсөв, зээл, мөнгөн эргэлтийн төлөвлөгөөний төсөл зохиож эхэлсэн нь ихээхэн дэвшил авчирсан байна.

Монгол Улс 1960-1990 онд олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож эхэлсэн хөгжлийн үе байлаа. Монгол Улсын гуравдугаар үндсэн хуулийг 1960 онд баталж, улсын санхүү зээллэгийн бодлогыг эх орны эдийн засгийн хүчин чадлыг байнга зузаатгах, социалист өмчийг өсгөн бэхжүүлэх, социалист соёлыг хөгжүүлэх, хөдөлмөрчдийн аж байдлыг дээшлүүлэхэд чиглүүлж, улсын санхүүгийн төлөвлөгөөг улс ардын аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөөнд захируулан улсын төсвийг жил бүр хуульчлан баталж иржээ. Монгол Улс 1961 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын, 1962 онд Эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн бүрэн эрхт гишүүн болсноор олон улсын байгууллага, гадаад орны санхүүгийн тусламж дэмжлэг авах өргөн боломж нээгдсэний ач үрээр эх орны их бүтээн байгуулалт 1960-аад оноос эрчимтэй явагдаж, шинэ хот, тосгон, үйлдвэр, уурхай, нийгэм-соёлын байгууллага, орон сууцны олноор барьж байгуулсан байна.

Монгол Улс 1990-ээд оноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны гишүүн болсноор олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудтай санхүү, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар хөгжлийн шинэ үе шатыг бүтээн байгуулах эхлэл тавигдлаа. Дэлхий дахины хөгжлийн нийтлэг чиг хандлагад нийцүүлэн МОНГОЛ УЛСЫН АРДЧИЛСАН ШИНЭ ҮНДСЭН ХУУЛИЙГ 1992 онд баталж, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн харилцааны эрх зүйн суурь үндсийг цоо шинээр томъёолон хуульчилсан явдал хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засгийн баталгааг бэхжүүлэхэд томоохон дэвшил авчирлаа.

Монгол Улс олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудын хөгжлийн хамтын ажиллагааны тусламж дэмжлэг хийгээд эх орны иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын шаргуу хөдөлмөрийн үр дүнд зах зээлийн эдийн засгийн харилцааны шилжилтийн хүнд бэрх он жилүүдийг амжилттай даван туулж, эдүгээ тогтвортой, эрчимтэй хөгжлийн үе шатыг бүтээн байгуулах өргөн боломж нээгдэж байна.

Санхүү, эдийн засгийн албаны хөгжлийн зуун жилийн түүхийг бүтээлцсэн, шинэ эриний эхлэлийг тавилцсан ахмад, дунд, залуу үеийн төлөөлөл болсон ажилтан, албан хаагчид болон тэдгээрийн гэр бүл, төрийн анхны таван яам байгуулагдсаны 100 жилийн ойн баярын мэндийг хүргэж, аз жаргал, эрүүл энх, хөдөлмөр бүтээлийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Монгол Улсын сан хөмрөг улам арвижин дэлгэрэх болтугай !

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд С.Баярцогт

Оны онцлох үйл явдал

Монголын эдийн засгийн 2011 оны онцлох таван үйл явдал

Монголын эдийн засагт 2011 онд тохиосон онцлох үйл явдлуудаас “Mongolian Economy” сэтгүүл, Монголын үндэсний олон нийтийн телевизийн Нийгэм, эдийн засгийн нэвтрүүлгийн албатай хамтран тавыг нь онцлон нэрлэж байна.

Байхгүйг бүтээх, байгаагаа өөд татах хөгжлийн галт тэрэг

Туулайн жилийн хаврын адаг сард Монгол Улс Хөгжлийн банктай болов. Хөгжих гэж яарч буй бидний хувьд хөгжлийг түргэвчлэх түлхэц болох тусгайлсан банктай байна гэдэг түүхэн үйл явдал. Хөгжлийн банк гэдэг нь монголчуудын хувьд нэр төдий дуулсан шинэ ойлголт, шинэ зүйл байлаа. Гэхдээ л бид хамтдаа чадна гэсэн Ерөнхий сайд С.Батболдын үг биелэлээ олов. Хөгжлийн банкиг ирэх цагийн хөгжлийг ойртуулна гэдэгт иргэд итгэлтэй байна.

2011.05.12. Монгол Улс албан ёсоор Хөгжлийн банктай болсноо олон улсад зарласан юм. Засгийн газрын 2010 оны 195 дугаар тогтоол ийн хэрэгжиж, төрийн ачаа ялимгүй хөнгөрлөө. Гэлээ ч үүрэг хариуцлага өмнөхөөсөө бүр ч нэмэгдэв. Хөгжлийн банкны удирдлагын багаар БНСУ-ын Хөгжлийн банкныхан ажиллахаар болж, тус банкны тэргүүн дэд ерөнхийлөгчөөр Л.Болормааг томилсон билээ. Байхгүйг бүтээх, байгаагаа өөд нь татах хөгжлийн галт тэрэг ийнхүү хөдөллөө.

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, томоохон төслүүдэд оновчтой хөрөнгө оруулалт хийх, эдийн засгийн өсөлтийг дэмжих, хөгжлийг хурдасгах улмаар эх орныхоо олон улсад өрсөлдөх чадавхыг сайжруулах

нь Хөгжлийн банкны өнөөгийн зорилт. “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр”, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”, “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор” зэрэг томоохон бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөр хэрэгжих эсэх нь Хөгжлийн банкнаас шууд шалтгаална. Үүрэг хариуцлага, итгэл найдварт өлгөйдүүлсэн Хөгжлийн банкны утга ирээдүй, цогцлоон

бүтээх их ажил урагштай байна гэдэгт итгэлтэй байгаа учраас эдийн засаг, улс төр, нийгмийн салбарынхан 2011 оны онцлох үйл явдлын нэгээр нэрлэсэн юм.



2. Тавантолгой ба хувьцаа

Монголчууд 2011 онд төрөл бүрийн эрдэнэс хэвлийдээ тээсэн газар шорооны эзэн гэдгээ илүүтэй мэдрэв. Өмнөговь аймгийн Цогтцэций сумаас баруун урагш 15 км-ийн зайд говийн элгэн дээр Монгол Улсын стратегийн чухал орд болох Тавантолгой бий. Энэ ордын эзэн нь Монголын иргэн бүр мөн гэсэн шийдвэрийг хамтарсан Засгийн газар 2011 оны гуравдугаар сарын 31-нд мэдэгдэж, иргэн бүртээ хувьцаа олгов. Монгол хүн бүрийг хувьцаатай болгохын сацуу таван тивийн ашигт малтмалын 16 компани, консорциумыг өрсөлдүүлсэн 6,42 тэрбум тонн нүүрсний нөөцтэй Тавантолгойн орд бөлгөө. Голт зүрхэндээ хүртэл нүүрсээ хав дарах өмнийн говь Монголын үүц. Үүцээ задалж, иргэн бүртээ 536 ширхэг хувьцаа тараасан нь яахын аргагүй оны онцлох үйл явдлуудын нэг байлаа. Нарийвчилсан тоогоор манай улсад хоёр сая 796 мянга 341 иргэнд Тавантолгойн 10 хувь буюу 1,5 тэрбум ширхэг хувьцаа ноогдсон. 2012 оны төсөв батлах үеэр аж ахуйн нэгжид олгох “Эрдэнэс Тавантолгой” хувьцааны 10 хувийг иргэдэд олгохоор тогтож, нийтдээ 1072 хувьцаа та, бидний нэрийн дансанд байршихаар болов.



Үүнтэй зэрэгцэн Тавантолгой төслийн бэлтгэл ажил шувтарч, сонгон шалгаруулалтын дүнд хэзээ тодрохыг хүлээж байна. Дэлхийд толгой цохих Тавантолгой төсөл урагшилсаар. ▶▶

3. Монголын хөрөнгийн бирж шинэчлэлийн аянд мордлоо

Монголын хөрөнгийн бирж Лондоны хөрөнгийн биржтэй хамтран ажиллах гэрээнд 2011 оны дөрөвдүгээр сарын 7-нд гарын үсэг зурж, хөрөнгийн зах зээлийн шинэ хуудсыг нээв. Монголын хөрөнгийн бирж 1990-ээд оны муу сургамжтай ягаан, цэнхэр тасалбараас өөр хувьцааны талаар ойлголт төсөөлөл маруухантай монголчуудын хөрөнгийн захын мэдлэг мэдээллийг сайжруулах, өөрийн үйл ажиллагаагаа шинэ шатанд гаргахаар ийн ажиллаж байгаа нь эдийн засгийн онцлох үйл явдал боллоо. Дэлхийн хөрөнгийн зах зээлд тэргүүлэгч 200 гаруй жилийн туршлагатай Лондоны хөрөнгийн бирж 20-иодхон жилийн хөгжлийн түүхтэй Монголын хөрөнгийн зах зээлийг “тоов”. Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх хэтийн зорилго тээн өдгөө тэд хамтран ажиллаж байна.

Лондоны хөрөнгийн биржийн ерөнхийлөгч Хавер Роле “Бид Монголын хөрөнгийн биржтэй хамтран ажилласнаар үнэт цаасны арилжаа явуулах орчин үеийн цогц системийг нэвтрүүлнэ. Улмаар энэхүү хамтын ажиллагааны дүнд



танай орны хөрөнгийн эрх зүйн орчин, дэд бүтэц, техник технологи, боловсон хүчний чадавх олон улсын стандартад хүрэх учиртай. Мөн Улаанбаатар-Лондон-Торонтогийн 24 цагийн арилжааны бүсэд холбогдон, олон улсын санхүүгийн зах зээлд гарах боломжийг нээнэ” хэмээн амласан.

4. Нүүрс баяжуулах үйлдвэр бас цахилгаан станц

Анхны хэмээх тодотголтой нүүрс баяжуулах үйлдвэр өмнийн говьд сүндэрлэж, энэ оны зургадугаар сард үйлдвэрийн нээлтийн туузыг хайчилсан. “Энержи Ресурс” компанийн “Ухаа худаг” төслийн хүрээнд ашиглалтад орсон дээрх баяжуулах үйлдвэрийг эдийн засгийн онцлох үйл явдлаар нэрлэж байна. Орчин үеийн дэвшилт технологийг дотоодын тэргүүн туршлагатай хослуулсан гэдгээрээ нэлээд онцлогтой. Баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад 20 гаруй туслан гүйцэтгэгч компанийн 600 гаруй ажилтан гар бие оролцсон байна. “Энержи ресурс” компанийнхан 2011 онд өмнийн говьд баяжуулах үйлдвэр бариад зогссонгүй “Ухаа худаг” уурхайн төслийн хүрээнд 18 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц өнгөрсөн намар ашиглалтад орууллаа. Усгүй говьд цахилгаан станц барьсан нь оны онцлох үйл явдлаар тодрохоос аргагүй. “Ухаа худаг” цахилгаан станцыг 80 гаруй компанийн 1500 орчим инженер, техникийн ажилтан



25 сарын турш ажиллаж байгуулсныг онцлон тэмдэглэе.

5. Эдийн засаг өсөж, Оюутолгойн бүтээн байгуулалт эрчимжлээ

Оюутолгой гэсэн энэ нэр дэлхийд брэнд боллоо олны анхаарлын төвд буй. Энэхүү томоохон ордын хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурснаас хойш хоёр жил, гэрээ хүчин төгөлдөр болсноос даруй жил хагасын хугацаа өнгөрчээ. Дэлхийн хэмжээний Оюутолгой ордын их бүтээн байгуулалт шуударсныг өнөө харахад бахдам. Дэлхийд хоёрдугаарт жагсах зэс алтны уурхайг ашиглалтад оруулахын тулд “Оюутолгой” компани өдөр бүр долоон сая ам.долларын бараа, үйлчилгээ худалдаж авч байна. Өнөөдөр “Оюутолгой” компанийн ханган нийлүүлэгч гэсэн “шошго”-той компанийн тоо 2500 давжээ. Өдгөө уурхайн бүтээн байгуулалтын ажил 50 хувьд хүрчихсэн явна. Оюутолгойд нисэх онгоцны буудал барих ажлыг Монголын гурван ч компани гүйцэтгэж байна. Тус төсөл одоогоор өдөрт дөрвөн тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж байгаа нь манай гадаад худалдаанд урд өмнө таамаглаж байгаагүй өөрчлөлтийг авчирч байна.

Уг ордын үйлдвэрлэл эхлэх үед жилдээ 450 мянган тонн зэс, 330 мянган тонн алт олборлох боломжтой уурхайг барихаар Өмнөговь аймагт 18 мянга гаруй иргэн ажиллаж



байна. “Оюутолгой” компанийн ерөнхийлөгч Камерон Макрей 2013 онд уурхайн үйлдвэрлэлийн ажил эхлэх үед арван ажилтан тутмын ес нь монгол хүн байна гэдгийг онцолсон.

Монголын эдийн засгийн гуравны нэгийг 2020 он гэхэд бүрдүүлэх төлөвлөгөөтэй байгаа Оюутолгой өнгөрсөн хугацаанд 2,9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн нь манай эдийн засгийг 17 хүртэлх хувиар өсөхөд нөлөөлсөн талаар судлаачид ярьдаг билээ. ■



Фотог Б.Бямба-Очир

Өрхийн төсөв

Гутланд уяатай төсөв



Б.Энхцэцэг

Жижигхэн шавар байшинд аав, ээж дэрсхэн хоёр хүү, охин тавуул амьдарна. Гутлын шар цавуу, нүүрсний үнэр холилдон толгой өвтгөх авч өөхөн тосны хурц үнэр, ээжийн халуун боорцгийг саванд шидлэх дуу, хар цайны буцлам ааг бүгд цаанаа л нэг сэтгэлд дулаан. Зай л гарвал хоолны ширээ гэрийн эзэн, гутал хоёрт “үйлчилж”, шороо тоосондоо хучигдсан ажлын талбар болон хувирна. Амьтай байсан бол энэ ширээ “Хэзээ тэр яриад байдаг ажлын тусдаа өрөөтэй болж намайг гутлын цавуу, шороо тоос, алх, хадааснаас салгаж амрах юм бол доо” гэж гомдол мэдүүлэх нь лавтай.

Аав нь дунд хүүгийн хамт өнөөдөр таван гутал хийх ёстой. Ээж нь гутлын буянаар олж буй хэдэн бор төгрөгөө чамлалгүй хэрхэн хоол хүнсэндээ хүргэх вэ гэдэгт тоо бодно. Том хүү нь барилга дээр ажиллаж эцэг, эхдээ тус болохыг хичээж яваа. Харин отгон охин нь дэвтэр үзэг, дэлгүүрийн лангуу хоёртой нөхөрлөж, турьхан биендээ ахадсан туршлагатай худалдагч бас тэргүүний онц сурлагатан. Монгол гэрээр зүйрлэн яривал энэ айл таван тулгуур баганатай юм.

Гуталчин бас барилгачин

Гутал хийнэ гэдэг их учиртай. Хэвэнд оруулах нь тун амаргүй. Хүүхдийн гуталд размераас шалтгаалан 20-30 дециметр /дм/ монгол арьс орно. Нэг дм арьсыг 180-200 төгрөгөөр худалдаж авахаас гадна дотор ул, утас, улалгаа, хадаас, уллагааны гадна резин, цавуу, наалт зэрэг материал шаардагддаг. Өглөө эртээ гутлаа исгэнэ, оёно, наана, хэвэнд хийнэ, цахилгаан үрүүлд барьж өөг нь авна... энэ мэтчилэн ажил хөвөрсөөр нэг мэдэхэд цагийн зүү 21.00-ыг зааж, таван “хөөрхөн” гутал төрдөг. Аавынх нь “Эзэн нь мөнх эд нь хэврэг байгаарай” хэмээх ерөөл гутлуудад шингэж, бяцхан эздээ хүлээнэ. ▶▶



► Хүүхдийн гутал ойролцоогоор зургаан мянган төгрөгт багтаж гардаг бөгөөд Ганхуягийнх тус бүрийн үйлдвэрээс гарсан үнэ дээр 2000 төгрөг нэмж бөөний үнээр худалддаг байна. Үүний сацуу танилуудын хүсэлтээр сардаа арав гаруй том хүний гутал хийх нь ч бий. Басхүү завсраар нь улны резин наах, өсгий янзлах зэрэг гарын үзүүрээр хийх гутал засварын ажил мундахгүй. Том хүний гутал илүү ашигтай ч хүүхдийн гутал, захиалга сайтай бас хийхэд харьцангуй хялбар байдаг аж. Хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх тусам эднийх гутлынхаа үнийг нэмэх болдог ч худалдан авагчдын зүгээс дургүйцэл илэрхийлэх нь ойлгомжтой учраас үнээ нэмж зүрхлэхгүй байгаа аж. Өвлийн улиралд гутлын борлуулалт харьцангуй сайжирдаг байна. “Зүгээр суувал хоосон хононо шүү дээ. Ажил хийвэл ам тосдоно гэдгээр дулаан цагт зуны шаахай, ботинк хийх, айлын пийшин, байшин барих гэх мэт ямар ч байсан ажилгүй налайж суух үе олддоггүй юм” хэмээн өрхийн тэргүүн, гутал үйлдвэрлэгч Ч. Ганхуяг гуай инээмсэглэл тодруулан хэлж байсан. Үйлдвэрлэлийн ослоор баруун гарынхаа гурван хурууг алдсан тул өнөөдөр түүний “цахилгаан гагнуурчин” хэмээх мэргэжил үнэлэмж өндөртэй ч тэрбээр ажлын чадамжгүйд тооцогддог байна. Гэвч 10 гаруй жил айлын пийшин болон байшин барьж, бас гутлаа урласаар явна.

Олох бас үрэх гэж зовдог

Эхний хэдэн жилд барааны зах дээр өрхийн үйлдвэрлэлийн гутлаа борлуулахаар зогсдог байсан Л. Отгонжаргал буюу Ганхуягийн эхнэр өнөөдөр хөдөө, орон нутагт бүр Тувад хүртэл бараа зөөн борлуулдаг наймаачдад гутлаа бөөндчихдэг болжээ. Тиймээс ч тэрбээр Яармагийн зургадугаар хорооны Нүхтийн нэгдүгээр гудамжны зургаан тоотод байрлах гэрийнхээ ойролцоо барааны лангуу ажиллуулах цаг завтай сууна. Ганхуягийнх анх 300 мянган төгрөгийн банкны зээлээр үйлдвэрлэлээ эхэлж байсан бол

одоо хоёр сая хүртэл төгрөгийн зээлээр бизнесээ явуулж байна. Чамлахааргүй орлоготой юм байна даа гэж бодвол бас ч тиймгүй. Өрхийн төсвийн орлогыг 100 хувь бүрдүүлдэг гутлын материалд нь орлогын ихэнх нь зарцуулагддаг. Эхнэрийнх нь тооцоолсноор гэр бүлийн сарын орлого 500 мянган төгрөг. Энэ өрхийн сангийн сайд өнөөдөр өрхийн төсвөө чамгүй сайн бодчихдог нэгэн бололтой.

Банкны найдвартай харилцагч байхын тулд сар бүр зээлийн эргэн төлөлт хэлбэрээр 150 мянган төгрөгийг яг цагт нь тушаана. Ингэхээр мөнөөх хоол хүнс, нүүрс түлээ, гэрэл цахилгаан гэх мэт ар араасаа хөврөх хэрэглээний зардалд ердөө л 350 мянган төгрөг үлдэнэ. Өөрөөр хэлбэл, том багагүй эрвийх дэрвийхээрээ зүтгэж байгаа ч сарын хэрэглээнд зарцуулах 350 мянган төгрөг гэдэг бол гэр бүлийн гишүүдээс нэг нь л ажил эрхэлж байгаа хэмжээний орлоготой гэсэн үг. Яаж ч хэмнээд 250,000 төгрөгийг сарын хүнсэндээ өлхөн зарцуулдаг тухай Л.Отгонжаргал ярьж байна.

Таван ам бүлийн хүртэж буй эх орны хишиг 105 мянган төгрөг тэдний хагас сарын хүнсийг даадаг. Гэрийн эзэгтэй төсвөө зөв захиран зарцуулахаас гадна өмнөх сард хэтрүүлсэн зарлагаа энэ сард нөхөх ёстой. Тэгэхийн тулд өдөрт хоёр талх идэж бийлэгжүү загнадаг байсан бол хэсэг хугацаанд нэгийг иднэ гэсэн үг л дээ. Өрхийн төсөвт ахиу жин дардаг хэрэглээ нь мах, гурил. Хүний хань, хүүхдийн ээж болсоор 20 жилийн нүүрийг үзсэн Отгонжаргал яаж ийгээд асуудлыг шийдэх арга чарга сүвэгчилнэ. Тухайлбал, нэг кг мах авах үнээр таван кг дотор эрхтэн бас хонины толгой авч болдог аж. За тэгээд мөнгөө хэмнэж, ухаанаа гарган байж авсан харьцангуй хямд үнэтэй “махаараа” таван цулын шөл хийж, гэр бүлийнхээ хөдөлмөрч гишүүдийн ядаргааг засна. Ажилсаг эзэгтэйн хямд төсөр хоолны жор дуусаагүй. Хонины толгойг төмс, ногоогоор амталж, сайхан зоог бэлтгэдэг байна. Дотор эрхтний өөхнөөс гамбир, боорцог хайрах тос гаргаад авчихна. ►

► Хэмнэнэ гэдэг ухаан, гамнана гэдэг хүмүүжил

Энэ гэр бүлийн өрхийн төсөвт хүн болгон өөрийн хувь нэмрээ оруулдаг. Том хүү Энхтүвшин тоглож наадахыг урьтгал болголгүй зуны амралтаараа “Барс” захад хүнсний бүтээгдэхүүн вагоноос буулгаж, өөрийнхөө болон дүү нарынхаа хичээлийн хэрэглэлийг бэлтгэжээ. Батлан хамгаалахын их сургуулийн оюутан хүү нь одоо ч хичээлийнхээ зав чөлөөгөөр ажил хийдэг. Тэргүүний сурагчийн байр суурин дээрээ бат зогсдог тавдугаар ангийн бага охин нь гэр орны ажилд тусалцахаас гадна ээжийнхээ ажиллуулдаг барааны лангууг түүний эзгүйд чамгүй сайн авч явдаг нэгэн. Эцгийгээ дууриасан гарын ур дүй сайтай дунд хүү Ганбаяр нь аавынхаа сайн туслагч нь. “Аав аа би хийе, би чадна аа л гээд байна шүү дээ” хэмээн эцэг, эх хоёр нь хүүгийнхээ талаар сайрхан ярьсан. Ганбаяр ирэх жилээс гутлын үйлдвэрлэлийг ном ёсоор нь заалгах болсондоо тун ч их баярлаж байгаа. Аав нь хаана байна хүү тэнд л гүйж явна. Ганхуяг гуай дунд хүүгээ зундаа айлын байшин засах, ханан пийшин өрөх гэх мэт ажилд байнга авч явж тоосго зөөж, шавар зууруулахаас өгсүүлээд гар хөлийн үзүүрт зарна. Аав, хүү хоёр хийсэн ажлынхаа үнэ хөлсийг өндөр хэлэхээсээ нэрлэхдэг гэх үү дээ. Нэрлэх гэх нь ч хаашаа юм үнийн хөөстэй нийгэмд жинхэнэ хөдөлмөрөөрөө амьдрах гэж зүтгэх ямар хэцүүг Ганхуяг яс махаараа мэддэг учраас ханын пийшин өрүүлж, байшингаа янзлуулсан хүмүүст үнэрхэж чадахгүй дунджаар 70 мянган төгрөгийн ажлын хөлс л авдаг байна.

Ээж, аавынхаа хөдөлмөрийг хайрладаг хүүхдүүд нь түрүү жилийн өвлийн хувцас гутлаа гамтай хэрэглэсэн тул энэ жил өвлийн хувцас гэж ээжийгээ зовоохгүй. Ээж нь хятад хувцаснаас илүү Герман, Японы комиссын барааны дэлгүүрээс чанартай чийг татдаггүй гутал хувцас авч өгдөг байна. Том хүү Энхтүвшин нь цэргийн сургуулийн оюутан тул жилд нэг удаа дүрэмт хувцасны 150 гаруй мянган төгрөг сургуульдаа тушаагаад л мөр бүтэн алхдаг.

“Болно доо болно”

Шинэ жил, Цагаан сар, Улсын баяр гээд ер нь ямар л тэмдэглэлт ой тохионо хэн хүнгүй яаж ийж байгаад ер зээл тавиад ч болтугай сайхан тэмдэглэн өнгөрөөхийг хичээдэг. Ганхуягийнх шинэ жилийг 50-60 мянган төгрөгөөр сүржин биш ч бас даржин бус тэмдэглэдэг. Энэ жил гэхдээ инфляцийн өсөлт өндөр байгаа тул шинэ жилийн баярт дээрхээс илүү мөнгө зарцуулж магадгүй юм.

Гурван сайхан хүүхдийн эцэг эх болсон энэ хоёр хүн ирэх жилийн намар хүүхдүүдээ сургуульд орохоос нь өмнө компьютертэй болгоно хэмээн төлөвлөжээ. Хэрвээ ингэж чадвал хүүхдүүд нь интернэтийн газруудад мөнгөө үрэхгүй даалгавраа гэртээ цаг тухайд нь хийх боломж бүрдэнэ гэж үзэж байгаа юм. Тавдугаар ангийн охин Отгончимэгт хүртэл бие даалт хийхэд нь компьютер хэрэг болдог байна. Харин гэр бүлийн эзэд үүнээс өмнө хүүхдүүдээ эрүүл, ая тухтай орчинд амьдруулахын тулд тусдаа ажлын байртай болох чин хүсэл эрмэлзлэлийг тээн амьдарч байна. Отгонжаргалын хувьд гэр бүлийн орлого нь хоёр дахин өсөж сая төгрөгт хүрвэл хангалттай биш ч дутагдах гачигдахын зовлонгүй амьдрах боломжтой гэнэ. Гэрийн эзэгтэйн хэлдгээр тэд “Болно доо болно” гээд л амьдарч байна. Ирээдүйд илүү гоёмсог гутал хийх тоног төхөөрөмж бүхий жижиг, дунд үйлдвэртэй болж хоолны ширээгээ “амраах нь” эдний бас нэг мөрөөдөл. Ганхуягийнх шиг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх гэж бор зүрхээрээ зүтгэж буй хэдэн мянган гэр бүлд улсаас атга тус, чимх дэмжлэг л хэрэгтэй болов уу. ■

Инфляци, ДНБ-ий өсөлт

Өсөлт бас дахин өсөлт

Б.Баяртогтох

Хуучин цагт байгаль нь өгөөжтэй орнууд хамгийн баян байлаа

Өнөө үед хүн нь илүү бүтээлч улс орнууд хамгаас баян ажээ

Хенри Бокль

Өсөлт бас дахин өсөлтийн тухай ярьсан хоног хугацаа улиран одож, 2012 онтой золгох нь. Өглөөний утаа, оройн автомашины түгжрэл гээд их хотын түмэн асуудал ар араасаа хөвөрсөөр. Ханан дахь хуанлийн хуудас арванхоёрдугаар сарын 31-нийг заах мөч ойртсоор байна. Баярын ширээгээ хэрхэн гоёх тухай эзэгтэй нар одооноос бодож, багачууд хэнийх том бэлэг өгөх бол гэж догдолж сууна. Харин Ерөнхий сайд маань Монгол Улс үсрэнгүй хөгжлийн гараанаас хөдөлж байгаа тухай зурагтын мэдээгээр онцолж харагдах нь олшров. Тэрбээр улс орны амьдралд их өөрчлөлт гарахыг тэмдэглэлээ. Эдийн засгийн өсөлт буюу гэнэтийн их орлого бидний амьдралд хэрхэн нөлөөлж, өрхийн төсөвт ямархан гэгээ татуулах бол оо.

“Хүчит шонхор” худалдааны захад хонины мах кг нь 3100-3500 төгрөгийн хооронд хэлбэлзэж байна (өнгөрөгч арваннэгдүгээр сарын 27-ны байдлаар). Уг нь өдийд махны үнэ хямдардаг ч энэ жилийн хувьд өмнөх жилүүдийнхээсээ ч илүү үнэтэй байгаад иргэн миний бие төдийлэн бухимдсангүй. Он гараад орлого нэмэгдэнэ гэсэн таатай хүлээлттэй байгаа учраас тэр. Килограмм махны борлуулалтад хэрэглэгчийн хүлээлт нөлөөлж, худалдагч нар магнай тэнэгэр, толгой гэдгэр үлдлээ. Үр дүнд нь инфляци “хөгжиж”, иргэд дахиад л үнийн өсөлттэй нүүр тулна. Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдорж ч нийлүүлэлтээс давсан илүүдэл эрэлт инфляцийн өсөлтийг өдөөж байгаа тухай ярьсан. Мөн орон сууц, автомашины үнэ өснө гэсэн үнийн цуурхал эдийн засгийн өсөлтийг илүүдэл зарлага болгож, иргэдийн хэтэвчийг холгож байгаад эдийн засагчид санааширч сууна. Хүсэж мөрөөдсөн төсвийн орлого, эдийн засгийн өсөлт гэдэг чинь “үнийн өсөлт ноёрхохыг” хэлдэг юм уу гэж эзэгтэй нар асууж байна. Гэтэл өсөлтийг бодитой байлгахын тулд инфляцийг нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй байлгах нь төгрөгт итгэх итгэлийг хадгалж болохыг Төвбанкны ерөнхийлөгч улстөрчдөд сануулсан. Өсөлтийг инфляци болгохгүй, улс орны хөгжилд шингээж үлдээхэд толгой гашилгах нь зөвхөн Монголбанкны үүрэг биш байлтай.

Манай ДНБ-ий өсөлт энэ оны хоёрдугаар улиралд 17,3 хувьтай гарсан. Ирэх онд бүр 20 хувьд хүрнэ гэсэн мэргэжлийн байгууллагуудын урьдчилсан таамаг ч бий. Хэдийгээр өндөр тоо харагдаж байгаа ч энэ нь бодит өсөлт биш гэдэгтэй олон эдийн ►



гэвэл үгүй л бололтой.

Эдийн засгийн өсөлтийг хэмжих зорилго нь үйлдвэрлэлийн өсөлт болохоос хөгжлийн хэмжүүр биш ажээ. Харин үйлдвэрлэл жигдхэн хөгжөөд, орлого нь зарлагаа давж, түүнийг тэгш хуваарилсан тохиолдолд л иргэд өсөлтийн үр шимийг тэгш мэдрэх гэнэ. Ц.Батсүх багш “Уул уурхайн орлогыг иргэн бүр адил тэгш хүртэж байна уу, гэвэл үүн шиг худлаа зүйл үгүй байх. Орлогыг тэгш бус хуваарилж байгаа учраас ард түмний амьдрал сайжрахгүй. Эдийн засгийн өндөр өсөлт хүн амын магадгүй 10-хан хувьд нь асар хүчтэй мэдрэгдэж, үлдэж буй 90 хувьд нь ядууруулах зэвсэг болж хувирдаг” гэв. Тэгвэл хэн орлогыг тэгш бус хуваарилаад байна вэ?

Эдийн засагт их хэмжээний хөрөнгө оруулчихсан хүнд өсөлтийн ихэнх хувь нь ногддог. Харин эрх мэдлийг дагаж хөрөнгөтэй болсон хүнд эдийн засгийн өсөлт мэдрэгдэнэ. Тухайлбал, эдийн засаг 20 хувь өсөхөд ийм эрх мэдлээр хөрөнгөтэй хүний амьжиргааны түвшин бараг 30 хувиар өсдөг болохыг Ц.Батсүх онцоллоо. Үүнээс гадна эдийн засаг өсөхөд хүн ам, хөдөлмөрийн өсөлт, технологийн дэвшил нөлөөлдөг байна. Тэгвэл, манай улсын хүн ам эдийн засаг нь 20 хувиар өсөхөөр хэмжээнд очтолоо олуулаа болж чадсан уу. Хөдөлмөрийн бүтээмж дээшилсэн үү?

“Манай улсын эдийн засгийн 20 хувийн өсөлт бол хөрөнгө оруулагч хэдэн нөхрийг дэмжиж байгаа болохоос ард түмний амьдралд нөлөөлөхгүй” хэмээн Ц.Батсүх багш шулуухан дүгнэсэн. Тэгвэл эдийн засгийн өсөлтийг иргэдэд наалдуулж, бодитой байлгахын тулд хэрхэх ёстой вэ?

“Иргэдийн худалдан авах чадвар дээшилж байгаа нь нэг талаасаа эдийн засгийн өсөлт юм шүү дээ” гэж МУИС-ийн ЭЗС-ийн багш Л.Оюунтайлбарласан юм. Цалин, тэтгэвэр нэмэгдэж буйг эерэг талаас нь харвал эдийн засгийн өсөлтийн үр дүн гэж үзэж болох нь. Өсөлтийн үр шимийг илүү хүртэх хүмүүст “Нарантуул” захын бизнес эрхлэгчдийг нэрлэж болох аж. Гэхдээ орлого нь нэмэгдсэн иргэд “Нарантуул” худалдааны төвийг тоохгүй байх талтай. Өөрөөр хэлбэл, тэд чанар, брэнд хөөж их хотын үнэтэй дэлгүүрүүдээр саатна. Харин эдийн засгийн өсөлтийн үр дүнд бараа бүтээгдэхүүний эргэлт сайжирдаг гэдэг онолоор бол гадаа гандаж, бор зүрхээрээ болгож яваа олон хувиараа хөдөлмөр эрхлэгч “Нарантуул” захын наймаачдад шууд бус дамаар нөлөөлнө гэсэн үг ажээ. ▶

▶ засагч, мэргэжилтэн, төр, засгийн хүмүүс ч санал нэгддэг. Тухайлбал, УИХ-ын гишүүн Д.Сэдваанчиг “ДНБ-ийг буруу тооцсон байж болзошгүй гэсэн эргэлзээ надад байгаа” хэмээн хэвлэлээр мэдэгдэв. УИХ-ын гишүүний ийн эргэлзсэнийг буруутгах аргагүй юм. Учир нь огцом өсөлтийг илэрхийлэх дээрх том тоо нь монголчуудыг төдийгүй дэлхийг алмайруулаад буй. Монголын өсөлтийг сонссон гаднынхан гайхахаас ч аргагүй. Учир нь, ганцхан жилийн дотор 17-20 хувиар өсдөг эдийн засаг гэж дэлхийд байхгүй гэнэ. Дэлхийн жишгээр эдийн засгийн бодит өсөлт жилдээ 1-3 хувьтай л байдаг аж. Харин Монголын эдийн засагт цутгаж буй их мөнгөний хэмжээг инфляцийн өсөлтөөс хэрхэн хамгаалж, бодит өсөлт бий болгох вэ гэдэг дээр хаа хаанаа толгойгоо гашилгах нь чухал юм. Тэгвэл өсөлт гэж чухам юуг хэлээд байна вэ?

Тооноос чанарт


Үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүний өсөлтийг хэмжих үүднээс эдийн засагчид анх эдийн засгийн өсөлтийг бодож олжээ. Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнээ хэмжих хэрэгсэл нь мэдээж эдийн засгийн өсөлт. Харин манай улсын хувьд үйлдвэрлэлийн өсөлт жилийн 20 хувьд хүрэх хэмжээнд очсон уу?

“Тухайн жилд шинээр үйлдвэрлэж, хүний гараар бүтээгдсэн баялгийн


хэмжээг л эдийн засгийн өсөлт гэж нэрлэдэг” хэмээн СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхмийн эрхлэгч Ц.Батсүх тайлбарлалаа. Тэгвэл хүний гараар бүтээгдсэн баялгийн өсөлтөд ДНБ, үндэсний нийт бүтээгдэхүүн /ҮНБ/ гэсэн хоёр ойлголт багтах ажээ. ДНБ нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нэг жилийн дотор бий болсон нийт үйлдвэрлэлийн хэмжээ. Харин ҮНБ нь Монгол үндэстний нэг жил хүртэлх хугацаанд үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний хэмжээг хэлдэг байна. Өөрөөр хэлбэл, ҮНБ-ийг илүү ойлгомжтойгоор илэрхийлбэл монголчууд өөрсдөө дотооддоо юу хийж бүтээж чадаж байна вэ гэдэг юм. Манай улсын хувьд хөрөнгө оруулагч бус хөрөнгө хүлээн авагч учраас ДНБ-ий хэмжээ их, харин ҮНБ-ий хэмжээ харьцангуй бага байдаг болохыг тэрбээр тэмдэглэлээ.

Улстөрчид болоод салбарынхан өндөр өсөлттэй гарах ДНБ-ий хэмжээгээр иргэдээ “хуурдаг” гэж үү? Монгол Улсын нутагт үйл ажиллагаа явуулж буй гаднын хөрөнгө оруулагчдын үйлдвэрлэл, ДНБ-ий хэмжээг хөөрөгдөөд, өөрсдөөдөө баялаг бий болгоод, түүнийгээ аваад явчихаж байна. Гэтэл манайд үйлдвэржилт хөгжөөгүй учраас бахь байдгаараа үлдэж, ҮНБ гэсэн ойлголт төдийлэн үнэ цэнэтэй биш байна. Тэгээд ч эдийн засгийн өсөлт буюу үйлдвэрлэлийн өсөлт хэрэглэгч, ард түмний амьжиргааны түвшинд нөлөөлөх үү

Эдийн засгийн цаашдын хандлага /оноор/



Монгол Улсын эдийн засгийн бүтэц /оноор/



Эх сурвалж: ҮХШХ

► Өсөлтийг тэгээд хэн хүртэх вэ?

Ирэх онд манай улсын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 5400 ам.долларт хүрнэ гэсэн чихэнд чимэгтэй мэдээ бий. Энэ гэхдээ бодит тоо мөн үү? Гэтэл улсын хэмжээнд ядуурал 40 хувьд хүрчихлээ шүү дээ.

Он гараад цалинг 53 хувиар нэмэгдүүлэх болохоор төрийн албан хаагчид болоод эмч, багш нарт орлого өснө гэсэн хүлээлт бүр ч их бий. Тиймээс зарим нь цалин нэмэгдэх юм чинь гээд үнэтэй цахилгаан бараа, шинэ автомашин, брэнд хувцас худалдан авах шийдвэр тээн эргэлзэхгүй явж байж ч болох. Тийм ээ, тэдний орлого нэмэгдэнэ. Гэхдээ нөгөө талд цалин нэмэх нь нэгэнт өсөлтийн хурд авсан инфляцийг улам бүр гааруулах вий дээ гэсэн болгоомжлол нийгэмд буй юм. Багшийн цалин яаж нэмэгдэхийг бодоод үзье л дээ. Ерөнхий боловсролын сургуулийн дадлага туршлага багатай шинэхэн багшаар жишээ татъя. Ийм багшийн одоогийн гар дээрээ авч буй дундаж цалин 300 орчим мянган төгрөг аж. 53 хувиар нэмэхээр шинэхэн багш маань даруй гар дээрээ 440 орчим мянган төгрөг авч, баярлана. Санаандгүй байтал цалин нь 100 гаруй мянган төгрөгөөр нэмэгдсэн багш бүсгүйн хэрэглээ тэлж, бараа бүтээгдэхүүний борлуулалт хурдсахад нөлөөлөх нь тодорхой. Үнэ хайчих бол. Үүнд, Сангийн сайд хэлэхдээ “Цалинг хоёр хувааж нэмэх болохоор инфляцийн дарамт үүсэхгүй” гэж булзааруулж байгаа. “Инфляци бол үйлдвэрлэгч талд эерэг. Тогтмол орлоготой хэрэглэгчдэд халтай далд таввар” хэмээн мэргэжилтнүүд хэлж байна. Нобелийн шагналт, эдийн засагч Мильтон Фрийдман “Хувь заяагаа сонгох нь” номондоо инфляци нь мөнгөний тоо хэмжээ өссөнөөс үүдсэн үзэгдэл хэмээн тэмдэглэжээ. Бодит эдийн засгийн өсөлтийг бий болгох хөшүүрэг нь хөрөнгө оруулалт, хөдөлмөр эрхлэлт. Тиймээс эдийн засаг тэлэхийн хэрээр ажлын байр бий болох учиртай тухай Ц.Батсүх багш онцлов. Гэтэл өнөөдөр манайд ажлын байрыг “үйлдвэрлэх” аж үйлдвэрлэл хөгжихгүй байгаа нь эдийн засаг бодитоор өсөөгүйн тод жишээ болов уу.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан арваннэгдүгээр сарын Монгол Улсын нийгэм, эдийн засгийн төлөв байдлаар улсын хэмжээнд Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 62700 болжээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 54,4 хувиар өсчээ. Үнэхээр сэтгэл түгшээх мэдээ байгаа биз дээ. Биднийг “эдийн засгийн өсөлт сайн байна, Монгол Улс үсрэнгүй хөгжих нь хэмээн хөөрөн баясах зуур бодит эдийн засгийн өсөлт гарахад шууд нөлөө үзүүлэх ажил эрхлэлтийн байдал улам бүр дордож байгаа нь харамсалтай. Төр, засгаас “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” гэж зарлаад ч энэ салбарт үр дүн

төдийлэн гараагүй. Эдийн засгийн өсөлт нь хөдөлмөрийн бүтээмж дээшилсэн тохиолдолд бий болдог баялаг болохыг МҮХАҮТ-ийн тэргүүн С.Дэмбэрэл хэлсэн.

Эдийн засгийн бодит өсөлтийг хэмжих бас нэгэн шалгуур нь хүний хөгжил. Гэтэл үсрэнгүй эдийн засгийн өсөлттэй гэж буй гэгдэх Монгол Улс НҮБ-аас гаргасан Хүний хөгжлийн индексээр дэлхийн 169 орноос 100 дугаар байрт жагсжээ. Энэ нь дундаж гэсэн ангилалд дөнгөж багтсан гэсэн үг юм. Эдийн засагчдын хэлж буйгаар өсөлт, хөгжил гэдэг эдийн засагт хоёр өөр ухагдахуун гэнэ. Эдийн засгийн өсөлт бол хөгжил бус, үйлдвэрлэлд гарч буй тоон үзүүлэлтийг хэлдэг байна. Тогтвортой өсөлт аль болох урт хугацаанд үргэлжилсний дүнд хөгжлийн чанар бий болдог аж. Тэгвэл энэ үүднээс аваад үзвэл эдийн засгийн огцом өсөлттэй, хэзээ ч өндрөөс унаж болзошгүй манай улсын хувьд хөгжил гэсэн ойлголт тэртээд бий гэсэн үг. Монгол Улсыг хөгжиж буйд итгэхийн тулд чанарын өөрчлөлтийг харах хэрэгтэйг Ц.Батсүх багш зөвлөлөө. “Гэнэт идсэн хоол гэгдсэнд халтай” гэгчээр өндөр өсөлт эдийн засагт эсрэгээрээ хортой гэдгийг эдийн засагч, мэргэжилтнүүд хэлж буй. Хамгийн наад зах нь инфляцийг хөөрөгддөг байна. Тиймээс эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих нь илүү чухал аж. Мөн УИХ-ын гишүүн Р.Амаржаргал “Эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоонд хүрлээ гэж сайрхацгаах юм. Баярлахаасаа илүү болгоомжлох ёстой юм биш үү” хэмээн нухацтай гэгч нь хэлсэн удаатай. Түүний үзэж байгаагаар “Жилийн 15-20 хувийн өсөлт өөрөө эрүүл үзэгдэл биш. 100 км цаг хурдалж буй машин тоормозгүй болсонтой адил. Эдийн засаг ямар ч удирдлагагүй, хэзээ хагарахыг нь мэдэхгүй томорч буй хөөстэй ижил” гэлээ. Тэрбээр “Гадаад капиталын цутгалт, түүхий эдийн үнийн өсөлтийг шүтсэн эдийн засгийн өсөлт тун богино настай” гэж дүгнэв. Зэс, нүүрсний үнээс хэт хараат манай эдийн засагт эрсдэл хэт өндөр байгааг эдийн засагч УИХ-ын гишүүн товчхон бөгөөд тодорхой тайлбарласан нь энэ.

Эдийн засгийн өсөлтийг өндөр үнээр худалдаж авч байгаа юу?

Барилгын жижиг компанитай хамаатны ахаасаа эдийн засгийн өсөлт барилгын бизнест нөлөөлж байгаа эсэхийг асуухад “Мөнгөний эргэлт сайжирсан нь өсөлтийн нэг шинж байх. Гэхдээ барилгын салбарт материал, түүхий эдийн нийлүүлэлт хангалтгүй хэвээр байна. Түүхий эд ховордоод ирэхээр эрэлтээ дагаад үнэ өсчихдөг байдал ч ужиг өвчин хэвээр. Тиймээс монголчууд эргээд эдийн засгийн үр ашигтай өсөлтийг өндөр үнээр худалдан авахад хүрээд байна” гэсэн нь улстөрчдөд нэгийг бодуулах биз ээ. Ирэх ►►

► оноос “100 мянган айлын орон сууц” хөтөлбөр хэрэгжинэ шүү дээ.

Эдийн засагт бий болох өсөлтийг нээрээ бид өндөр үнээр худалдан авч байгаа юу. Инфляци цаашид өсөлтийг бүр ч үнэтэй болгох уу? Гэхдээ ийм байдалд хүрэхгүй гэж найдъя. Учир нь, Төвбанкны ерөнхийлөгч “Төсвийн зарлагыг нэг их наяд төгрөгөөр бууруулсан нь инфляцийг 10 орчим хувьд барих боломжийг бүрдүүллээ” хэмээн мэдэгдсэн. Иргэдийн худалдан авах чадвар огцом нэмэгдэхээр сагсанд буй өргөн хэрэглээний барааны үнэд нөлөөлж, инфляци хөөрөгдөхийг Монголбанк улстөрчдөд байнга сануулдаг. Өдөөс нь Засгийн газар “өсөлт” гэсэн товчхон хариулт өгдөг билээ. Харин “Мөнгө хэний гарт байна, түүнд эдийн засгийн өсөлт илүү мэдрэгдэнэ” гэж эдийн засагчид учирлах.

Малчны хотонд инфляци л очдог

“Эдийн засгийн өсөлтийг айл бүрийн босгоор алхууль” гэж уриалснаараа эдийн засагч Н.Туяа олонд танигдах боломжоо улам бүр баталгаажуулав.Түүний хэлсэнчлэн үнэхээр өрх бүрийн санхүүгийн үүд хаалгыг эдийн засгийн өсөлт тогших болов уу. Мэдээж, эдийн засгийн өсөлт гэдэг эрхэмсэг үнэ цэнэтэй тоо.

Айл бүхэнд өвлийн өвгөн аав бэлэг тарааж чаддаггүй. Айл бүрээр орж бэлэг тараах хүсэл байгаад ч цан хүүрэг савсуулсан, цагаан сахалт өвөө цаг хугацаандаа амждаггүй.

Үүний нэгэн адил айл бүрийн босгоор алхах учиртай эдийн засгийн өсөлт өвлийн өвгөн шиг байж таарахгүй. Тиймээс Н.Туяа эдийн засагч ийн оновчтойгоор уриалсан биз ээ. Өсөлтөөс юу горьдох вэ? Өндөр цалин, ажлын байр, өөр ямар боломж хүлээх вэ. Тогтмол орлогогүй, мал сүрэг нь эрсдэл ихтэй, малынхаа ноос ноолуурын ашиг шимийг жилдээ нэг хүртдэг малчны амьдралд эдийн засгийн өсөлт хэрхэн ирэх вэ. Өнөөдөр өсөлтийн үр дүн бус, инфляцийн өндөр цифрээр хэмжигдсэн нугарсан үнэтэй, “хугарсан” чанартай бараа бүтээгдэхүүн малчны хотонд очдог. Төв, суурин газрын иргэдийг бодоход харьцангуй хэрэглээ багатай ч гурил будаа, тамхи тариа, дээлийн торго дурдан мэтийн өргөн хэрэгцээт бараагаа зах зээлийн үнээс хэд дахин өндөр үнээр авдаг хөдөөнийхөнд эдийн засгийн өсөлт хүрэх болов уу? Малчин Доржийн гарт мах, ноос ноолуур байвал түүнийгээ зах зээлийн үнээр арилжаалсан тохиолдолд эдийн засгийн өсөлтийг тэр мэдэрнэ. Саальчин Чимэгээ ааруул тосоо борлуулах нь эдийн засгийн өсөлтийг “амтлах” оролдлого хийж байгаа хэрэг хэмээн таамаглаж байгаагаа эдийн засагчид хэлж байна.

Маргааш амьдрал сайхан болно гэсэн мөнхийн итгэл найдвар алдрахгүй. Эдийн засгийн хурдтай өсөлтийг дагаж ажлын байр олноор бий болсноор л Монгол Улсын иргэн бүр ажилтай, орлоготой сайхан амьдрах боломж бүрдэх нь. Юутай ч итгэл найдвар тээсэн их өсөлтийн жил Монголын эдийн засагт тавтай морилго. ■

KHATAN TUUL
Pure Water

Packaging quantity of Pure water:

0.35 L /bottled/	Маркетинг: 99071655
0.6 L /bottled/	Захиалга авах утас: 70173386
1 L /bottled/	Факс: 976-11-70174494
19 L /ballon/	

Produced and bottled by “Welmon Trade” Co.,Ltd of Mongolia



Ч.Отгочулуугийн булан

20 дугаар тогтоол давтагдах уу? “Үгүй” гэхдээ...

Он гараад 20 дугаар тогтоол давтагдаж, бүх юмны үнэ хоёр дахин өсөх нь, төгрөгийн худалдан авах чадвар навсайтлаа унах нь гэсэн шуугиан гараад намжлаа.

Энэ шуугиан хэнд ашигтай байв? Ирэх жил сонгуулиар гарч ирэх сонирхолтой гуравдагч хүчнийхэнд мэдээж далим болно. Учир нь тэд “Эрх барьж буй намуудын урагшгүй, чадамжгүй байдлаас болж инфляци өсөж байна. Эрх мэдэлтнүүд хуйвалдаж, ард түмнийг мэхлэх замаар өөрсдөө хөрөнгөжих гэж байна” гэх суртлыг дэлгэрүүлж чадвал, бухимдсан иргэдээс санал авах магадлал нь өснө гэж тооцоолж байж ч болох юм. Түүнчлэн ам.долларын нөөцтэй ченж хэмээх валют арилжаалагч нарт ашигтай. Төгрөгт итгэх итгэл буурснаар ам.долларын эрэлт өснө гэдгийг тэд сайн мэднэ.

Энэ шуугиан хэнд ашиггүй байв? Цалингаас цалингийн хооронд амьдарч буй жирийн иргэдийн хувьд үнийн хөөрөгдөл хэзээд ашиггүй байдаг. Инфляци ханшийн тогтворгүй байдал эцсийн дүндээ эдийн засагт сөргөөр нөлөөлдөг.

20 дугаар тогтоол хэзээ, хэрхэн, ямар учраас гарсаныг залуу уншигчид, оюутнууд тэр бүр сайн мэдэхгүй байж болох юм. Харин ахимаг насны иргэдийн ой тойнд бүх юмны үнэ зэрэг өссөн, сайд дарга нар нууцаар өөрсдийн мөнгөө банкинд байршуулж хоёр дахин өсгөж авсан гэх зэрэг бүдүүн тойм санамж үлдсэн нь тодорхой. Энэ санамж нь таагүй сэтгэгдэл, битүү айдсыг одоо хэр нь дагуулж, хойч үеийнхэнд ч нөлөөлж байна.

Гэвч энэ айдас бодитой юу? Эсвэл өнгөрсөн зүйлийн сүүдэрт нь орчихоод хий шаналаад байна уу? Ер нь 1991 оны нэгдүгээр сард нууцаар боловсруулагдаж, гэнэт батлагдсан шигээ ард түмнийг гэнэтийн цочролд

оруулсан Засгийн газрын 20 дугаар тогтоолын зорилго юу байв?

Тухайн үеийн Бямбасүрэн гуайн Засгийн газарт тун ч хүнд бэрхшээл учраад байж.

БНХАУ-тай харьцах харилцаа өнөөгийнх шиг сайн биш, хил харьцангуй хаалттай хэвээр. Харин халамжлагч ах ЗХУ дотроо хямрахын зэрэгцээ, ардчиллын дуу аялсан Монгол хэмээх дүүгээ хардангуй харах болсон цаг.

ЗХУ-ын удирдагч асан Михаил Горбачев 1989 оны тавдугаар сард БНХАУ-д албан ёсны айлчлал хийсэн байдаг. Тус айлчлалын гол зорилго нь 30 орчим жил дайсагнаж ирсэн хоёр улсын харилцааг хэвийн болгох, мөн түүнчлэн бүс нутгийн орнуудыгаа хамтран “засан тохиуулах” зэрэг байв. Вьетнам, Камбоджийн хооронд үүсээд байсан хямралыг зохицуулах нэрийн дор болсон уг уулзалтын нэг чухал зорилт нь ЗХУ-БНХАУ-ын хил орчим бөөгнөрөн байрласан цэргийн их хүчийг багасгах, ЗХУ БНМАУ-аас цэргээ гаргаж, улмаар хоёр их гүрний хоорон дахь эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг байж.

Ердөө хоёр том хөрштэй, тэр хоёроор дамжиж дэлхийтэй холбогддог Монгол Улсын хувьд байдал эгзэгтэй болсоор л байв. Барааны хомсдол нүүрлэж, ЗХУ гадаад худалдаагаар илт хавчиж эхэлсэн нь Монголд асар хүнд туссан юм. Тухайлбал, ЗХУ БНМАУ-ын экспортод 60-150 хувиар татвар авах шийдвэр гаргасан байдаг.

ЗХУ БНМАУ-ын ДНБ-ий 30 орчим хувьтай тэнцэх тусламж үзүүлдэг байснаа 1990 оны арванхоёрдугаар сарын 26-наас бүрэн зогсоосон байна. Мөн БНМАУ-ын жил бүрийн төсвийн алдагдлыг ЗХУ санхүүжүүлэх бөгөөд үүнийгээ өр болгон бүртгэдэг байв.

БНМАУ-ын нийт экспортын 95 хувь ах дүү гэгдэх социалист орнууд руу ЗХУ-аар дамжин гардаг байсан нь ч мөн зогсов. ЗХУ мэдээж

БНМАУ-д нийлүүлдэг шатахууныхаа үнийг нэмж, хэмжээг нь багасгахаа ч мартсангүй. Түүнчлэн ЗХУ-ын олон арван мянгаар тоологдох их цэрэг БНМАУ-аас гарч эхэлснээсээ хойш бас нэгэн бэрхшээлийг үүсгэв. Учир нь тэд монгол төгрөгийг хуримтлуулж, улмаар Монголд үлдсэн барааны нөөцийг худалдан авахад зарцуулжээ. Орос цэргүүдэд зохиомол өндөр ханштай монгол төгрөг хэрэггүй байсан бололтой, харин тэдэнд биет бараа л хэрэгтэй байсан учир “хүсээгүй экспорт” үүсэв. Уг нь дотоодын зах зээлд нийлүүлэлт нь эрэлтээс давсан үед экспорт хийж байвал нэмэлт орлого бий болно, эсрэгээр дотоодын нийлүүлэлт нь эрэлтээсээ бага байхад импортын орон зай үүснэ. Гэтэл манайд далд хэрнээ бодит ре-экспорт хүчээ авч байж.

Чухам энэ үед л барааны хомсдолд орсон ядуу, жижиг орны Засгийн газар маань үлдсэн жаахан нөөцөө хадгалж үлдэх арга ухаан сийлэх хэрэгтэй болсон хэрэг.

“Эдийн засгийг зах зээлийн зохицуулалтад шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” нэрийн дор 1991 оны нэгдүгээр сарын 15-нд алдарт 20 дугаар тогтоолыг баталсны нэг зорилго нь ч үүнтэй холбоотой.

Тухайн цагт монгол төгрөг хаана эргэлдэж байв? Мэдээж банкинд хадгаламж байдлаар, байгууллагуудын данс тэгээд бас багагүй хэсэг нь иргэдийн гар дээр буюу банкнаас гадуур гүйлгээнд байв. Уг банкнаас гадуурх мөнгөний багагүй хувь нь Орос цэргүүдэд төвлөрч байсан тухай тэр үеийн эдийн засагчид дурдсан байдаг.

Уг тогтоолын үр дүнд өргөн хэрэглээний хүнс, барааны үнэ хоёр дахин өсчээ. Түүнчлэн цалин, иргэдийн бага дүнтэй хадгаламж мөн хоёр дахин өссөн байна. Харин гүйлгээнд байгаа мөнгө худалдан авах чадвараа хоёр дахин алдав. Өнгөц харахад ▶

хэсэг иргэдийнхээ эсрэг хийж буй мэт боловч үнэндээ барааны хомсдол руу хурдтай гулсан орж байсан эдийн засагт тустай зоримог алхам болжээ.

Өнөөдрийн Монголд хүнс, барааны хомсдол нүүрлээгүй байна. Монголын төр баян болж. Иргэдийн худалдан авах чадвар ч 1991 онтой харьцуулахад эрс дээшилжээ. Монголд харийн цэргийн анги алга. Монголд буй хүнс болон бусад өргөн хэрэглээний барааг зөөх сонирхол ч алга. Тиймээс алдарт хорьдугаар

тогтоол шууд утгаараа дахиж гарна гэж үгүй биз ээ. Учир нь цаг үе, нөхцөл нь өөр юм. Харин Монголын зэс, нүүрсийг гадагш зөөх сонирхол их байна. Нэгэнт бид өөрсдөө ашиглаж чадахгүйгээс хойш, тэр түүхий эдийг идэж эсвэл өмсөхгүйгээс хойш гаргасан нь ч зөв. Харин нүүрс, зэснээс орж буй их мөнгө сонгуулийн мөчлөгөөр тэжээгдэн бодит эдийн засгийг халааж, инфляцийг хөөрөгдөж, төгрөгийн ханшийг савлуулж байна.

Хэрэв өнөөдөр 20 дугаар тогтоол

шигдаацтай, түүхэн шийдвэрийг дахин гаргах хэрэг байна уу гэвэл олонх эдийн засагч үгүй гэх байх. Харин улс төрийн аливаа нэг үзэл суртал, бүлэглэлийн гинжийг тас цохиж, зах зээлд өөрт нь боломж олгосон гэдэг утгаараа 20 дугаар тогтоол шиг зоримог алхам хэрэгтэй. Алдарт 20 дугаар тогтоолоор 1991 онд хэт социалист эдийн засгийн бодлогоос Монголыг ангижруулсан, өдгөө цагт харин хэт популист улс төрчдөөс зах зээлийг чөлөөлөх алхам л илүү үгүйлэгдэж байна. ■

Тооны хэлээр

Эдийн засгийн өнгө


1.1 Эдийн засгийн өсөлт.

Монгол Улсын үйлдвэрлэдэг гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн гадаад болон дотоод эрэлт нэмэгдэж байгаа, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, тэр дундаа уул уурхай, олборлох салбарын хэмжээ тэлж байгаагаас тайлант оны эхний гурван улиралд ДНБ-ий бодит хэмжээ (2005 оны суурь үнээр) 3, 513.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх 2010 оны мөн үеийнхээс 16.7 хувиар өсөлттэй гарлаа. Харин оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 7,810.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх 2010 оныхоос 31.4 хувиар нэмэгдлээ. Уг өсөлтөд үйлчилгээний салбарын өсөлт болон бүтээгдэхүүний татварын хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Үйлчилгээний салбар оны үнээр 29.0 хувь, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 20.1 хувиар өссөн. Үйлчилгээний салбарын өсөлтөд тээвэр, бөөний болон жижиглэн худалдааны салбарын өсөлт голлон нөлөөлөв.

Аж үйлдвэрийн салбар хурдацтай өссөн, тухайлбал нүүрсний олборлолт 25 сая тонн хүрч өмнөх оноос хоёр дахин нэмэгдсэн, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл 24 хувиар, үндсэн металлын үйлдвэрлэл 30 хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Түүнчлэн уул уурхайн салбараас олж байгаа орлогыг нийгэмд хуваарилах зорилгоор аж ахуйн нэгж байгууллагад тодорхой хувийг эзэмшүүлнэ гэсэн Засгийн газрын бодлогын үр нөлөөгөөр 2011 оны эхний улиралд зохион байгуулагдсан аж ахуйн нэгж байгууллагын тооллогод аж ахуйн нэгж байгууллагууд маш идэвхитэй оролцсон. Үүний үр дүнд ч албан бус салбарыг бууруулах чухал алхам боллоо. Эхний хагас жилийн байдлаар энэ арга хэмжээний үр дүнд бараа, үйлчилгээний татварын цэвэр татварын хэмжээ 26.4 хувиар өссөн байна. 2011 оны эхний долоон сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 1083.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 69.3 тэрбум төгрөг буюу 6.8 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдэр үйлдвэрлэл 0.1-78.2 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлтэд нүүрсний үйлдвэрлэлтийн эзлэх хувийн жин огцом нэмэгдэж байна.

Хүлээгдэж буй гүйцэтгэлээр, Монгол Улсын эдийн засаг

Уул уурхай, олборлох үйлдвэрлэлт, эхний найман сарын байдлаар



2011 онд 20, үүнээс уул уурхайн салбар 18.0, бусад салбар 20.3 хувиар тус тус өсөхөөр хүлээгдэж байна. Энэ онд мал аж ахуйн салбар өсөлттэй байхаар таамаглаж байна. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаар дамжин эдийн засгийн бусад салбарын өсөлт нэмэгдэнэ.

Харин 2012 онд эдийн засгийн бодит өсөлт 19.7 хувьд хүрэхээр төлөвлөж байгаа бөгөөд үүнд уул уурхайн олборлолт огцом нэмэгдэхээр байна.

1.2 Инфляци

Эдийн засаг тэлж, эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт эхний найман сарын байдлаар 5.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 61.6 хувиар өссөний зэрэгцээ Засгийн газраас хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хомсдолыг багасгах үүднээс хавраас эхлэн хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд инфляцийн түвшин буурч байсан хэдий ч хувийн хэвшлийн эрэлт нэмэгдсэн, шатахууны үнэ өссөнөөс тээврийн үйлчилгээний үнэ өсч тээврийн зардлаас үүдэж бусад бараа үйлчилгээний үнэ өсөх хандлагатай ▶

Улаанбаатар хотын жилийн инфляци



Жилийн инфляцид үзүүлэх нөлөө



▶ боллоо. Хэрэглээний үнийн индекс найман сарын эцэст өмнөх оны мөн үеэс 9.0 хувиар өслөө. Энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр, шатахуун нийлүүлэлтийн найдвартай байдлыг хангах, махны нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр оны эцэст инфляцын түвшин 9.7 хувьд байхаар байна. Эдийн засгийн тэлэлт 2012 онд үргэлжлэх бөгөөд инфляцийн түвшинг 9.0 хувьд таамаглаж байна.

1.3 Валютын ханш



Валютын дотогшлох урсгал нэмэгдсэнээс оны эхний долоон сарын байдлаар, гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 1827.1 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал 2.9 дахин өссөн нь санхүүгийн дансны ашгийг 5.9 дахин нэмэгдүүлэн 1449.3 сая ам.долларт хүрсэн байна. Гадаад валютын цэвэр албан нөөцийн хэмжээ наймдугаар сарын 31-ний өдрөөр 2615.6 сая ам.долларт хүрлээ. Төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн дундаж ханш найман сард 1238.6 төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 86.5 төгрөг буюу 6.5 хувиар чангарсан. Манай улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ өсч байгаа, гадаадын хөрөнгө оруулагчдаас Монголд хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэхийн хэрээр хөрөнгийн дотогшлох урсгал хүчтэй нэмэгдэж, төгрөгийн ханш чангарч байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр, төгрөгийн америк доллартой харьцах дундаж ханш 1240.3 төгрөг байхаар байна.

Гадаадын валютын дотогшоо урсгал, төлбөрийн тэнцлийн санхүүгийн дансны ашигтай байдлаас үүдэж 2012 онд валютын ханшийг жилийн дунджаар 1199.7 төгрөг байхаар таамаглалаа.

1.4 Гадаад худалдаа.

Монгол Улсын гадаад, дотоод бараа эрэлт сайжирсан, уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэнээс тоног төхөөрөмжийн импорт огцом өссөнөөс гадаад худалдааны нийт бараа эргэлт 2011 оны эхний найман сарын байдлаар 7080.1 сая долларт хүрч, үүнээс экспорт 2889.0 сая ам.доллар, импорт 4191.1 сая ам.долларт хүрч, гадаад худалдааны алдагдал 1302.1 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 7.6 дахин нэмэгдсэн

Экспорт. 2011 оны эхний найман сарын байдлаар нийт 2889.6 сая ам.долларын бараа, бүтээгдэхүүн экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 61.1 хувь буюу 1095.4 сая ам.доллараар өссөн. Мөн хугацаанд нийт экспортын 39.9 хувийг чулуу нүүрс, 22.9 хувийг зэсийн баяжмал, 9.5 хувийг төмрийн хүдэр ба баяжмал, 5.2 хувийг боловсруулаагүй нефть тус тус бүрдүүлж байна. “Бороо Гоулд” ХХК 1474.9 кг алтыг Канад улс руу, Хадгаламж банк 150.8 кг алтыг БНСУ руу, 397.8 кг алтыг Швейцарь улс руу, Монголбанк 684.7 кг алтыг Их Британи улсад тус тус экспортолсон байна.

Импорт. Уул уурхайн төслүүдийн хэрэгжилттэй уялдан хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импорт өмнөх оны мөн үеийнхээс 147.5 хувиар, нефть импорт 82.6 хувиар, тээврийн хэрэгслийн импорт 3.1 дахин нэмэгдсэн нь нийт импортыг өмнөх оны мөн үеэс 2.1 дахин нэмэгдэхэд хүргэсэн байна.

Хүлээгдэж буй гүйцэтгэлээр, 2011 онд экспортын хэмжээ 4395.5 сая ам.долларт, харин импорт 5900.1 сая ам.долларт хүрч, гадаад худалдааны нийт тэнцлийн алдагдал 1504.6 сая ам.долларт хүрэхээр байна. Харин 2012 онд олборлох салбарын тоног төхөөрөмжийн импортын өсөлт буурч, экспортын орлогыг өснө гэж үзэн экспортын хэмжээ 6816.4 сая ам.доллар, импорт 7592.8 сая ам.долларт хүрэхээр тооцон, нийт гадаад худалдааны тэнцлийн алдагдал багасан 776.4 сая ам.долларт хүрнэ гэж үзлээ.

Монгол Улсын эдийн засгийн байдал дунд хугацаанд

2.1 Эдийн засгийн өсөлт

Эдийн засгийн өсөлт 2013-2014 онуудад дунджаар 13 орчим хувьтай байхаар байна. Энэ өсөлтөд уул уурхайн салбарт орж буй хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн боломжит хүчин чадлын хэмжээний өсөлт, экспортын бараа, бүтээгдэхүүний үнийн өөдрөг төсөөлөл нөлөөллөө. ДНБ-ий бодит хэмжээ 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2013 онд 6793.3 ▶

Зээлжих зэрэглэл тогтоогч байгууллага	Монгол Улсын Зээлжих зэрэглэл/төлөв байдал/
Фитч	B+/Тогтвортой/
Стандарт энд Пүүрс	BB-/Тогтвортой/
Мүүдийз	B1/Тогтвортой/

Эх үүсвэр: Сангийн яам

▶ тэрбум төгрөг, 2014 онд 7701.5 тэрбум төгрөгт хүрэхээр байна. Эдийн засгийн энэхүү өндөр өсөлтөд гадаадын хөрөнгө оруулагчид чухал үүрэгтэй.

Монгол улсын зээлжих зэрэглэл 2010 оноос эхлэн сайжирч байна. Зээлжих зэрэглэл тогтоодог Фитч, Мүүдийз, Стандарт энд Пүүрс компаниуд Монгол Улсын эдийн засгийг тогтвортой гэж үнэлсэн нь Монгол Улсад орох гадны хөрөнгө оруулалтыг татах чухал үзүүлэлт болжээ.

2.2 Инфляци

Эдийн засгийн тэлэлттэй уялдан инфляцийн түвшин нэмэгдэж байгаа бөгөөд дунд хугацаанд инфляцийг нэг оронтой тоонд барихыг зорьж ажиллаж байна. 2013-2014 онуудад инфляцийн түвшинг 8-9 хувьд байлгахад төлөвлөж байна.

2.3 Валютын ханш


Дунд хугацаанд гадаадаас орох хөрөнгө оруулалт, валютын дотогшлох урсгалаас шалтгаалан төгрөгийн ам.доллартай харьцах ханш чангарах төлөвтэй байна.

Гадаад худалдаа

Дунд хугацаанд гадаад эдийн засгийн эрэлт сайн, манай улсын дотоод идэвхжилтийн нөлөөнөөс гадаад

худалдаа эрчимтэй нэмэгдэж, ялангуяа экспортын өсөлт огцом явагдахаар байна. Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ болон биет хэмжээ өсч, экспортын хэмжээг 2013 онд 8984.0 сая ам.долларт, 2014 онд 10628.1 сая ам.долларт хүргэхээр байгаа бөгөөд нөгөө талаас сүүлийн жилүүдэд уул уурхайн төслүүдийн хэрэгжилттэй уялдан хүн даацын машин, механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импорт аажмаар буурч, 2013 онд 8283.7 сая ам.доллар, 2014 онд 9692 сая ам.долларт хүрэн гадаад худалдааны тэнцэл 2013 оноос эхлэн ашигтай гарахаар байна. ■

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: Сангийн яам

Сангийн яамны 100 жилийн ойд

Сангийн сайд Д.Моломжамц агсныг дурсахуй

Д.Бэхээ

“Өнөөдрийн залуучууд урагшаа тэмүүлэхийн хэрээр арагшаа хардаг байгаасай”

... Би дэлхийн олон улс оронд очиж, Тавантолгой ордын талаар танилцуулсан ч тоож авч хэлэлцээгүй юм. Харин хамгийн сүүлд Хойд Солонгосын Ерөнхийлөгч Ким Ир Сенийг манай улсад галт тэргээр айлчлаад буцахад нь би коксжсон нүүрстэй ордынхоо тухай ам хуурайгүй ярьсаар түүнийг Алтанбулагийн гааль хүртэл үдэж өгч билээ. Удалгүй Хойд Солонгосоос экспертизийн мэргэжилтнүүд ирж, нүүрсний дээжээс авч явсан юм даг. Түүнээс хойш сураггүй болсон...

Дэлхийн томоохон улс гүрэн,

үндэстэн дамнасан компаниудын сонирхон гүйгээд байгаа Тавантолгой ордын тухай Сангийн яамны сайд агсан Д.Моломжамц ийн ярьж билээ. 1948-1957 он хүртэл Сангийн яамны сайдаар ажилласан энэ хүн одоогийн Эрдэнэтийн зэсийн ордыг ашиглах, мөнгө төгрөг босгоход чиглэсэн бүх л ажлыг хариуцан ажиллажээ. Харин Тавантолгойн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах нь Монголын хөгжилд асар их үүрэгтэйг тэртээх он жилүүдэд хэдийнэ харж идэвхтэйгээр гүйсэн ч тусыг эс олсон гэдэг. Социализмын үеийн Монгол орны хамгийн хүнд хэцүү үед Сангийн сайдын албыг өсөн жил хашиж, улс орны эдийн засгийн өнөөгийн хөгжлийн суурийг

бэхжүүлсэн хүн гэж үздэг юм билээ, Моломжамц гуайг. Үнэхээрийн мэдлэг боловсролтой хүн цөөн, ялангуяа эдийн засаг, санхүүгийн салбарт мэргэшсэн таван хуруу дарам боловсон хүчний нэг байсан тухай хүмүүсийн дурсамжаас уншиж болно.

Тэрбээр эдийн засаг, нийгмийн байдал хүнд, ороо бусгаа үед 26-хан насандаа Сангийн сайдын хүндхэн албыг авчээ. Ганцхан жишээ дурдахад тухайн үеийн банк, Сангийн яамны системд эдийн засгийн дээд мэргэжил эзэмшсэн Ю.Цэдэнбал дарга, Д.Моломжамц болон түүний эхнэр Ж.Цэрэн-Янжингаас өөр мэргэжилтэн бараг л байгаагүй гэдэг. Товчооноор илэрхийлбэл, нэг сая ▶



Д.Моломжамц агсан УИХ-ын гишүүн Лүндээжанцан, Ч.Улаан нарын хамт.

Баруун гар талаас хоёрдахь нь Д.Моломжамц

хүрэхгүй нэн ядуу, өвчин эмгэг бүхий амьдралтай, ард иргэдийн ихэнх нь бичиг үсэгт тайлагдаагүй, малаас өөр амьжиргааны эх үүсвэргүй, Азийн хамгийн хоцрогдсон орны нэгж байжээ, манай улс. Ийм нөхцөлд тэрбээр улс орны санхүүг атгаж, хөгжүүлэх том бөгөөд хариуцлагатай үүрэг хүлээж. Ямар боловсролтой хүмүүсийг удирдаж ажиллах нь дэндүү тодорхой байсан тул хамгийн түрүүнд хойд хөршид жил бүр 20-иод оюутан суралцуулах замаар мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, дотоодын сургууль, соёлын хүрээг өргөтгөх зэрэг арга хэмжээг авсан нь өнөөгийн эдийн засгийн салбарын хөгжлийн үндэс болсон ажээ. Түүнийг сайдын албан тушаалыг авах үед улсын нэгдсэн төсөв 277.1 сая төгрөгийн орлоготой, 304.1 сая төгрөгийн зарлагатай байсан бол есөн жилийн дараах үзүүлэлтээр орлого 643.2 сая, зарлага 600.3 сая төгрөг болж баланс тэнцвэржиж эхэлжээ.

Энэхүү өсөлтөд хүрэхийн тулд цаг наргүй ажилладаг байсан тухай дурсамжууд бий. Даргынхаа өрөөний гэрлийг унтрахаар л ажлаа дуусгаж, гэр рүүгээ явдаг байлаа хэмээн түүний удирдлагад ажиллаж байсан хүмүүс ярьсан бол эхнэр Ж.Цэрэн-Янжин “Нөхөрт маань чөлөөт цаг их бага гарна. Тиймээс миний хувьд ар гэртээ санаа зовохооргүй, улс орныхоо төлөө тууштай ажиллах нөхцөлийг нь бүрдүүлэхэд анхаардаг байсан. Гэлээ ч эхнэр хүүхдэдээ халамжтай сайн аав, гэрийн эзэн байсан. Хүүхдүүдээ унтсан хойно ирж, тэднийгээ үнсээд өглөө унтаж байхад нь явдаг байсан даа” хэмээн дурссаныг санаж байна.

Тухайн үеийн нэгдсэн төсвийн орлогын дийлэнх нь малын албан

татвар, архины орлого, улсын зээллэг, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, ард иргэдээс хураадаг албан татвараас бүрддэг байсан бол зарлага нь ихэнхдээ сургууль, эмнэлэг, соёл боловсролыг хөгжүүлэхэд явахаас гадна улсын батлан хамгаалахад төсвийн 40-50 хувийг зарцуулдаг байж. Харин Д.Моломжамц төсвийн ийм байдалд дүн шинжилгээ хийж, төсвийн орлогын шинэ эх үүсвэрийг хайх, олох, нэмэгдүүлэх, зарлагын бүтцийг оновчтой болгоход гол анхаарлаа хандуулж ажилласны дүнд төсвийн орлого, зарлагад чанарын өөрчлөлтүүд гарч, хөгжлийн бааз суурь бэхжсэн гэж үздэг ажээ.

Тавантолгойн ордыг ашиглах асуудал өнөөдөр бараг л шуудрах шатандаа ороод байгаа. Нөгөө тоохгүй байсан улс гүрнүүд янз бүрийн аргаар энэ ордыг ашиглах үйл ажиллагаанд оролцох хүсэлтээ хэдийнэ илэрхийлээд, хариу хүлээн сууна. Өөрөөр хэлбэл, нэгэн жаранд уг ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахаар явж байсан сайд, нөгөө талдаа 100 жилийн босгон дээрээ мөнөөх ордыг ашиглах талд ажиллаж буй Сангийн сайдуудын тухай ярилцлага, нийтлэл манай сэтгүүлд орж байгаа нь тохиол юм. Сангийн яамныхан Д.Моломжамц сайдаа нэлээд хүндэтгэдэг байсныг мэдэх юм. 100 жилийн ойн хүрээндээ Сайдынхаа 90 насны ойг тэмдэглэн өнгөрүүлсэн бол төрсөн нутаг Дундговь аймгийн ИТХ-ын тогтоолоор Баянжаргалан сумын дунд сургуулийг Д.Моломжамцын нэрэмжит болгожээ. Мөн түүний тухай “Би ганцаараа бүтээсэн юм биш” нэртэй ном ч хэвлэгдэн гарчээ.

Тэрбээр сайдын ажлаас гадна

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч, нэгдүгээр орлогч дарга, Улсын төлөвлөгөөний комиссын дарга, МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны гишүүн, нарийн бичгийн даргаар олон жил ажилласан байна. Ийм ч учраас “Моломжамц бол өнгөрсөн зуунд МАХН-ын “мөнхийн” хоёрдугаар хүн гэгдэж явсан төрийн том зүтгэлтэн” хэмээн түүний тухай “Би ганцаараа бүтээсэн юм биш” номд дуржжээ.

Сангийн яамны үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой тохиож буй өдрүүдэд энэ түүхэн хүний тухай дурсаж суугаадаа баяртай байна. Миний хувьд энэ хүний тухай хэзээ нэгэн цагт дурсамж бичнэ ээ гэж боддог байсан юм. Учир ийм юм аа.

Танилцсан нь

2011 он. “Өнөөдөр” сонины редакци. Нэгэн өглөөний шуурхай дээр социализмын үед Сангийн сайд байсан хүнтэй ярилцлага хийх тухай ярьж, ярилцах сэдэв нь Мянганы зам тул надад тэр үүрэг ирлээ. Яг үнэнийг хэлэхэд би ямар хүнтэй уулзах болсноо сайн мэдээгүй бөгөөд манайхан надад Ю.Цэдэнбалтай хамт ажиллаж байсан хүн гэснээс өөрийг хэлсэнгүй. Харин Гэрэл зургийн албаны Р.Чулуун ах “За Бэхээ минь чи их мундаг хүнтэй ярилцлага хийх боллоо. Мэдлэг боловсрол өндөр, айхавтар хүн бий. Би чамд гэрийн утсыг нь өгнө. Уулзахдаа үсээ задгай тавьж, сагсайж сэгсийлгэлгүй, ажил хэрэгч хувцаслаж очоорой” гэлээ. Би эхэндээ тоохгүй байснаа сүүлдээ айж эхлэв. Би хэнтэй уулзах гэж байгаа юм бол оо гэж. Ярилцлага хийх гэж буй хүнийхээ тухай хүмүүсээс судалж, асуулаа. Тэгээд утсаар нь яривал нэлээд хахир бололтой хүний дуу сонстож байна.

-Хэнтэй ярих вэ?

-Моломжамц гуайтай.

-Би байна. Яах гэж байгаа юм?

-Ярилцлага авах гэсэн юм аа.

-Юуны талаар?

-Мянганы замын талаар. /дуу нь жаахан зөөлөрлөө/

-Хүүхээ чи хэдэн жил сэтгүүлч хийж байна вэ?

-Жил гаран л болж байна.

-Маргааш манай гэрт хүрээд ир. Ирэхдээ бичсэн барьсан юм байвал авч ирээрэй. Утсаар яриарай.

Ингээд би Моломжамц сайдтай ярилцлага хийхийн тулд багагүй бэлтгэж билээ. Өөрийн бичсэн томоохон гэсэн нийтлэлээ хайчилж, асуултаа бэлтгэж, үс гээгээ ч анхаарав. Маргааш нь ▶▶

▶ гэрийнх нь гадаа очоод утсаар яривал тэрбээр гурван давхрынхаа тагтан дээр гарч ирээд, орцны түлхүүр өгснөөр тэдний гэрт анхлан зочилж билээ. Нэлээд хэдэн өрөө бүхий цэвэр цэмцгэр айл байв. Би эхэн үедээ яагаад ч юм сандраад байлаа. Тэд халуун өтгөн кофегоор дайлж, миний бичсэн нийтлэл, ярилцлагыг тоймлон харснаа нэлээд хэдэн асуулт асуув. Тэд удалгүй нэг жилийн туршлагатай ямар сэтгүүлч юм гэх байдал жаахан арилж, бидний “Мянганы зам Монголын хөгжлийн эх суурь болно” гарчигтай ярилцлага эхэлсэн юм. Тэрбээр Мянганы замыг ихэд дэмжиж, зам барьж байж хөгжинө гэсэн байр сууринаас өөрийн бодлоо ярьж билээ.

Үүнээс хойш хааяахан тэднийд очиж, Монголын болон дэлхийн эдийн засаг, нийгэм, хөгжлийн талаар ярьж суудаг боллоо. 80 насны босго давсан гэр бүлийн хоёр хоёулаа намайг очих бүрт шинэ санаатай угтана. Тэд Оросын телевизүүдийн цаг бүрийн мэдээг сонсоно. Орой нь үндэсний телевизийн мэдээг тогтмол үзнэ. Дэлхийн болоод Монголын цаг үеийн мэдээллээс хоцрохыг огтхон ч хүсдэггүй. Моломжамц сайд өдөрт хийх ажлынхаа хуваарийг гаргаад гэртээ ажилладаг байсан гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, номоо бичих, хийсэн бүтээснээ эмхэтгэх цэгцлэх, за тэгээд цаг үеийн чанартай эдийн засгийн асуудлуудад анализ хийнэ. Заримдаа төрийн түшээд, ялангуяа хуучнаар МАХН-ын удирдлагууд бодит амьдралтай холбоогүй зүйл ярьж, бодлого шийдвэр нь буруу байвал таягаа тулаад Төрийн ордны зүг харайна.

Нэг удаа Төрийн ордны ойролцоо тааралдахад ихэд бухимдангуй явж байлаа. “УИХ-ын гишүүд буруу юм яриад байна. Улс орон ард иргэдийнхээ эрх ашгийг хамгийн эхлээд бодолцох ёстойг би ойлгуулж тэдэнтэй уулзахаар явж байна” гэж билээ. Улс орныхоо хөгжлийн төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэсэн энэ өвгөн буурал Сайдын үгийг орчин цагийн төр, засгийнхан нь сонсоод л нөгөө чихээрээ гаргадаг байх даа хэмээн бодогдоод хоцорсон. Тэрбээр өнөөгийн улстөрчдийг хараад үнэндээ дургүй нь хүрдэг байсан биз ээ. Мэдлэг боловсролтой хүн цөөн байна. Улс орныг зөв бодлогоор удирдахад эрдэм номтой, үнэнч сэтгэлтэй хүмүүс байх ёстой. Гэтэл одоогийн төрийн түшээд амьдрал мэдэхгүй учраас бодит амьдралд буухгүй бодлого, шийдвэр ярьж, гаргаад байна. Энэ нь улс орон, ард иргэдэд сайнаар нөлөөлөхгүй

гэнэ.

Бас нэгэн удаа намайг дуудав. Яваад очвол эхнэртэйгээ хоёулаа бухимдангуй сууна. Манайх шиг жижиг оронд ийм том бандгар жийпүүд ерөөс хэрэггүй. Өндөр хөгжилтэй орнуудад ч том жийп яваад байдаггүй. Учир нь том жийпүүд чинь эдийн засагт маш үрэлгэн, бензин их иддэг, тэгээд манайх шиг нарийн замд тохирохгүй шүү дээ. Том зай эзэлсэн, хотын агаарын бохирдлыг ихэсгэж, түгжрэл үүсгэхээс өөр ид шид байхгүй. Том бандгаруудыг бусад улс орныхон хөдөө гадаа явахдаа л унах гэж авдаг бол манайхан гоёоны, баянаа харуулах гэж худалдан авч байна. Гэтэл хажууд нь хүүхдүүд гудамжинд өлсөж, ядуурал ихэсч байна. Төрийн түшээд нь хүртэл унах юм. Ямар бодлого вэ гээд л ярьж гарсан юм.

Түүний нэгэн дурамжаас хүргэе.

...Сангийн сайдын ажлаа авсны дараахан Маршал Чойбалсан намайг дуудаж билээ. Үнэхээр их айж байв. Гэтэл хангайн хоёр, говийн хоёр аймаг, нэг аймгийн гурваас доошгүй сум, нэг сумын 3-4 баг, баг тус бүрийн 10-аас доошгүй айл өрхөөр орж, ажил амьдралтай танилцаж ир гэсэн даалгавар өгсөн. Бас нэгэн удаа Маршал Чойбалсан “Хөдөө орон нутгаар томилолтоор явахдаа хот айлын зүүн гэрт эхлээд орж бай. Тэнд ядуу хүмүүс амьдардаг. Баруун гэрүүд баячуулынх. Ядуу зүдүү айл өрх л улс орны амьдралын жинхэнэ тусгал байдаг юм. Ард түмэн яаж амьдарч байгааг чи илүү сайн харж ойлгох болно гэж билээ...

Энэхүү томилолт Моломжамц сайдын ард иргэдийнхээ амьдралыг илүү сайн ойлгох, бодит шийдвэр гаргахад ихээхэн үүрэгтэй аялал болсон нь ойлгомжтой. Тэгвэл өнөөгийн төрийн түшээд хөдөө орон нутгаар их явдаг. Гэхдээ ширээний бүтээлгээ солиорой, шинэхэн сайд ирж байна гэдэг утгаар хандаж, урьд нь бэлтгэсэн албан байгууллага, газар, айл өрхөөр ороод явдаг нь нууц биш ээ. Тэд төлөвлөгөөг зөрчөөд хөдөөгийн хамгийн ядуу айлаар орж байсан эсэхийг мэдэхгүй юм. Харин УИХ-ын сонгуулийн үеэр бол замдаа тааралдсан бүх л айлаар ордог байх л даа.

Моломжамцсайдын зүрхсэтгэл насан өөд болтлоо эх орныхоо төлөө цохилсон гэж боддог. Улс орон, ард иргэдийнхээ эрх ашгийг эн тэргүүнд тавьж ирсэн ясны төрийн зүтгэлтэн, үлгэр жишээ авахуйц, туршлага хуваалцахуйц олон зан чанар, мэдлэгтэй хүн байв.

Тэднийх нэг хүү, хоёр охинтой.

Хүүхдүүд, ач, зээ нар нь бүгд гадаадад амьдарч сурдаг. Тэр хоёр зун, эсвэл өвлийн утаатай үед байсхийгээд л хүүхдүүд рүүгээ явна. Ирэхдээ яаж Итали, Испани шиг хөгжих вэ, гарц юу байна, хөгжилтэй орнуудын бодлого, шийдвэрийг судалчихсан ирнэ. Үүнийгээ бусадтай хуваалцана.

Хүүхдүүдээ мэдлэг боловсролтой болгож, хүмүүжүүлэхийн төлөө тэд хамтдаа зүтгэсэн. Хүүхдүүдийн маань өнөөдрийн мэдлэг боловсролтой болж, сайхан амьдарч байгаа нь эхнэрийн маань л ач. Би чинь өглөө үүрээр шахам яваад шөнө лгэртээ ордог байлаа хэмээн гэрийн эзэн ярина. Моломжамц гуайг тэр өндөрлөгт хүрэхэд мэдээж эхнэрийн үүрэг, ухаан нөлөөлсөн нь ойлгомжтой. Төрийн том удирдлагуудын эхнэр ийм л хүн байдаг байх даа хэмээн би Цэрэн-Янжин эгчийг хараад төсөөлдөг байсан. Үр хүүхдүүдээ өсгөж, гэр орноо цэвэр цэмцгэр байлгаж, нөхрийнхөө болон өөрийнхөө хувцаслалт гадаад, дотоод үзэмж, боловсрол мэдлэгт анхаарах, нөхрөө ар гэртээ санаа зовохооргүй ажиллах бүх орчныг бүрдүүлэхийг хичээдэг байсан гэж ярьдаг байлаа. Ж.Цэрэн-Янжин эгчийн хувьд Эрхүү хотын Санхүүгийн дээд сургуулийг төгссөн. ЗХУ-д эх орны дайн эхэлсэн, дарийн үнэр үнэртсэн Эрхүүгийн хавар тэр хоёр насан туршийн амьдралаа эхлүүлжээ. Өөрөөр хэлбэл, тэд эх орны дайны саарал тэнгэр дор өлгийтэй охиноо тэврэн улсын шалгалтаа өгөхөөр гүйж явсан гэдэг.

Моломжамц сайд Ю.Цэдэнбалын тухай, түүний амьдралын сүүлийн он жилүүд, түүнийг хүнд өвчтэй байх үед эргэж очсон тухай, мөн түүний эхнэр Филатова, үр хүүхдүүдийнх нь тухай маш сонирхолтой яриа өрнүүлнэ. Сэтгүүлч хүний хувьд ярьсан бүхнийг нь тэмдэглэн авч гоё ном гаргах хүсэл бодол төрдөг ч би бичихгүй гэдгээ амласан юм. Тэрбээр сэтгүүлчдэд ярилцлага өгөх тун дургүй байсан. Худлаа үнэн юм хольж хутгаж бичдэг хүмүүс гэнэ. Нэг сонины сэтгүүлч гудамжинд тааралдаад ярилцлага авъя гэсэн чинь би Бэхээ сэтгүүлчид л өгнө гэж хэлсэн гэдэг. Үүнийг сонсоод их баярлаж билээ, би.

Хамгийн сүүлд би ой өнгөрч буй жаахан охинтойгоо тэднийд очиж билээ. Охиныг маань өвөр дээрээ суулган эрхлүүлж тоглоод л. Харин Цэрэн-Янжин эгч охиноо хоёр нас хүрэхээр нь тоо зааж эхлэх хэрэгтэй. Болж өгвөл хүүхдээ өөрсдөө өсгө. Өвөө, эмээ нар хэт эрхлүүлээд хүүхдээр наадаг юм гээд л амьдралын сургаал айлдана. Ийм л хоёр хөгшин амьдралын ▶


► сүүлийн жилүүдэд би орж ирж, тэдэнтэй санал бодлоо хуваалцаж, сонин сайхан ярьж, заавар, зөвлөгөө, сургаалыг нь сонсон сонсон, өдгөө ажил амьдралдаа хэрэгжүүлэхийг хичээн явна. Тэдний халуун дулаан уур амьсгал, зөөлөн харц, ухаалаг бөгөөд даруу зан чанар миний сэтгэлд хоногшжээ.

Өнгөрсөн зууны томоохон удирдагч Моломжамц гуайн зөөлөн халуун гар, сэтгэлийг би мартаггүй. “Өнөөдрийн залуучууд урагшаа тэмүүлэхийн хэрээр арагшаа хардаг байгаасай. Энэ бүх бэлэн зүйлийг эхийн хэвлийд байхдаа өөрсдөө бүтээчихсэн мэт ярих юм” хэмээн хэлсэн түүний үгээр энэхүү дурсамжаа өндөрлөе. ■

Улсын нэгдсэн төсөв

	орлого	зарлага
1948 он	277.1 сая төг	304.1 сая төг
1957 он	643.2 сая төг	600.3 сая төг
2011 он	5.8 их наяд	6.3 их наяд

Дипломат алба үүсэж хөгжсөний 100 жилийн ойд



Б.Энхмандах Доктор /Ph.D./

Нийгмийн хөгжлийн загвар ба Монгол орон

/Цуврал нийтлэлийн Оршил/

Өнөөдөр даяаршил гэдэг монголчууд бидэнд шинэ зүйл биш ээ. Мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжлөөр нөхцөлдсөн энэ үзэгдэл дэлхий дахиныг хамрахдаа өөрийн замд тааралдсан бүх зүйлийг өөрчлөн байгуулж байна. Даяаршил хөгжлийн түвшингээс үл хамааран улс орон бүхнийг хамарч, тэдгээрийн хүн ам, соёл, зан заншил, эдийн засаг, санхүүг бүхэлд нь хөдөлгөөнд оруулж, заримдаа хямралыг гинжин цуваагаар дагуулах боллоо.

2008 оны АНУ-ын банк, санхүүгийн хямрал халдварлаж, Ирланд, Португал, Грекийн цаашилбал, Италийн гэх мэтээр Евро бүсийн өрийн хямрал болон үргэлжилж байгаа бол Египт, Түнисээс эхэлсэн “Арабын хавар”-ын хувьсгал дарангуйлагчдын аранга болж, Хойт Африк, Ойрхи Дорнод, Баруун Азийг донсолгож байна.

Саяхнаас эрх чөлөөний эх орон АНУ-д “Уолл Стрийтийг эзлэх” хөдөлгөөн Нью-Йоркын Маннхейтаны санхүүгийн дүүрэгт олон мянган хүн жагссанаар эхэлсэн бол өдгөө энэхүү хөдөлгөөн АНУ-ын 100 орчим, дэлхийн 1500 гаруй хотод салбарлачихаад байна.

Хөгжингүй орнуудад үүсээд буй энэ шинэ үзэгдэл, үйл явц өнөөдөр дэлхий нийтийн анхаарлыг зүй ёсоор татаж, олон янзын тайлбарыг хийцгээж байна. Тэдгээрийн дотор BRICS /Бразил, ОХУ, Энэтхэг, Хятад, өмнөд Африк/ буюу

шинэ тутам хөгжиж буй эдийн засгийн орнууд ямар байр суурьтай байгааг авч үзвэл, Бразилийн Ерөнхийлөгч Дилма Роуссефф: “Бид тэмцэгчдийн хэлж буй үгсийг хүлээн зөвшөөрч байна” гэсэн бол Энэтхэгийн Ерөнхий сайд Манмохан Сингх “АНУ-д ажилгүйдэл өсч, Европын эдийн засаг хямарч байгаа нь тогтолцоо бүхэлдээ өөрчлөгдөх шаардлагатай гэдгийг харуулж байна” гэжээ. Харин Хятадын төрийн мэдлийн “Синьхуа” агентлаг “АНУ-ын эдийн засаг, улс төрийн тогтолцоонд зарчмын шинжтэй асуудал байгааг харуулж байна” хэмээн байр сууриа илэрхийлсэн байна.

Эдгээрээс үүдээд, уул уурхайн “тэсрэлт” болж, эдийн засгийн үсрэнгүй өсөлтөд хүрч буй Монгол Улсад байдал ямархан байгаа билээ гэж бодоход эрхгүй хүргэж байна. Манай “эдийн засаг, улс төрийн тогтолцоонд өөрчлөх шаардлагатай, зарчмын чанартай асуудал байгаа юу, үгүй юү” гэдэг асуудал зүй ёсоор гарч ирж байгаа юм.

Асуултад олонхи нь маш ойлгомжтой бөгөөд товчхон “Байгаа” гэж дуу нэгтэй хариулах биз ээ.

“Тэр байгаа юм нь юу вэ” гэж надаас асуувал, миний хувьд нийгмийн хөгжлийн үндэс болсон тогтолцооны гажуудал гэж хэлмээр байгаа юм.

Хүний эрх, улс төрийн эрх чөлөөг олж авахын тулд монголчууд бид 1990-ээд онд ардчилсан өөрчлөлтийг хийж, ►

► зах зээлийн эдийн засгийн замаар 20 гаруй жил хөгжиж ирлээ. Үр дүнд нь багагүй ололтод хүрснийг үгүйсгэхийн аргагүй ч гэсэн бидний хүрсэн нийгэм маань хүсэн хүлээсэн ардчиллын үнэт зүйлсийн маань нэгэн хэсэг болсон нийгмийн шударга ёс, тэгш эрхийн зарчим зөрчигдсөн “гажигтай” ардчилал болон өнөөдөр бидэнд харагдах боллоо. Үүнийг бид санаатай хийчихэв үү? Эсвэл, санамсаргүй, бодлогогүйгээсээ хийчихэв үү? Бодох л хэрэгтэй. Гэхдээ хариулт маш тодорхой бөгөөд ардчилал, эрх чөлөөний эх орон АНУ-ын хөгжлийн замыг үг үсэггүй хуулбарлан, чөлөөт зах зээлийн халуун мөрөөр хэв нэг явж ирсний үр дүнд ийм байдалд хүрчихлээ гэж хэлж болохоор байгаа юм.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд “...хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх” явдлыг Монголын ард түмний эрхэм зорилго, туйлын хүслэн болгон тунхаглаад, эдийн засгийн хэвшил нь “төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засаг” байхыг зааж өгсөн. Үүнээс үзэхэд, онолын хувьд Монгол Улс бүх нийтийн сайн сайхан нийгмийн хөгжлийн загвар буюу Европын нийгмийн хөгжлийн замаар замнахаар бодож, хууль, эрх зүйн үндсэн зохицуулалтууд нь хийгдсэн байгаа юм. Гэтэл бид Үндсэн хуулиа хэрэгжүүлэх явцдаа энэ замаасаа багагүй хазайжээ.

Ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн гэгдэх 20 гаруй жилийн хугацаанд бид эхний ээлжинд хүнс, барааны хомсдол, үнийн өсөлт, төсвийн алдагдал гэх мэт эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулах, шилжилтийн эхэнд зах зээлийн эдийн засгийн механизмуудыг хурдан бүрдүүлэхийг зорихдоо хүнээ, нийгмийн асуудлуудаа умартан, хөгжлийн загварын талаар огт бодолгүйгээр хөгжлийн урсгалд автан, чөлөөт өрсөлдөөний замаар явж, нийгмийн хөгжлийн илүү их алдаа эндэгдэлтэй замаар замнасаар ирсэн байна.

Үр дүнд нь Монголын нийгэм өнөөдөр нийгмийн гүнзгий ялгаварлалд автаж, нэг хэсэг нь буюу олонхи нь ядуу, нөгөө хэсэг буюу цөөнх нь хэт баян гэсэн хэн ч хүсэн хүлээгээгүй

тогтолцоонд хүрчээ.

ОУВС-гийн Монголыг хариуцсан ажлын хэсгийн ахлагч, Ази, Номхон Далайн газрын хэлтсийн дарга Стивен Барнетт манай орны эдийн засгийн өнөөгийн байдлын талаар саяхан өгсөн нэгэн ярилцлагадаа: “... Эдийн засаг өссөн ч ард иргэдийн аж байдал тэр хэрээр сайжрахгүй байгаа бөгөөд баян болон ядуугийн ялгаа бүр ихэссэн” гэсэн дүгнэлт хийсэн нь хоосон үг биш ээ.

Үүнээс үүдээд хүсэн хүлээж байсан нийгмийнхээ талаарх хүмүүсийн төсөөлөл бодит байдалтай зөрчилдөж, иргэдийн сэтгэл ханамж уналтад орж, олон нийтийн бухимдал газар авч, нийгмийн тэгш ёсон, шударга ёсны тухай хүсэл мөрөөдөл сэргэж, зарим тохиолдолд нийгмийн хувьсгалын тухай хуучны үзэл санаа хүртэл сэргэх аюул нөмөрч байгааг нуух хэрэггүй. Энэ тохиолдолд бид өнөөдөр хөгжлийн ямар замаар замнаж буйгаа дахин нэг бодож болгоон, засаж залруулах зүйлээ эртхэн засч сайжруулахын тулд нийгмийн хөгжлийн загварын талаар ерөнхий ойлголт авах, тэдгээрээс сонголтоо хийх цаг мөч бидэнд тулгараад байна. Үүнд улс төрчид төдийгүй эрдэмтэд, судлаачид, цаашилбал, иргэн хүн бүрийн санаа оноо чухал байх учиртай.

Өнөөдөр дэлхий нийтэд хамгийн түгээмэл хэрэглэгдэж ирсэн, хэрэглэгдэж байгаа хөгжлийн гол загваруудын талаар товчхон авч үзэж, түүн дотроос улс орныхоо хөгжлийг дэлхий нийтэд үлгэр жишээ болгож чадсан Хойт Европын буюу Умардын орнуудын хөгжлийн загварыг илүүтэй тодруулан, улмаар Монголын хөгжлийн загварын хамгийн ерөнхий дүр зургийг тодорхойлохыг зорьсон цуврал бодролоо уншигч олондоо өргөн барьж байна.

**Та бүхний оюуны мэлмий тунгалаг байх болтугай!
Стокгольм хот. 2011 оны 10 сар.**

Үргэлжлэл бий ■

Эдийн засаг, санхүү, бизнесийн нэвтрүүлэг



тун удахгүй...

Дэлхийн залуу удирдагч



Баруун гар талаас хоёр дахь нь Хавиер Гарсиа Мартинес.
Нийслэлийн 33 дугаар сургууль дээр

Монголын олон их, дээд сургуульд хэн багшлах юм бэ?

Дэлхийн залуу удирдагчдыг Монголд зочлох үеэр “Mongolian Economy” сэтгүүл Испанийн нанотехнологийн тэргүүлэх эрдэмтэн Хавиер Гарсиа Мартинестэй ярилцлага хийсэн юм.

Хавиер Гарсиа Мартинес нь Испанийн Аликантегийн Их сургуулийн Нанотехнологи, молекулын лабораторийн захирал, тэнхимийн гишүүн. Тэрбээр наноматериал, катализ болон эрчим хүчний сэдвээр олон нийтлэл туурвиснаас гадна 15 патентын эрхийг эзэшигч аж. Түүний хамгийн сүүлд “Нанотехнологийг эрчим хүчинд ашиглах нь” (2010), “Химийн элемент: Дэлхийн ирээдүйд химийн ухааны оруулах хувь нэмэр” (2011) номууд бичжээ.

Тэрбээр дэвшилт каталист технологийг арилжаанд гаргадаг, байгаль орчинд ээлтэй эрчим хүчний “Райв Текноложи” (Rive Technology) ХХК-ийг үүсгэн байгуулсан байна. Дэлхийн эдийн засгийн форумаас түүнийг 2009 оны залуу удирдагчаар шалгаруулж байжээ. Хавиер 2011 оноос эхлэн Шинэ технологийн ерөнхий зөвлөлийн дэд ерөнхийлөгчийн албыг хашиж байгаа. Европын 35-аас доош насны гарамгай химичдэд жил бүр олгодог Европ медалийг Хавиер 2005 онд, Европын залуу химичдийн Мөнгөн медалиар 2006 онд тус бүр шагнуулжээ. Түүнчлэн Масачусетийн Технологийн институтын “Technology Review” сэтгүүлийн шагналыг 2007 онд хүртсэн байна.

-Та “Райв Текноложи” компанийнхаа үйл ажиллагаанаас танилцуулна уу?

-Дэвшилт каталист технологийг ашиглан газрын тосыг цэвэршүүлж, ингэснээр нэг баррель түүхий газрын тосны тээвэрлэлтийн шатахууны өгөөжийг сайжруулдаг цэвэр эрчим хүчний компани юм. Масачусетийн их сургуульд сурч байх үед миний

бүтээсэн технологи нь уламжлалт зеолит каталистыг том гидрокарбон молекулд хүртээмжтэй болгосноор шингэн ба дизель түлшийн хэмжээг нэмэгдүүлдэг. Бид 47 сая ам.долларыг тэргүүлэх хөрөнгө оруулагчдаас босгосон бөгөөд Масачусет мужийн Кембридж, Нью Жерси мужийн Принсетон, Техас мужийн Хьюстон хотод 30 гаруй ажилтантай үйл

ажиллагаа явуулдаг.

-Нанотехнологи гэж чухам юу болохыг хамгийн энгийнээр тайлбарлаж өгнө үү?

-Нанотехнологи нь аливаа материалыг молекулын түвшинд бүтээх чадварыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, бид өвөрмөц шинж чанар бүхий цоо шинэ материалыг үйлдвэрлэх боломжтой гэсэн үг. Жишээ нь, илүү сайн чанарын нарны эрчим хүчний тэжээлийн элемент, салхины хөдөлгүүрийн сэнс, тээвэр болон барилгын салбарт хэрэглэх хөнгөн хайлшийг дурдаж болно. Нанотехнологийг мөн хорт хавдар өвчнийг илүү үр дүнтэйгээр оношлох, эмчлэхэд хүртэл ашиглаж байгаа жишээнүүд бий. Шинэ аж үйлдвэрийн хувьсгал хэмээгдэх болсон тодорхойлолтын эдийн засгийн боломж асар их. Нанотехнологийн салбарт нэг жилд олгогдох патентын тоо хэдэн мянгад хүрч байна. Түүнчлэн тус салбарын шинэ нээлтийг арилжааны олон чиглэлд ашиглан үйл ажиллагаа явуулдаг гарааны бизнесийн тоо ч эрс нэмэгдэж байна.

-Манай улсад уул уурхайн “бөөм” болж байна. Дэлхий монголчуудыг сонирхох боллоо. Уул уурхай хөгжилд хүргэх үү?

-Энэ асуултыг монголчуудад тавимаар байна. Та бүгд ямар нийгэм бүтээн бий болгохыг хүсэж байна вэ? Монголчуудад асар их байгалийн баялаг байна. Энэ нь том боломж боловч бас бэрхшээл мөн. Засгийн газрын зүгээс монголчууд ямар нийгэм бүтээхийг хүсэж байгаа талаар нийтийн хэлэлцүүлэг хийх хэрэгтэй гэж бодож байна. Учир нь та нар өөрсдөө л газар нутаг, агаар, ус болон амьдралаа шийднэ. Монгол Улс гайхамшигтай нүүдэлчний соёлын уламжлалтай. Байгалийн баялгийг хурдан ашиглаж, улс оронд хэрэгцээтэй байгаа дотоод бүтэц, үйлчилгээг бий болгож, эдийн засгийн өсөлтөд хүрэх боломж нээлттэй ч ногоон эдийн засаг, аялал жуулчлал, органик хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх тал дээр түлхүү анхаарах хэрэгтэй.

-Ногоон эдийн засаг дэлхийн шинэ чиг хандлага болж байна. Та ногоон эдийн засгийн талаарх өөрийн бодлоосоо сонирхуулахгүй юу?

-Монголчууд та бүгдэд байгалийн баялаг хэмээх гайхалтай сайхан бэлэг заяажээ. Энэхүү бүтээгдэхүүнээ шууд зарж борлуулж болно. Тэгвээс хямд тусна. Эсхүл байгалийн баялагтаа нэмүү өртөг шингээгээд борлуулах ▶

боломжтой. Цэвэр технологи гэж байгаа зүйл дээр нэмүү өртөг нэмж, улам үр өгөөжтэй болгохыг хэлнэ. Энэ нь хүмүүсийн амьдралд болон эдийн засгаа төрөлжүүлэхэд маш чухал үүрэгтэй. Цэвэр эрчим хүч гэдэг нь ерөнхий ойлголт. Үүнд цэвэр технологи, ус, органик хоол, салхи болон нарны эрчим хүч гээд олон зүйл багтдаг.

Ногоон эдийн засаг гэсэн ойлголт маш өргөн хүрээг хамардаг. Энэ нь эдийн засгийг төрөлжүүлж, үнийн тогтворгүй байдлын эрсдэлийг бууруулах боломж юм. Монгол Улсын хувьд эгзэгтэй асуудал мөн. Та бүгд ээс, нүүрсний үнийн хэлбэлзлээс ийм их хараат байж болохгүй. Эдийн засгийг төрөлжүүлэх сайн арга бол байгальд ээлтэй технологид хөрөнгө оруулах явдал юм. Тэгэхийн тулд боловсролоо дээшлүүлэх шаардлагатай.

Танай улс боловсролд зориулж ихээхэн хэмжээний төсөв гаргасныг би олж харсан. Үүний ихэнх нь дунд сургуульд зарцуулагдахаар төлөвлөсөн байна лээ. Байгалийн баялгаа зохистой ашиглахыг хүсэж байгаа бол танайд мэргэжлийн инженерүүд зайлшгүй шаардлагатай. Үүний тулд инженерүүдээ маш сайн сургах, бэлтгэх нь чухал юм.

Цэвэр технологийг нэвтрүүлэхэд хангалттай тооны бизнес эрхлэгчид хэрэгтэй. Тэд бүх төрлийн бизнес, үйлчилгээ үзүүлэх чадвартай тул, эдийн засгийг төрөлжүүлэхэд шүүмжлэлтэй ханддаг. Уламжлалт боловсрол хангалтгүй. Аж ахуй эрхлэлт харин чухал. Монгол Улсын эдийн засагт эцэс төгсгөлгүй олон арван боломж байна гэж би түрүүн дурдсан. Гэсэн хэдий ч танайд дотоодын аж ахуй эрхлэгчид зайлшгүй хэрэгтэй. Үүний тулд залуусыг зөв замаар сургах нь маш чухал юм.

-Манай улс 2.7 сая хүн амтай мөртлөө 200-гаад их дээд сургуультай. Гэсэн хэдий ч боловсролын хөгжил тийм ч сайн биш гэдэг. Танд ямар санагдаж байна вэ?

-Би өөрийнхөө боловсролын талаар ярихад маш сайн боловсрол эзэмших аз завшаан надад тохиосон. Испанид бага, дунд сургууль болон коллежи үнэ төлбөргүй байдаг. Дунд сургуулиа төгсөөд би Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан Америкийн Масачусетийн их сургуульд суралцахаар явсан. Миний суурь боловсрол маш сайн тавигдсан юм. Туршлагаас харахад боловсролын

байгууллагын тоо бус, харин чанар нь илүү чухал байдаг.

Танайд шүүмжлэлтэй хандах зүйл гэвэл энэ олон их, дээд сургуульд хэн багшлах юм бэ? Дэлхийн зэрэглэлд нийцсэн багш, профессортой байх хэрэгтэй. Ийм хүний нөөц танай улсад байхгүй бол авьяастанг тодруулах алхмыг хийх шаардлагатай. Инженер, аж ахуй эрхлэлийн чиглэлийн сургагчидтай болохын тулд боловсрол олгогчдынхоо авьяас чадварыг сайжруулахад анхаарлаа хандуулах ёстой. Монгол Улсын хувьд цөөн хүн амтай хэрнээ ийм олон их, дээд сургуультай байгаа нь хэр чанартай боловсрол олгодог бол гэдэгт эргэлзэж байна.

-Та манай хүүхэд залуучууд, оюутнуудын төлөөлөлтэй уулзсан. Залуучуудад хандан боловсролын чиглэл дээр ямар зөвлөгөө өгөх вэ?

-Манай онгоц өглөөний зургаан цагт Монгол Улсад газардсан. Тэгээд есөн цагт бид 33 дугаар сургууль дээр очсон.

Тэд бидний тухай

Монголд хөрөнгө оруулахад учирч болох улс төрийн эрсдэлүүд-III

"Mongolian Economy" сэтгүүл "Reaters" агентлагаас улирал тутам шинэчлэн гаргаж буй "Монголд хөрөнгө оруулахад учирч болох улс төрийн эрсдэлүүд" нийтлэлийг уншигчиддаа байнга хүргэдэг билээ. Энэ оны сүүлийн улирлын манай эдийн засаг, бизнесийн орчинд хийсэн дүн шинжилгээ бүхий нийтлэлийг хүргэж байна.

Газрын хөрсөн дороо асар их баялагтай Монгол Улс ирэх арван жилд дэлхийн хамгийн хурдтай эдийн засгийн өсөлттэй, өндөр хөгжилтэй орнуудын эгнээнд нэгдэх их замын гараан дээрээ ирээд байгаа билээ. Тэдний өмнө сайн, муу хоёр зам бий. Саудын Араб, Австрали, Чили шиг өндөр хөгжилд хүрэх эсвэл Нигери, Замбабие шиг үгүйрэн хоосрох гээд. Тиймээс гараанаас зөв гарч, шийдвэрлэх мөч тулгараад байна. Үүнд, ялангуяа Монгол шиг дэд бүтэц хангалттай хөгжөөгүй, буурай эдийн засагтай, уул уурхайн салбараа анхлан хөгжүүлэх

Дэлхийн залуу удирдагчдын хамгийн эхний очих газрыг дунд сургууль байсан нь монголчууд та бүгдийн талаар ихийг өгүүлсэн.

Монгол Улс залуусын орон юм байна. Ардчиллын түүхэн үед төрсөн хүмүүс л хамгийн үнэтэй баялаг юм.

Монголын залуусын нээлттэй, үзэл бодлоо илэрхийлэх байдал надад гүн сэтгэгдэл төрүүлсэн. Дэлхий дахины залуус шинэ бодит байдалд сэтгэл хангалуун биш байгааг бид харж байна. Испани, Чили, Израиль зэрэг оронд олон хүн гудамжинд гарч, жагсаал цуглаан хийсээр байна. Шинэ үеийнхэнд дуу хоолойгоо хүргэх боломжийг нь олгох туйлын чухал. Би тэдэнд хандаж хоёр зүйл хэлмээр байна. Нэгдүгээрт, та нар энэ улс орны ирээдүй, хоёрдугаарт, маш сайхан уламжлалтай. Өнгөрсөн түүх дээр тулгуурлан, ахмадуудынхаа үгийг сонсож, бүтээн байгуулах гэж зорьж буй улс орныхоо төлөө өөрийн гэсэн бодолтой байхыг зөвлөж байна.

-Танд баярлалаа! ■

гэж буй оронд гадаадын хөрөнгө оруулагчдын дэмжлэг туслалцаа, туршлага, техник технологийн дэмжлэг ихээхэн хэрэгтэй. Хөрөнгө оруулагчдыг татахын тулд хөрөнгө оруулалт, хууль эрх зүйн таатай орчин, улс төрийн тогтвортой, тодорхой байдал нэн тэргүүний чухал асуудал. Хөрөнгө оруулагчд хувьд энэ тал дээр Монголыг харьцангуй дээгүүр түвшинд үнэлдэг. Гэвч ирэх оны зургадугаар сард болох Парламентын сонгуультай холбоотой улс төрийн тодорхойгүй байдал хөрөнгө оруулагчдад болгоомжлол төрүүлсэн хэвээр байна. Ялангуяа өнгөрсөн намар Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах тухай асуудал босч ирсэн нь санаа зовних нэг ноцтой шалтгаан болсон. Тиймээс хөрөнгө оруулагчид Монголын Засгийн газар Орос, Хятад гэсэн хоёр том хөрш болон ард түмнийхээ шахалт шаардлагыг зохицуулахын зэрэгцээ хууль эрх зүйн тогтвортой орчин бүрдүүлж чадах эсэхийг тодорхой мэдэхийг хүсч, анхааралтай ажиглаж байгаа юм. Монголын улс ▶

▶ төрд гарч болох эрдсдэлүүдийг дараах байдлаар тоймиллоо.

Хөрөнгө оруулалт ба улс төр

Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг байгуулснаас хойш ердөө хоёр жилийн дараа өөрчлөлт оруулах талаар асуудал боссон нь гаднын хөрөнгө оруулагчдын санааг зовоож, ихээхэн эргэлзэхэд хүргэсэн. Монголын Засгийн газар 2008 оны сонгуулийн их хэмжээний бэлэн мөнгөний амлалтаа биелүүлж, орлогоо нэмэгдүүлэхийн тулд багагүй дарамт дор байгаа. Зарим улстөрч нь Оюутолгойн гэрээний асуудлаас болж, Ерөнхий сайдаа хүртэл огцрохыг шаардсан. Оюутолгой дээр үүссэн энэ асуудал өөр нэг томоохон орд болох Тавантолгойн ирээдүйд сүүдэр тусгаж болзошгүй. Тавантолгойг ирэх онд дэлхий зах зээлд IPO хийхээр төлөвлөөд байсан ч стратегийн хөрөнгө оруулагчийн сонгон шалгаруулалт хэзээ, хэрхэх нь тодорхойгүй байна. Хөрөнгө оруулагчид он дуусахаас өмнө асуудал нэг тийшээ болох байх гэсэн хүлээлтэй байгаа аж. Төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” компанийн зүгээс Лондон, Хонконг, Улаанбаатрын бирж дээр IPO хийнэ хэмээн мэдэгдсэн ч дээрх сонгон шалгаруулалтаас болоод хугацаа нь одоо хэр тодорхойгүй л байна. Одоо Монголын УИХ болон Засгийн газар УИХ-ын сонгуулийн тухай хууль батлах, шүүх тогтолцоондоо шинэчлэл хийх, Тавантолгойн хөрөнгө оруулагчийг шалгаруулах гээд тун завгүй ажиллаж байгаа учир үлдсэн богино хугацаанд энэ бүхнийг амжуулж чадах эсэхэд олон хүн санаа зовниж, эргэлзэж байна.

Хөрөнгө оруулагчид юуг анхааралтай ажиглах вэ

-Парламентаар орж буй шинэ хуулиудад ахиц гарч байгаа эсэх.

-Засгийн газар Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээгээ цаг хугацаанд нь гаднын хамтрагчдынхаа санаанд нийцүүлж, ард түмнээ сэтгэл хангалуун үлдээхүйц хийж чадах эсэх.

-Монгол руу чиглэх хөрөнгө оруулалтын урсгал хэр их байгаа. Өнгөрсөн арваннэгдүгээр сард л гэхэд олон улсын түүхий эдийн худалдааны “Trafigura” компани Монголын нүүрс, төмрийн хүдрийг экспортлохоор Хятадын “Oligo Partners”-тай хамтран компани байгуулсан.

-Монголын Засгийн газрын газрын ил тод бус байдал гаднын хөрөнгө оруулагчдад саад, чирэгдэл учруулж байгаа эсэх.


Баялгийн хараал

Монголын эдийн засгийн дан ганц уул уурхайгаас хараат байдал өөр нэгэн санаа зовоосон асуудал болж байгаагийн дээр инфляци, хүүгийн хэмжээнээс өсч байгаагаар “Голланд өвчин”-ий шинж тэмдэг хэдийнээ илэрч эхэлжээ. Эрх баригчид нь уул уурхайгаас орж ирэх баялгийг хэрхэн хуваарилах вэ гэсэн хэцүүхэн сорилттой тулгараад байгаа. Дээр нь ард иргэддээ сонгуулиар амласан мөнгөө тараахын тулд Оюутолгой,

бодлого инфляцийн дарамт үүсгэж байна хэмээн анхааруулсан.

Хүчирхэг нөлөө бүхий хөршүүд

Монголын 2.7 сая иргэний олонхи нь Хятад, Оросын нөлөө нэмэгдэж байна гэж санаа зовниж байгаа. Тавантолгойн баруун хэсэгт хөрөнгө оруулах эрхийг Хятад, Оросын талд давуу байдалтайгаар олгосон нь энэ айдсыг улам нэмэгдүүлсэн. Хятадын хувьд энэ оны эхний хагасын байдлаар Монголын экспортын 90 хувийг эзлэх болсноороо хэдийнэ ноёлж эхэлсэн. Монгол Улс түлш, эрчим хүч, тээвэрлэлт зэргээр Орос, Хятадаас илүү хараат болж байгаа нь уул уурхайн салбарын томоохон эрсдэл юм. Оросын хувьд



Тавантолгойн аль алинаас нь урьдчилаад төлбөр авчихсан байгаа.

Хөрөнгө оруулагчид юуг анхааралтай ажиглах вэ

-Монголын Засгийн газар уул уурхайн төслүүдээс орж ирж буй мөнгийг хэрхэн зарцуулж байна. Тус улс төсвийн Тогтворжуулалтын сан байгуулсан нь авууштай ч ард иргэддээ бэлэн мөнгө хавтгайруулан амласан нь сайшаахаар зүйл биш.

-Эдийн засгийн хурдтай өсөлт, инфляци, гадаадын хөрөнгө оруулалтыг хэрхэн зөв зүйтэй зохицуулж, эдийн засгаа бодитой өсгөж чадаж байгаа эсэх. Өнгөрсөн арваннэгдүгээр сард Олон улсын валютын сангаас Монголын эдийн засгийн хэт тэлэлттэй

дургүй нь хүрвэл крантаа хаагаад нефтийн нийлүүлэлттээ тасалчихдаг гэмтэй. Дээр нь Япон, Өмнөд Солонгос руу нүүрс гаргахын тулд Оросын төмөр замаас хараат байна.

Хөрөнгө оруулагчид юуг анхааралтай ажиглах вэ

-Хоёр хөршөөсөө хараат байдлаа багасгах тал дээр арга хэмжээ авч байгаа эсэх. Ойрын хугацаанд Монголын нүүрс болон бусад ашигт малтмалын гол зах зээл нь зөвхөн Хятад байна уу. Эсвэл өөр сонголттой хувилбар байна уу.

-Гадаадын хөрөнгө оруулагчид компаниуд, ажилчдын үүрэг оролцоонд эгдүүцэх, буруу зөвөөр ойлгох ард түмнийхээ хандлагыг зөрүүлэх тал дээр Засгийн газраас ямар арга хэмжээ авч байгааг түлхүү харах болно. ■



Д.Энхбатын булан

Цахим матаас

Хүмүүс вэб сайтуудад сэтгэгдлээ их бичдэг болжээ. Сайтууд ч үүнд их дуртай. Яагаад гэвэл бусдын сэтгэгдлийг уншиж сонирхох, нэмж бичих хүмүүс олон, энэ нь ч сайтын хандалтын тоог өсгөдөг. Заримдаа, ямар нэгэн нийтлэлд бичсэн сэтгэгдлүүд нь тэр нийтлэлээсээ ч илүүтэйгээр олны анхаарал, сонирхлыг татаж байгаа нь харагддаг.

Хэд хоногийн өмнө би твиттерт нэгэн жижиг санал асуулга явуулав. “Сайтад сэтгэгдлээ бичиж буй хүнээс и-мэйл хаягаа заавал бичихийг шаардах нь зөв үү?” гэж асуухад нийт 37 хариулт ирснээс 32 нь “Буруу: Нэр хаяг шаардах нь бидний эрх чөлөөг хааж буй үйлдэл”, тав нь “Зөв: Аноним сэтгэгдэл бол зохисгүй зүйл” гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл, асуултад хариулсан залуусын 85 хувь нь интернэт сайтад сэтгэгдлээ аноним бичих нь зохистой зүйл төдийгүй эрх чөлөөний нэг хэлбэр гэж хардаг юм байна.

Сайтуудад сэтгэгдлээ нэр хаяггүйгээр бичих нь үнэхээр бидний эрх чөлөөгөө эдэлж буй нэг хэлбэр үү? Эсвэл, энэ нь бидний айдсаа нууж, бухимдлаа тайлах гэсэн нэг арга уу?

Хүмүүс үгээ хэлчихээд нэрээ хэлэхээс болгоомжилж байна. Энэ бол эрх чөлөөний илрэл явч биш. Сэтгэгдлээ нэр хаяггүйгээр бичих, бусдыг харааж доромжлох, талцан маргалдах цахим “хөдөлгөөн” бол манай нийгэм дэх бухимдал, амь бөхтэй оршсоор байгаа айдсын нэг илрэл гэж би хардаг. Эрх чөлөөтэй хүн гэж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, хүсэл зорилгынхоо төлөө ухамсартайгаар явж буй хүнийг хэлдэг бус уу.

Бухимдал их байгааг бид бүгдээрээ мэднэ. Харин яагаад ийм айдас байсаар байна?

Айдас заавал улс төрийн шалтгаантай байх албагүй. Өөртөө итгэлгүй, нийгмийн байр сууриа олж чадаагүй, эсвэл өөрийн амьдралыг бусдын ивээл, тэтгэлэг, орчны нөхцөл байдлаас хэтэрхий хамаатуулж хардаг хүмүүс үргэлжийн далд айдастай амьдардаг. Бидний туулж ирсэн социалист тогтолцоо ч амьдралын энэ хэлбэрийг манай нийгмийн далд ухамсар, бараг соёл болгон ихэнхэд маань төлөвшүүлэн суулгасан. Нийгмийн энэ соёл маань одоо вэб сайтуудаар тод илрэн харагдаж байгаа бололтой.

Өнөөдөр бидэнд өөрийгөө зоригтой илэрхийлж, үзэл бодлоо уралдуулж, олны дунд өрсөлдөн амьдрах шинэ соёл тун дутагдаж байна. Манай боловсролын тогтолцоо ч хүүхэд, залууст ийм соёл, хүмүүжил олгох түвшинд хүрч чадаагүй л байна.

Твиттерт ирсэн нэг хариултад, энэ бол нөгөө л бид бүхний сайн мэддэг “тамын тогоон доторх мэт” амьдралын маань дүр төрх шүү дээ гэжээ. Үнэний ортой л үг. Нэргүй

сэтгэгдэл бичих дуртай хүмүүсийн ихэнх нь нийтлэлийн агуулга, утгыг хэлцэх бус, харин нэр нь дурьдагдсан хувь хүмүүсийг дайрч доромжилсон, хараасан байх нь элбэг. Ингэж нийтлэлийн агуулгыг бус харин хувь хүнийг авч хэлцэх нь ердийн нэг хов ярианаас хэтэрдэггүй, хэлцэж буй асуудалд ямар ч үнэ цэнэ нэмдэггүй билээ. Ийм байдал нь ихэнхдээ аноним бичигчийн өөрийн сул байдал, амьдралын бэрхшээлд бусдыг буруутгаж сэтгэлээ хуурч тайвшруулах гэсэн инстинкт үйлдэл байдаг гэсэн. Сэтгэл зүйн мухардлын ийм инстинкт үйлдлийг сэтгэл зүйч нар сайн мэддэг ажээ.

Хэдийгээр интернэт сайтууд олон нийтийн бодит бухимдлыг илэрхийлэх тавцан болж, тэдэнд стрессээ бага ч гэсэн тайлах бололцоо олгодог ч энэ нь манай нийгэмд тийм их хэрэгтэй үйл хэрэг огт биш болов уу. Яагаад гэвэл, хараал хэлж, бусдыг доромжилж, хэрэлдэж, стрессээ түр тайлж болох ч дараа нь тэр хүн улам их стресст орох гинжин урвалыг өөртөө үүсгэдэг. Мөн өөрийн стрессийг нийгэмд түгээдэг.

Бид зөвхөн эрүүлээр сэтгэж, хамтран хэлцэж, ажиллаж байж л амьдралаа өөрчилнө, нийгмийн бухимдал, стресстээ шийдэл олно. Интернэт сайтууд, мэдээллийн технологийн залуусыг чухам үүнийг л олж хараасай гэж би хүсч байна.

Хагас тэрбум гишүүнтэй Facebook сүлжээ гишүүдээ зөвхөн хууль ёсны нэр хаягаар нь бүртгэдэг, тэр нэрээрээ бусадтай ил тод харьцахыг шаарддаг. Шинээр түрэн гарч ирж буй Google+ сүлжээ ч мөн адил. Үүний шалтгааныг ойлгоход төвөггүй. Хэрвээ олон зуун сая гишүүнтэй эдгээр сүлжээнд хүн бүр аноним байдлаар бичиж эхэлбэл тэд тун удалгүй асар том цахим хогийн сав болж хувирна. Аноним мэдээллийн нийгмийн үнэ цэнэ маш бага, харин хор нөлөө нь их байдаг гэдгийг хүн төрөлхтөн туршлагаасаа сайн мэддэг болсон.

Социализмын үед нэр хаяггүй захиаг матаас гэж нэрлэдэг байсан юм. Яагаад гэвэл хүнийг хараагүй байхад араар нь муу хэлж, хууль хяналтын байгууллагад нууц бичиг илгээж, харсан үед нь инээж мэндэлдэг хүмүүсийг матаасчин гэдэг байсан. Тийм хүмүүс нийгмийн цөвүүн цаг, хэлмэгдүүлэлтийн он жилүүдэд олширч байсан гэдэг.

Олны өмнө үзэл бодлоо ил тод хэлэхээсээ айдаг, нэрийг нь мэдчих вий гэхээс эмээдэг хүмүүсийн бичсэн цахим матаасууд вэб сайтуудаар дүүрч байна. Энэ бол шинэ цагийн цахим ертөнцийн соёл огт биш. Монголын Интернэт хараал, доромжлолын тавцан биш, харин хүмүүсийг холбож оюун санааг нь нэгтгэсэн ертөнц байгаасай. ■

Фото дуранд

2011 оны дэлхийн шилдэг зургууд

Вашингтон хот, Цагаан ордон дахь нөхцөл байдлын хяналтын өрөөнд Осам бин Ладенг баривчлах ажиллагааны үеэр. Уг өрөө тухайн нөхцөл байдлыг шууд харуулах мониторингийн системтэй.




Гримсвотн галт уулын дэлбэрэлтээс үүссэн үнс нурам мөсөн уулыг бүрхжээ. 2011 оны тавдугаар сарын 26.




Израйлийн нууц ажилтан Палестин эмэгтэйн дүрээр бослогот оролцон Палестин босогчийг барих гэж байгаа нь. 2011 оны тавдугаар сарын 15.



Суданы төв экваторын бүсийн Терекакагаас холгүй байх нэгэн тосгонд Мундари овгийн үхэрчин залуу үхрийн шээсээр нүүрээ угаах байгаа нь. Африкийн бусад орны адил энэ нутагт усны хангамж тун муу. 2011 оны нэгдүгээр сарын 19.



Шинэ Зеландын Христчурч хотноо болсон 6.3 магнитудын аймшигтай газар хөдлөлтийн маргааш даржээ. Газар хөдлөлтийн улмаас галт тэрэгний зам ийн муруйсан байна. 2011 оны хоёрдугаар сарын 22.



Техасын Стравын ойролцоо болсон гал түймрийн үеэр уг зургийг авчээ. 2011 оны 4-р сарын 26



Хуан Рамирез Тижерина хэмээх уг эр гэр бүлийн эргэлт ирэх үеэр өөрийгөө цүнхэнд хийн шоронгоос оргох гэж байгаад хамгаалагч нарт баригджээ. 2011 оны долдугаар сарын 02.

Хирс хэмээх амьтны эвэр зах зээлд өндөр үнэтэй учраас их хэмжээгээр устгагдаж байгаа аж. Харин Дэлхийн зэрлэг амьтдын сангаас 1000 хирсийг шилжүүлэн нүүлгэх ажил хийж байгаа бөгөөд ийнхүү цэргийн нисдэг тэргээр зөөвөрлөж байна. 2011 оны арваннэгдүгээр сарын 8.



Японд болсон аймшигт газар хөдлөлтийн дараа Мияаги мужийн Сендайд өөрийн гэртээ унтаж буй настай эмэгтэй. 2011 оны гуравдугаар сарын 13.



Шинжээч бичиж байна

Өрнөдийн тухайд тогтворгүй, дорнодын тухайд тодорхойгүй



Л.Бямба /УМС компанийн эдийн засагч/


Манай сэтгүүлийн “Шинжээч бичиж байна” буланд Л.Бямба бичлээ. УМС компанийн эдийн засагч, Санхүүгийн зах зээлийн холбооны Боловсролын хорооны дарга тэрбээр бидний хүсэлтийн дагуу энэ удаагийн нийтлэлээ Америкаас бичиж ирүүлээ. Азийн хөгжлийн банкны Суурин төлөөлөгчийн газарт хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, тус

банкнаас хэрэгжүүлсэн Санхүүгийн салбарын чадаахыг бэхжүүлэх техник туслалцааны төслийн зохицуулагчаар тус тус ажиллаж байсан туршлагатай эдийн засагч юм. МУИС-ийн ОУХДС-ийн Англи, Америк судлалын бакалавр, Японы Васедагийн их сургуулийн бизнесийн удирдлагын магистр цолтой.

2011 он

Энэ онд дэлхийн эдийн засагт өрнөсөн үйл явдлууд хэдэн жилийн өмнөөс эхэлсэн шинэ хандлагыг улам бататгаж өгөв. Тухайлбал, хөгжилтэй орнуудын хөгжлийн эрч хүч суларсан, дэлхийн санхүүгийн хүндийн төв Ази руу шилжиж эхэлсэн, хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт дэлхийн өсөлтөд голлох хувь нэмэр оруулах болсон зэргийг дурдаж болно. Доорх зургаас сүүлийн 20 жилийн турш хөгжиж буй орнуудын дэлхийн ДНБ-д эзлэх хувь тогтмол нэмэгдэж ирсэн нь илт харагдаж байна.

Зураг 1. Дэлхийн ДНБ /их наяд ам.доллар/



Эх сурвалж: ОУВС, Standard Chartered

2011 онд дэлхийн ДНБ-ий өсөлт гурав орчим хувьтай байхаар байгаа нь 2010 онд 4.3 хувь байснаас буурсан үзүүлэлт юм. Хөгжилтэй орнуудын тухайд өнгөрсөн жил 3.1 хувь байсан бол энэ жил 1.6 хувь болж буурах төлөвтэй байна (ОУВС). Үүнд дэлхийн санхүүгийн хямралыг даван туулах идэвхжүүлэлтийн арга хэмжээний үр нөлөө суларч улс орнууд илүү хатуу бодлого баримтлах болсон, Японд хүчтэй газар хөдөлсөн, Ойрх Дорнодын улс төрийн тогтворгүй байдлаас газрын тосны үнэ өссөн, мөн АНУ, Европын өрийн

хямрал зэрэг шалтгаан хамгийн ихээр нөлөөлөв.

Харин хөгжиж буй орнуудын ДНБ-ийн өсөлт 2010 онд 7.3 хувь байсан бол 2011 онд 6.4 хувьтай гарахаар байна (ОУВС). Хэдийгээр уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах дээр өндөр байсан нь байгалийн нөөц баялаг ихтэй орнуудад сайнаар туссан ч, хөгжилтэй зах зээлийн эрэлт буурсан, мөн мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж эхэлсэн зэрэг нь сөрөг нөлөө үзүүлсэн гэж дүгнэж болохоор байна.

2012 оны төлөв

Ер нь аливаа орны эдийн засгийн гүйцэтгэл ямар байх нь үйлдвэрлэл, гадаад худалдаа, инфляци гэх мэт тухайн орны суурь үзүүлэлтүүд, төрийн зүгээс авч хэрэгжүүлж буй бодлого, мөн хэрэглэгчийн хүлээлт, итгэл гэсэн гурван хүчин зүйлээс хамгийн ихээр хамаардаг. 2011 оны дүнгээс харахад 2012 оны төлөвийг өрнөдийн тухайд тогтворгүй байдал, дорнодын тухайд тодорхойгүй байдал гэж ерөнхийлөн тодорхойлж болохоор байна.

Өрнөдийн буюу хөгжилтэй орнууд дотоод өрийн асуудлаар хэрхэн оновчтой шийдвэрт хүрэх, системийн хэмжээний өөрчлөлт оруулж чадах, эдийн засгийн уналтад оруулчихгүй байх эсэх нь анхаарах үндсэн асуудал. Учир нь суурь эдийн засгийн үзүүлэлтүүд сул, төр засаг нэгдсэн зөвшилцөлд хүрч, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ амжилттай болж чадах эсэх тодорхойгүй, мөн хэрэглэгчдийн хүлээлт муу байгаа юм. Улмаар санхүүгийн салбарын шинэ хямралд ч орж тогтворгүй байдал үүсэхийг үгүйсгэх аргагүй.

Харин хөгжиж буй орнуудын тухайд сонирхол татсан гол асуулт нь хөгжиж буй орнууд хэр зэрэг эсэргүүцэлтэй байж чадах вэ гэдэг болоод байна. Өөрөөр хэлбэл, өрнөдийн дийлэнх орон эдийн засгийн болон өрийн хямралд автсан байхад тэдгээрээс үл хамааран хөгжиж буй орнууд, тэр дотроо Хятад улс өөрийн эдийн засгийн өсөлтийг ▶

үргэлжлүүлж чадах эсэх нь чухал юм. Учир нь эдгээр орны суурь үзүүлэлтүүд харьцангуй сайн байгаа, мөн төрөөс арга хэмжээ авах шаардлагатай нөхцөлд хангалттай нөөц бололцоо бий. Зах зээлийн итгэл ч өндөр байгаа юм.

Олон улсын томоохон байгууллага, банкууд энэ оны болон ирэх жилийн эдийн засгийн өсөлтийг дараах байдлаар таамагласан байна.

Хүснэгт 1. ДНБ-ийн өсөлтийн таамаг 2011, 2012 онд, хувиар

	Дэлхий		АНУ		Евро бүс		Хятад	
	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012
ОУВС	3.6	4	1.4	2.2	1.1	1.6	9.3	9.1
Дэлхийн банк*	3.2	3.6	2.6	2.9	1.7	1.8	9.3	8.7
Fitch	3	2.4	1.7	1.8	1.6	0.4	9	8.5
Goldman Sachs	3	3.2	1.6	2	-1.6	0.1	9.1	8.6
Standard Chartered	3	2.2	1.8	1.7	1.5	-1.5	9.2	8.1

*2011 оны зургадугаар сард хийсэн таамаг

Эх сурвалж: дурдсан байгууллагуудын эдийн засгийн тайлан, 2011 оны 11-12 сар


Монгол

Манай орны хувьд 2011 оны эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг авч үзвэл зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш хамгийн амжилттай жил боллоо гэж дүгнэж болохоор байна. Тодруулбал, энэ оны гуравдугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад ДНБ-ий өсөлт 20 хувь давсан, төсвийн орлого нэмэгдэж, үлдэгдэл нь ДНБ-ий гурав орчим хувьтай тэнцэх нэмэх дүнтэй гарсан. Эдийн засгийн суурь үзүүлэлт хэр эрүүл байгааг харуулдаг матриксаас үзвэл боломжит долоон онооноос 5.3 оноо авсан байна.

Зураг 3. Монголын эдийн засгийн эрсдэлийн матрикс 2012 онд

Сөрөг үр дагавар	Өндөр	<ul style="list-style-type: none"> Төслийн алдагдал өндөр гарч, төсвийн тогтворгүй байдал үүсэх 	<ul style="list-style-type: none"> Хятадын банкны зээлийн хөөс хагарч санхүүгийн салбар тогтворгүй болж эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх 	<ul style="list-style-type: none"> Төр засаг тэлэх бодлого үргэлжлүүлэн хэрэгжүүлж инфляцийн түвшин өсөх
	Дунд зэрэг	<ul style="list-style-type: none"> Зээлийн олдоц муудаж, эдийн засгийн эргэлт саарах Чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх 	<ul style="list-style-type: none"> Валютын ханшны хэлбэлзэл нэмэгдэх Банкуудын хөрвөх чадвар муудах Томоохон хөрөнгө оруулалтын төслүүд дээр улс төрийн шийдвэр гарах 	<ul style="list-style-type: none"> Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурах ОХУ-аас импортлох түлшний үнэ нэмэгдэх
Бага	<ul style="list-style-type: none"> Манайд болон хөрш зэргэлдээ орнуудад халдварт өвчин эпидеми гарах Байгалийн гамшиг тохиолдох, цаг уурын онцгой нөхцөл үүссэн 	<ul style="list-style-type: none"> Сонгууль, улс төр, эдийн засгийн байдлаас хамааран үймээн самуун дэгдэх жагсаал цуглаан болох 	<ul style="list-style-type: none"> Дэлхийн эдийн засаг уналтад орох Гадаад худалдааны алдагдал нэмэгдэх 	
		Бага	Дунд зэрэг	Өндөр
Гарах магадлал				

Зураг 2. Макро эдийн засгийн эрүүл мэнд



Эх сурвалж: UMC Capital

2011 оны эцсийн гүйцэтгэлээр инфляциас бусад дээрх үзүүлэлтүүд сайн хэвээр гарах төлөвтэй байгаа бөгөөд ДНБ-ий өмнөх онтой харьцуулахад 15 орчим хувь болохоор байна. Гэхдээ инфляцийн түвшин арваннэгдүгээр сарын байдлаар өмнөх оныхтой харьцуулахад 10 орчим хувьтай байгаа тул бодит өсөлт тав орчим хувь болох нь.

2011 оны өсөлтийн чиг хандлага ирэх жил ч хадгалагдах төлөвтэй байгаа бөгөөд Монголын эдийн засгийн ирэх оны өсөлтийг олон улсын байгууллагууд өөдрөгөөр таамагласан байна.

Хүснэгт 2. ДНБ-ийн өсөлтийн таамаг 2011, 2012 онд, хувиар

	2011	2012
ОУВС	11.5	11.8
Дэлхийн банк	14.9	15.1
Азийн хөгжлийн банк	10	8

Эх сурвалж: дурдсан байгууллагуудын эдийн засгийн тайлан

Гэхдээ Монголын эдийн засаг багтаамж, хүчин чадлын хувьд жижиг хэвээр байгаа тул гаднын болон дотоодын бодлогын хүчин зүйлээс хамааран савлах нь хялбар байдаг. 2012 онд гарч болох дараах эрсдэлүүдийг тооцож, болгоомжтой хандах хэрэгтэй. ■



“Ногоон эдийн засгийн өсөлт” ТББ НОГООН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, бохирдол нь уламжлалт эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэх хатуу шаардлага тавьж байна. Хүн амын өсөлт, хотжилт, үйлдвэржилт, хэрэглээний өсөлтийн улмаас байгалийн нөөцийн хэрэглээ ба хог хаягдал нэмэгдэж, экологийн даац, чадавхаас давахад хүрсэн нь хүн төрөлхтний нийгэм, эдийн засгийн ололт амжилтыг эрсдэлд оруулж, хөгжлийн тогтворгүй байдалд хүргэж байна.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс “Ногоон эдийн засаг”, НҮБ-ын Үйлдвэрлэлийн хөгжлийн байгууллагаас “Ногоон үйлдвэрлэл”, НҮБ-ын Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комиссоос “Ногоон өсөлт”-ийн үзэл баримтлалуудыг дэвшүүлж, нийгэм, байгаль орчинд ээлтэй, тогтвортой эдийн засгийн хөгжлийг хангахыг чухалчилж байна.

2012 онд Рио-де-Жанейро хотноо болох “НҮБ-ын Рио+20” бага хурлаар дэлхийн цаашдын хөгжлийн хандлагыг “Ногоон хөгжил” болгох зорилт тавихаар бэлтгэж байгаа бөгөөд байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах, байгаль орчны бохирдлоос зайлсхийсэн, хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн тогтолцоог бий болгож, зохистой

хэрэглээг хэвшүүлж хөгжүүлсэн улс орон дэлхийн эдийн засгийн харилцаанд илүү үр ашигтай оролцох боломж бүрдэж байна.

Тиймээс дэлхийн эдийн засгийн энэхүү шинэ харилцаанд цаг алдалгүй ороход “Mongolian Economy” сэтгүүлийн дэргэдэх “Ногоон эдийн засгийн өсөлт” төрийн бус байгууллага хувь нэмрээ оруулах юм. Мөн “Ногоон эдийн засгийн өсөлт” төрийн бус байгууллагын гол зорилго нь “Mongolian Economy” сэтгүүл, www.mongolianeconomy.mn, “Economy” телевизийн студи болон бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд ногоон эдийн засгийн талаар мэдээ мэдээлэл өгч, байгальд ээлтэй хөгжлийг дэмжих замаар ногоон хөгжлийн үйлсэд гар бие оролцох болно оо. Манай ТББ-ын Удирдах зөвлөлд байгальд ээлтэй хөгжлийг ойлгож дэмжиж, хөгжүүлэх хүсэл эрмэлзлэлтэй хүмүүс орсон байгаа. “Ногоон эдийн засгийн өсөлт” ТББ-ын Удирдах зөвлөлийн даргаар “Эко-Ази” Дээд сургуулийн ерөнхий захирал Ц.Адьяасүрэн, гүйцэтгэх захирлаар “Mongolian Economy” сэтгүүлийн Эрхлэгч Д.Бэхбаяр нар томилогдсон болно. Удирдах зөвлөлийн гишүүдээс ногоон хөгжлийн талаарх сэтгэгдлийг нь сонслоо. ▶▶

-Та ногоон хөгжлийг юу гэж бодож байна вэ?**-Ногоон хөгжилд “Ногоон эдийн засгийн өсөлт” ТББ-ын оролцоо үүрэг юу байх вэ?**

► **Ц.Адьяасүрэн /“Ногоон эдийн засгийн өсөлт” ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга, “Эко-Ази” Дээд сургуулийн ерөнхий захирал/:**



-Дэлхийн хүн ам хурдацтай өсч байгаа нь зүй зохистой хэрэглээ, эдийн засгийн үр өгөөжтэй бодлого шаардаж байна. Уг шаардлага нь гурван “Э” гэх ойлголтыг шинээр бий болгож байгаа. Энэ нь “Эрс багасгах, эргүүлж ашиглах, эдэлгээ уртасгах” зэрэг юм. Манай орны хувьд энэ гурван ойлголт эртнээс нааш бидний энгийн амьдралд байсан ухагдахуун. Тэр дундаа эдэлгээ уртасгах тухайд арвин туршлагатай. Хамгийн энгийн жишээ гэхэд дээр үеэсээ хүн бүр тус тусын аяга, халбагатай явдаг байсан гэдгийг хэн хүнгүй мэднэ. Мөн эргүүлж ашиглах тал дээр олон уламжлал байгаа. Ахуй амьдралтай ойрхон жишээнээс дурдахад, ахад нь хийж өгсөн дээл жилийн дараа багадлаа гэхэд дүү нь өмсдөг. Элгэдсэн хойно нь малын нэмнээ хийдэг ч гэх юм уу. Эдгээр энгийн жишээнээс харахад л ногоон эдийн засаг гэдэг ойлголтын хөрс манайд байгаа гэдгийг харж болно. Харин өнөөдөр бид нэг удаагийн хэрэглээг илүүд үзэх болсон нь хэд хэдэн сул талыг бий болгоод байна. Тухайлбал, өртөг өндөртэй, чанарын шаардлага хангахгүй бүтээгдэхүүн гарах шалтгааныг зарим нэг талаараа бүрдүүлээд байгаа юм. Мөн маш их хэмжээний хог хаягдлыг бий болгож байгаа. Тэр их хаягдлыг хааш нь хаях вэ гэдэг асуудал гарч ирж байна. Гэхдээ зарим нэг хог, хаягдлыг эргүүлэн ашиглах шинэ технологийг гаднын орнууд

нэвтрүүлээд удаж байна. Харин ногоон эдийн засгийн гол ойлголт бол бага зардлаар ашигтай мөн байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал юм. Эс тэгвэл олон хүний өдөр тутмын хэрэгцээг л хангана гэхэд ихээхэн сөрөг үр дагаваруудыг бий болгоно. Байгалийн нөөц ч хүрэлцэхгүй. Тиймээс дэлхий нийт ногоон хөгжлийн зүг явж байгаа. Үйл ажиллагаа болоод орчин нөхцөл гээд бүх талын ойлголтыг энэ зүг хандуулж байна.

-Төрийн бус байгууллагын хувьд нэн түрүүнд хийх ёстой ажил бол олон нийтэд ногоон хөгжлийн талаар сурталчлах явдал юм. Энэ тал дээр “Mongolian Economy” сэтгүүлийн хамт олон ихээхэн үүрэг хүлээн ажиллана. Иргэний нийгмийн зүгээс энэ төрлийн төрийн бус байгууллага байгуулж байгаа нь ихээхэн сайшаалтай. Тиймээс бид өөрсдөө бусдад үлгэр дууриал болох учиртай юм. Өөрсдөө дэмий “Ногоон өсөлт” гээд л яриад байвал болохгүй. “Ногоон хөгжил”-д хувь нэмрээ оруулна гэдэг маш энгийн зүйлээс эхэлнэ. Тухайлбал, илүүдэл хэрэглээгээ хязгаарлах тал дээр анхаарах явдал юм. Ер нь ногоон хөгжил гэдэг шууд төрийн бодлогын түвшинд ярих бус эхлээд хүн бүр энэ талын ойлголтоо цэгцэлж үйл ажиллагаандаа тусгах нь илүү үр дүнтэй. Уул уурхайн салбар хурдтай хөгжиж байгаа өнөө үед бид “Ногоон эдийн засаг”, “Ногоон үйл ажиллагаа” гэдгийг хүн бүрт сурталчлах ёстой. Тэр дундаа миний дээр дурдсан гурван “Э”-гийн зарчмыг хүн бүр, албан байгууллага бүрд ойлгуулах нь чухал.

► **Ч.Батбаяр: /Эрчим хүчний газрын Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга/**



Уламжлалт эдийн засгийн ойлголтоос ялгаатай нь ногоон эдийн засаг зөвхөн эдийн засгийн өсөлтийг хангаад зогсохгүй мөн байгаль орчны тэнцвэрт байдал, хүрээлэн буй орчныг хамгаалах болон нийгмийн хөгжлийг тогтвортой байдлын зарчмуудтай уялдуулан цогцоор авч үздэг.

Хэрэглээний ач холбогдол болон байгаль орчинд үзүүлэх нөлөөгөөрөө хүн төрөлхтөнд хамгийн чухлаар тавигддаг эрчим хүчний найдвартай хангамжид өнөөг хүртэл зөвхөн шавхагдах нөөцтэй нүүрс, байгалийн хий, уран зэргийг ашиглаж ирсэн бол одоо нар, салхи, ус, газрын гүний эрчим хүчийг ашиглах нь нэгэнт бидний гарцаагүй ирээдүй болжээ. Мөн эрчим хүчийг хэмнэх, түүний алдагдлыг бууруулах нь ногоон хөгжлийн нэгэн салшгүй хэсэг юм. Цаашлаад хүнсний салбарт цэвэр байгалийн бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг

хангах нь ногоон эдийн засгийн өөр нэг суурь үзүүлэлт. 20-р зууны аж үйлдвэржилтийн үр дүнд бий болсон хүнсний бүтээгдэхүүнийг массаар үйлдвэрлэх нь тэдгээрийн жинхэнэ байгалийн шинж чанарыг сулруулсан юм. Тэгвэл өнөө үед химийн ямар ч бордоогүй жимс, ногоо, бэлчээрийн малын мах, химийн найрлагагүй бусад бүтээгдэхүүн үнэ цэнэтэйд тооцогдож байна.

-Байгаль орчинд ээлтэй аль ч салбарын технологи нэвтрүүлэгч хувийн хэвшлийг дэмжих, тэдний үйл ажиллагаа явуулахад эрх зүй, эдийн засгийн таатай орчинг бий болгохын тулд төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах замаар тухайлбал, нийслэлийн агаарын бохирдол гамшгийн хэмжээнд хүрээд байгааг багасгах, зогсоох, улмаар Монгол Улсад ногоон зах зээлийг дэлгэрүүлэхэд ТББ-уудын оролцоо чухал. Тиймээс манай “Ногоон эдийн засгийн өсөлт” ТББ ногоон хөгжлийн ирээдүйд тодорхой чиглэлүүдээр ажиллаж хувь нэмрээ оруулна гэж найдаж байна. ►►

С.Дэмбэрэл / МҮХАҮТ-ын дарга/:



Засгийн газрын мөрийн хөтөлбөрт 2030 он гэхэд Монгол Улс ногоон эдийн засгийн суурийг тавина гэсэн ганц өгүүлбэр орсон. Түүнээс биш, ямар нэгэн бодлогын баримт бичигт тусаж чадаагүй байгаа. Одооноос л ногоон эдийн засгийн асуудлыг ярьж эхлэхгүй бол оройтлоо. Ийм үед “Ногоон эдийн засгийн өсөлт” ТББ байгуулагдсан нь цаг үеэ олсон асуудал юм. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн ногоон эдийн засаг бол тогтвортой өсөлт гээд хэлчихлээ. Өнөөдрийн манай эдийн засгийн өсөлт ногоон биш хүрэн бөгөөд тогтвортой биш байна.

Байгаль орчны доройтол амьжиргааны түвшин, эрүүл мэнд рүү орчихлоо. Ногоон эдийн засгийн өсөлтийг тайлбарлах, олон нийтийн сонирхолд хүргэх, улстөрчдийн сонирхлыг татах хэрэгтэй байна. Танхим ногоон эдийн засгийг хөгжүүлэх хүрээнд “Таван 20”-ын зарчмыг гаргаж ирсэн. Энэ талд хамтарч ажиллах нь чухал.

Одоо дотоодын нийт бүтээгдэхүүн өслөө гээд л баярлаад байна. Гэтэл энэ бүтээгдэхүүн үнэхээрийн чанартай байж чадаж байна уу? Хариу олох ёстой. Эхлээд

чанар гэж юу вэ гэдэг асуултад хариулах хэрэгтэй. Энэ ойлголт нь нөгөө л байгаль орчинд ээлтэй, эрүүл мэндэд хор нөлөөгүй гэсэн ногоон хөгжилтэй холбогдоно. Тэгэхээр ногоон хөгжил нь бүх салбар хоорондын уялдаа холбоо юм. Олон судалгаанаас харж болно. Манай орны хувьд байгаль орчны доройтол газар авсан. Эрүүл мэндийн хувьд архаг таван өвчин хүн амын 90 хувийг зовоож байна. Ой мод устаж цөлжилт ихэссээр. Гарц нь юу байх вэ. Ногоон эдийн засаг гэдэг ойлголтыг яаралтай ажил хэрэг болгох нь л хамгийн чухал ач холбогдолтой.

Өнөөдөр монгол хүн бүр Засгийн газар ч тэр байгалиасаа л аваад байгаа боловч өгөхгүй байна. Төр татвар авах замаар их мөнгө олдог мөртлөө байгальдаа эргээд хөрөнгө оруулалт хийхдээ маш бага 10 хүрэхтэй үгүйтэй хувийг зарцуулдаг. Энэ бүхний ард маш чухал нэг асуудал дутагдаад байна. Энэ нь бидний хамгийн сайн мэдэх тогтвортой хөгжил болоод олон талын оролцоо юм. Гэтэл өнөөдөр байдал эсрэгээрээ байна шүү дээ. Тиймээс л бид хөгжихгүй байна. Дээрх хоёр ойлголтыг нэгтгэвэл “Ардчилсан өсөлт” гэдэг шинэ ойлголт гарч ирнэ. Өөрөөр хэлбэл, хүмүүс өөрсдөө эзэн нь байж баялгийг бий болгоно гэсэн үг. Ийм баялаг л ирээдүй хойч үеийнхэнд ашиг тусаа өгнө.

Ш.Ханзельманн /ГОУХАН-ийн Түүхий эд иж бүрэн санаачлага хөтөлбөрийн захирал/:



-Ногоон эдийн засаг гэж тогтвортой болон байгаль орчинд ээлтэй хөгжлийг уялдуулан нийцүүлэх арга замаар ард түмний амьдралыг дээшлүүлэх боломжтой эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөвийг хэлнэ. Сонгодог эдийн засгаас ялгаатай тал нь жишээ нь байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үүсч гарах байгаль орчин ба нийгэмд учруулах хор уршгийн зардлыг тооцоход оршино. Өөрөөр хэлбэл, байгууллагууд үнэлгээ өгнө. Агаарын бохирдол, хөрсний элэгдэл зэрэг гадаад зардлыг үнэлснээр эдийн засгийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг үр дагавар болон шууд бус үр нөлөөг эдийн засгийн бодлогод шингээж, анхааралдаа авах бүрэн боломжтой болно.

Сэргээгдэх эрчим хүч, ногоон барилга байгууламж, цэвэр тээвэр, ус ба хог хаягдлын менежмент зэрэг төр болон хувийн хэвшлийн аль алинд нь тулгарах асуудлыг цогцоор шийдвэрлэх стратегийг боловсруулсан тохиолдолд ногоон эдийн засгийн хэрэгжилт амжилтад хүрэх юм. Ногоон нийгмийг бүрэлдүүлэн хөгжүүлэх шийдвэр цаашдын урт хугацаанд ашигтай бөгөөд үүний хэрэгжилт өндөр өртөгтэй болохыг ойлгох нь миний хувьд чухал юм. Ногоон эдийн засагт шилжихэд хамгийн орчин үеийн технологи, шинэчлэгдсэн бүтцийн хүрээ, шинжлэх ухааны сүүлийн үеийн нарийвчилсан судалгаа шаардлагатай. Бид ногоон болон тогтвортой хөгжлийн бодлогыг эдийн засгийн саад тогтвор мэтээр харахаа больж, харин эдгээрийг хэрэгжүүлснээр шинэчлэл, дэлхий нийтийн манлайллын гол түлхүүр мөн гэдгийг ухамсарлах хэрэгтэй юм.

-Монголын улс төр, нийгэм одоогийн байдлаар ногоон эдийн засгийн үйл ажиллагааны өгөөж, хэрэгцээн дээр анхаарлаа сайтар хандуулаагүй байгаа. Үүний зэрэгцээ Монголын эдийн засгийн өсөлтийн дийлэнх хувийг байгалийн баялгийн салбар бүтээж буй тул ногоон эдийн засагт шилжих нь улс орны ирээдүйн хөгжилд туйлын ач холбогдолтой болж байна. Манай “Ногоон эдийн засгийн өсөлт” төрийн бус байгууллага нь ард иргэдийг мэдээллээр хангаж, техникийн зөвлөгөө өгөх замаар эдгээр сэдвээр олон нийтийн ухамсрыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах болно.

Энэхүү эдийн засгийн шилжилтэд орох томоохон шаардлага хэрэгцээ нь сонгогч ба хэрэглэгчдэд түлхэц болно. Учир нь тэд ногоон эдийн засгийн авчрах үр ашиг болох шинэ ажлын байр, шинэ зах зээл болон аж амьдралын чанарт хэрхэн өөрчлөлт гарахыг мэдрэх болно.

Байгаль орчинд ээлтэй бус бизнесээс ашиг орлого олдог хүмүүст байгалийн нөөц баялаг болон байгаль орчны салбарын удирдах байгууллагуудад нэвтрэх боломж илүү хялбар байдаг. Тиймээс иргэний нийгэмд чиглэж ногоон хөгжлийн ач холбогдлыг ойлгуулах зайлшгүй хэрэгтэй юм. Ингэснээр тэд Засгийн газраас шийдвэр гаргах үйл явцыг улам илүү ил тод байлгахыг шаардаж эхэлж, гарч байгаа бодлого нь олон нийтийн өмнө хариуцлага хүлээсэн гэдгийг баталгаажуулах болно. Энэхүү зорилгыг идэвхтэйгээр дэмжин, манай ТББ нь ногоон ба тогтвортой бизнесийн гол дэмжигч болж, оролцогч талуудын дунд зуучлах үүргийг гүйцэтгэн, тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг хэлэлцэх болно. Манай төрийн бус байгууллага нь Монголыг ногоон эдийн засагт шилжин ороход хувь нэмрээ оруулахад бэлэн байна. ▶

► УИХ-ын гишүүн Д.Энхбат:



-Манайх олон зуун жилийн уламжлалаараа байгальд ээлтэй, аж ахуйг хөгжүүлж ирсэн. Харин одоо аж ахуйн хэлбэр өөрчлөгдөөд үйлдвэржээд, хотжоод байгаа бол социализмын үед төлөвлөгөөтэй явж ирсэн. Ерөнхий төлөвлөлт, улс орны хэтийн салбаруудын уялдаа холбооны асуудалд харьцангуй сайн түвшинд байж. Өнөөдөр Монгол зах

зээлийн эдийн засагт шилжээд 20 жил боллоо. Хүн болгон амьдрахын тулд өөр өөрийнхөө зүтгэсэн. Гахай үүрээд бизнес хийгээд эхэлсэн. Энэ зуршлаараа уул уурхайн салбарт хүч түрэн орж, газар ухаад эхэлсэн. Гэтэл энэ замбараагүй байдал нь байгаль орчин, нийгмийн амьдралд сөргөөр нөлөөлж байна. Монголд өнөөдөр ногоон эдийн засгийн тухай ойлголтыг дөнгөж л ярьж эхэлж байна. Ногоон эдийн засаг бол тусдаа эдийн засгийн нэг салбар биш үү дээ. Энэ чинь өнөөдрийн үйлдвэр, аж ахуй, уурхай, технологийн дараагийн түвшинд буюу байгальд ээлтэй ногоон хөгжлийн замд орох тухай яриа. Сэргээгдэх эрчим хүчний салбарт ногоон эдийн засгийн анхны оролдлогуудыг

хийж байгаа. Гэхдээ Монголын эдийн засаг бүхэлдээ хүрэн. Улам хүрэн болж байгаа. Хүрэн болох нь ногоон болохоосоо гурав дахин хурдан явж байна.

-Монголд өнөөдөр хүн болгон уул уурхайн тухай ярьж байна. Уул уурхайгаас цаашаа улс орон яаж явах юм бэ гэдэг асуудлаар ярьж байгаа нь тун цөөхөн. Ялангуяа хүн төрөлхтөн 21дүгээр зуунд өөр замаар явах тухай ярьж буй энэ үед монголчууд ямар замаар явах гээд байна вэ. Үүний гол чиглэл нь ногоон эдийн засаг. Ногоон эдийн засгийн талаар ярьж байгаа хүмүүсийн үзэл бодлыг нэгтгэж, энэ талаар өөрийн тодорхой алхмуудыг хийж ажиллаж буй байгаа хамтын ажиллагааны байгууллага их чухал. Тийм учраас "Ногоон эдийн засгийн өсөлт" төрийн бус байгууллага ногоон эдийн засгийн асуудлыг зэрэгцүүлж ярьж байгаа нь их чухал. Тус байгууллагын үйл ажиллагааг дүгнээд хэлбэл Монголын хөгжил зөвхөн уул уурхай биш ээ. Тогтвортой хөгжил юм. Дараа үеэ хохироохгүйгээр хэрхэн хөгжих вэ. Энэ маргааныг өдөөж, энэ талаар үзэл бодлоо уралдуулахад үйл ажиллагаагаа чиглүүлэх зорилготой байгуулагдсан байгууллага гэж үзэж байна. Мөн "MongolianEconomy" сэтгүүл ч энэхүү төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, ногоон хөгжилд гол хувь нэмрээ оруулна гэж бодож байна.

Б.Бямбасайхан /"Ньюком" компанийн гүйцэтгэх захирал/:



-Өнөөдөр Монголын эдийн засгийг хөгжүүлэхэд тогтвортой загвар шаардлагатай гэж хүн бүр ярьж байна. Тэр загвар нь миний хувьд ногоон эдийн засгийн хэлбэр байх болов уу гэж бодож байна. Монголд дэд бүтэц, уул уурхай, аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхдээ бид хамгийн орчин үеийн дэвшилт технологийг, өөрөөр хэлбэл

хамгийн бага эрчим хүч зарцуулдаг, хамгийн их үр ашигтай тийм технологийг Монголд оруулж ирж нутагшуулаад, үйлдвэрлэлийнхээ процессыг явуулбал манай эдийн засаг тогтвортой байна гэсэн үүднээс харж байна. Сэргээгдэх эрчим хүчний асар их нөөц Монголд байгаа. Тэр нөөцийг эдийн засгийн эргэлтэд нэн даруй оруулах шаардлагатай. Хоёрдугаарт, сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалт хийхэд шаардагдах эрх зүй, бодлого, санхүүгийн дэмжлэгийн орчныг бий болгох юм бол Монголд зөвхөн цөөхөн хүн биш, олон хөрөнгө оруулагч энэ салбарт хөрөнгө оруулах боломжтой юм.

Нөгөө талаас эрчим хүчний зохистой хэрэглээ, үр ашигтай зохицуулалт гэсэн томъёолол бий. Эрчим хүчний хэмнэлт нь манай эдийн засгийн суурь ойлголт болох хэрэгтэй юм. Өнөөдөр Монгол Улс ДНБ-ий нэг нэгжийг гаргахад дэлхийн дунджаас гурав дахин илүү эрчим хүч

зарцуулж байгаа. Тэгэхлээр энэ нь хэрэглэгчид тухайн бараа бүтээгдэхүүн, бараа үйлчилгээ гурав дахин үнэтэй очиж байна гэсэн үг. Цахилгааны үнэ бага болохоор манай дундаж түвшний айл бүр бүх өрөөнийхөө гэрлийг асаалттай хаядаг. Энэ нь эдийн засгийн их хаягдал үүсч байна гэсэн үг. Тэгэхээр гэрийнхээ чийдэнг сүүн гэрэл буюу эрчим хүчийг 80 хувиар бага зарцуулдаг технологиор солих тохиолдолд хэмнэлт гарч, эдийн засагт ч сайн нөлөө үзүүлнэ. Эдийн засгийн чадавч сайжирна гэсэн үг. Хувь хүний, тухайн айл өрхийн өөрийн санхүүд ч бас хэмнэлт гарна. Энэ бүхнээ тооцвол эрчим хүчний үр ашигтай зарцуулалтыг өдөр тутмын амьдралд хэрэгжүүлэх хэрэгтэй. Энэ бол манай эдийн засгийн өсөлтийн тулгуур ойлголт байх ёстой.

-Ер нь зөв ойлголтыг хүмүүст хүргэх шаардлагатай байна. Монголын өнөөдрийн бизнесийн орчинд ойлголтын зөрүү гэдэг том бэрхшээл байна. Энэ зөрүүг хүмүүст ногоон эдийн засаг гэж юу вэ, яагаад үүнийг хийх шаардлагатай, яагаад өсөлт тогтвортой байх ёстой, яагаад эдийн засгийн чадавч сайтай байх ёстой гэдэг талаар зөвөөр ойлгуулах нь хамгийн чухал байна. Гэхдээ хэн нэгэн дарга гарч ирээд, уриа лоозон хэлээд бүтэхгүй. Харин бодит амьдрал дээр тулгуурласан жишээн дээр тайлбарлавал хүн өөрөө хүлээж аваад, практик дээр хэрэглэх боломжтой. Тэгэхлээр энэхүү ойлголтын зөрүүг арилгахад манай "Ногоон эдийн засгийн хөгжил" ТББ их үүрэг гүйцэтгэнэ гэж бодож байгаа. ►

► **З.Батбаяр/ Усны газрын орлогч дарга/:**



-Ногоон эдийн засгийг ихээхэн өргөн хүрээнд ойлгож байгаа. Хэрвээ товчхон хэлбэл, эдийн засаг нийгмийн хөгжил нь экологийн баримжаатай байж, ус болон байгалийн нөөцөд тулгуурласан төлөвлөлтийн үндсэн дээр нийгэм эдийн

засгийг удирдахыг хэлнэ гэж ойлгож байна. Энэхүү ТББ-ыг байгуулснаар ногоон эдийн засгийн талаарх ойлголтыг нэгтгэж, төр, засгийн бодлого нь ногоон эдийн засаг гэж тунхаглах биш харин хэрэгжүүлдэг болоход хувь нэмрээ оруулна гэж бодож байна.

И.Отгонжаргал /"Mongolian Economy" сэтгүүлийн орлогч эрхлэгч/:



-Ногоон эдийн засгийг илүү ойлгодог, одоолхөгжүүлэхгүйбол Монголоройтлоо гэж санаа нь зовдог, сэтгэл зүрх нь шаналдаг салбар салбарын хүмүүсээс манай төрийн бус байгууллагын Удирдах зөвлөл бүрдсэнд би хувьдаа их баяртай байгаа. Ногоон эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх байр суурин дээр зогсох учиртай усны салбарыг сайн мэдэх Усны газрын орлогч дарга Ч.Батбаяр, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр Бямбасайхан, З.Батбаяр захирал байх жишээтэй. МҮХАҮТ-ын С.Дэмбэрэл дарга, Д.Энхбаят гишүүн, Адьяасүрэн захирал нарыг энэ чиглэлээр байнга хэлж ярьдгийг олон хүн мэднэ. Түүнчлэн "ХасБанк"-ны

гүйцэтгэх дэд захирал асан Л.Төр-Од байгаа. Тэрбээр Монголд ногоон эдийн засгийн чиглэлээр мэргэжлийн түвшинд ярих цөөхөн хүний нэг. Мөн ногоон хөгжлөөрөө дэлхийд тэргүүлэгч ХБНГУ-ын Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн хөтөлбөрийн захирал хүн ч манай Удирдах зөвлөлд багтсан. Ийм мэргэжлийн түвшний, сэтгэл, зорилго нэгтэй баг бүрдсэн учраас "Ногоон эдийн засгийн өсөлт" ТББ-ын туулах зам урт, хийх ажил их бий.

Монголд "ногоон" нэртэй байгууллага олон ч хийж хэрэгжүүлж байгаа нь харьцангуй цөөхөн байдаг. Тийм болохоор манай төрийн бус байгууллага нийгэмд өргөн далайцтай, олон нийтийн санаа бодолд ногоон сэтгэхүйг суулгахуйц бодитой үйл ажиллагаа явуулах болно оо.

Д.Бэхбаяр/ Ногоон эдийн засгийн өсөлт ТББ-ын гүйцэтгэх захирал/:



-Дэлхий дахины шинэ хандлага ногоон хөгжлийн талаар улс орнууд нэлээд хүчтэй ярьж, бодлого шийдвэртэй түлхүү тусгаж, өөрөөр хэлбэл, тогтвортой хөгжлийн түлхүүр болсон ногоон хөгжилд ихээхэн анхаарч байна. Харин манай улс уул уурхай түшиглэн хөгжих тухай ярьж байгаа. Байгалийн баялгаа зөв бодлогоор ашиглаж хөгжих нь мэдээж нэн тэргүүний асуудал. Гэхдээ үүний хажуугаар ногоон хөгжлийг уул уурхайгаас дутуугүй ярьж, дэмжиж ажиллах зайлшгүй шаардлагатай байна.

Байгальд ээлтэй хөгжлийг дэмжиж ажилласан, ногоон

технологийг нэвтрүүлсэн үйлдвэр компани, хувь хүнийг тодруулан гаргаж ирж, мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах замаар олон нийтийн бодол санаа сэтгэхүйд ногоон хөгжлийг суулгаж өгөх чиглэлээр манай ТББ түлхүү ажиллах юм. Өөрөөр хэлбэл, дэлхийн улс орнууд ногоон эдийн засгийг хөгжүүлэх чиглэсэн ямар арга хэмжээнүүд авч байгаа, ногоон хөгжлийн туршлага, Монгол улс ямар бодлого явуулж байгаа талаарх мэдээ мэдээллийг "Mongolian Economy" сэтгүүл, www.mongolianeconomy.mn, сайт, "Economy" TV студиэр дамжуулан олон нийтэд хүргэх зорилготой ажиллах юм. Тэгэхээр манай улсын хувьд дөнгөж ярьж эхэлж байгаа ногоон эдийн засгийн хөгжилд манай ТББ тодорхой хэмжээнд нэмрээ оруулах болно оо. ■



НҮБ-ын тогтвортой хөгжил сэдэвт бага хурлын тухай

Үндэслэл

НҮБ-ын “Тогтвортой хөгжил” сэдэвт бага хурал Ерөнхий Ассамблейн 2010 оны гуравдугаар сарын 31-ний 64/236 тоот шийдвэрийн биелэлтийг хянах зорилгоор зохион байгуулагдаж байна. Уг бага хурал 1992 оны НҮБ-ын “Хүрээлэн буй орчин, Хөгжил” сэдэвт бага хурлын 20, 2002 оны “Тогтвортой хөгжил” сэдэвт дээд хэмжээний уулзалтын 10 жилийн ойг тус тус тохиолдуулан 2012 оны зургадугаар сарын 20-22-нд Бразил улсын Рио-Де-Жанейро хотноо зохион байгуулагдана. Бага хурлын хүрээнд улс гүрнүүдийн Ерөнхийлөгч, Засгийн газрын тэргүүн зэрэг тухайн орны хамгийн өндөр албан тушаалтан болон холбогдох төлөөлөгчдийг оролцуулахаар зорьж байна.

Бага хурлын зорилт

Бага хурлын шийдвэрээр тогтвортой хөгжлийн төлөө улс төрийн үүрэг даалгаврыг шинэчлэн найруулахаар зорьж байна. Мөн тогтвортой хөгжлийн төлөөх бусад томоохон уулзалтуудын шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилготой.

Хурлын хүрээнд нэгдүгээрт, тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах зорилгын хүрээнд ногоон эдийн засгийн асуудал хоёрдугаарт, тогтвортой хөгжлийн төлөөх институционал ажлын хүрээ гэсэн хоёр үндсэн сэдэв дээр голлон хуралдах ажээ.

Бэлтгэл ажил

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 64/236, 65/152 шийдвэрүүдийн дагуу уг бага хурлын өмнө гурван бэлтгэл хурал зохион байгуулахаар шийдсэн бөгөөд эдгээр нь 2010 оны тавдугаар сард эхний хурал, 2011 оны гуравдугаар сард хоёр дахь нь болсон бөгөөд гурав дахийг үндсэн бага хурлын өмнөхөн зохион байгуулахаар шийдвэрлээд байна. Үүнээс гадна дээрх гурван хурлын дундах уулзалтууд ч хэдийнэ болсон байна.

Эхний бэлтгэл хурлаар бүс нутаг бүрээс хоёр төлөөлөгч байхаар 10 гишүүнтэй хороо байгуулагдсан бөгөөд үүн дээр Бразил улсыг төлөөлж нэг гишүүн сонгогдсон. Тус хороо хурлыг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах үүрэгтэй юм.

Харин Монголд

Дээрх хурлуудын 20 жилийн ойн хүрээнд хийж буй ажилтай холбогдуулан Монголын төрөөс ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, тогтвортой хөгжлийн бодлого зорилтыг хэрхэн тодорхойлсон, хүрээлэн буй орчин, байгаль хамгаалах, байгальд ээлтэй хөгжлийг дэмжих чиглэлээр ямар бодлого, үйл ажиллагаа явуулж байгаа талаарх мэдээ мэдээллийг бид энэхүү булангаараа дамжуулан хүргэх болно. Мөн ирэх онд болох “Рио+20”-ийн хуралд Монгол Улс хэрхэн бэлтгэж байгаа талаар байнга сурвалжлан хүргэхээр төлөвлөж байна. ■



Фотог Э.Зоригт

Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн дарга Б.Болдтой хийдэг цуврал ярилцлагын энэ удаагийн сэдэв Тэтгэврийн сангийн талаар өрнөлөө. Өмнө нь бид мэргэжлийн хөрөнгө оруулагчдын тухай ярилцаж байсан билээ. Сэтгүүлийн анхны дугаараас эхлэн хөрөнгийн зах зээлийн талаар манай уншигчдад тодорхой ойлголт өгөх, оюуныг цэнэглэхэд чиглэсэн ярилцлагуудыг цаг заваа гарган байж өгдөг Болд захиралд “Mongolian Economy” сэтгүүл болон уншигчдынхаа өмнөөс маш их талархсанаа илэрхийлье.

Энэхүү цуврал ярилцлагууд дараа жил ч үргэлжлэн уншигч танаа хүрэх болно оо. Хөрөнгийн зах зээлийн талаар мэдлэг өгсөн дээрх цуврал ярилцлага хүмүүст хүрч байгааг бид харахдаа баяртай байдаг. Олон уншигчаас сэтгэгдэл ирдэг. Зарим компанийн удирдлага Болд захиралын ярилцлагатай сэтгүүлийг уншиж мэдэх, ойлголт авах үүргийг ажилтнууддаа өгдөг гэсэн. Үнэндээ манайханд хөрөнгийн зах зээлийн талаар өргөн мэдлэг мэдээлэлтэй болох зайлшгүй шаардлагатай тулгарч байгаа учраас тэр юм.

Таны мэдлэгт

Б.Болд: Залуучууд ирээдүйд тэтгэврийн хуримтлалаа өөрсдөө бүрдүүлэх хэрэгтэй

-Тэтгэврийн сангийн талаар манай уншигчдад энгийнээр тайлбарлаж өгнө үү?

-АНУ-ын Калифорн, Техас зэрэг мужид хамгийн том тэтгэврийн сангууд бий. Өөрөөр хэлбэл, хувь хүний хөрөнгийн хуримтлалыг бий болгох зорилгоор тусгай мэргэжлийн хүнээр тухайлбал, хөрөнгө оруулалтын сангийн менежерээр удирдуулсан төрөл бүрийн тэтгэврийн сангууд байдаг. Ер нь яагаад тэтгэврийн сан үүсэх болсон, мөн яагаад АНУ-д ийм үр дүнтэй хөгжиж байна гэхээр тус орны төрийн татварын бодлого гэж бий. Энэ нь тодорхой наснаас өмнө тухайн жилдээ тэтгэврийн сан руу оруулсан мөнгөнийх нь жилдээ 15-20 мянган ам.доллар гэдэг юм уу татвараас чөлөөлөгддөг. Хүн ирээдүйд жилд хэчнээн хэмжээний зардал

гаргаж амьдрах, насны ангиллаас хамааран хэр хэмжээний эрсдэл дааж чадахаа тооцож бодоод тэтгэврийн санд хөрөнгө оруулдаг.

Залуу хүмүүс илүү эрсдэлтэй хөрөнгө оруулалтыг сонгож болох юм. Гэхдээ энэ нь гүйж очоод л эрсдэлтэй хувьцаа авна гэсэн үг биш. Өнөөдөр аль ч улс орны хувьд энэ тал дээр мэргэших ихээхэн шаардлага байгаа ч нөгөө талаас мэргэших боломж хязгаарлагдмал байна. Учир нь хүн болгон эмч болдоггүй шиг хүн бүр өөрсдөө тэтгэврийн сангаа удирдаж чадахгүй шүү дээ. Тиймээс тухайн хүн өөрийнхөө мөнгөн хуримтлалаа мэргэжлийн хүнээр удирдуулах зайлшгүй шаардлагатай тулгардаг. Ялангуяа олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн гарсан тохиолдолд мөн дэлхийн улс орнуудад хөрөнгө

оруулах боломж зэргээс шалтгаалж хувь хүн өөрөө тэтгэврийн сангийн идэвхтэй менежментийн амжилттай үйл ажиллагаа явуулах боломж хомс. Тухайлбал, өнөөдөр та банкинд мөнгөө хадгалуулах шаардлага гарлаа гэхэд тухайн банкинд, удирдлагад нь найдаж сонголт хийж, ур чадварт нь итгэдэгтэй яг адилхан юм.

Ер нь ирээдүйд тэтгэврийн сангийн төрлүүд манайд зайлшгүй орж ирнэ. Эхнээсээ ч бий болоод явж байна. Ийм ойлголтыг энгийнээр тайлбарлах нь хүндрэлтэй. Тухайлбал, АНУ-ын хувьцааны зах зээл 15, Хятадын эдийн засаг зургаан триллион ам.доллар. АНУ-ын хөрөнгийн зах зээлийн нийт хэмжээ ойролцоогоор 15 орчим триллион доллар. Өөрөөр хэлбэл, эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нэг нэгийн харьцаатай явж

байна. Тэгвэл энэ том хөрөнгийн зах зээлийн хувьцааных нь 40-50 хувийг дэлхийн томоохон тэтгэврийн сангууд барьж байгаа. “California Pension” / Калифорния Пенсион / гэж бий. Тус компани ойролцоогоор 350 тэрбум долларын төрөл бүрийн хувьцаа эзэмшдэг. Дотроо төрөлжсөн 100-200 тусгай сантай. Тэдгээрийг нь мөн тооны дэлхийд хамгийн шилдэг санхүүгийн менежерүүд удирддаг байх жишээтэй. Тэгэхээр энэ менежерүүд асар их хувьцааны хөдөлгөөнийг ажиглаж, хөрөнгө оруулалтаа хянаж суудаг.

-Тэтгэврийн сангийн системийг Монголд хэрхэн бүрэлдүүлж хөгжүүлэх вэ?

-Өнөөдөр манайх зөвхөн улсын тэтгэврийн сангийн тогтолцооны хэлбэрээр явж байгаа. Харин ирээдүйд улсын болон хувийн гэсэн хосолсон хэлбэр гарч ирэх байх. Энэ тохиолдолд ялангуяа залуучууд ирээдүйд би улсаас тэтгэвэр авна гэхээсээ илүүтэй өөрөө өөрийнхөө тэтгэврийн хуримтлалыг бүрдүүлэх хариуцлагатай шүү гэсэн сэтгэхүйтэй ажиллах хэрэгтэй. Үүний тулд хамгийн түрүүнд хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх нь чухал. Тэр дундаа эхлээд хувийн тэтгэврийн сангийн менежерүүдийн хүлээх хариуцлагын тогтолцоо ямар байх ёстой талаар тодруулах хэрэгтэй. Жишээлбэл, Монголбанкнаас арилжааны банкыг хянадаг маш нарийн хяналтын системтэй. Тэтгэврийн сан ч ялгаагүй мөн ийм хяналтын системтэй байх шаардлагатай. Хүний мөнгийг хүн хариуцаж байгаа тул мэргэжлийн өндөр ур чадвар, ёс суртахууны хатуу шаардлага тавих ёстой. Энэ шаардлагын дагуу мэргэжлийн тоглогчдын мэргэжил боловсролыг дээшлүүлэх ёстой. Ялангуяа ёс зүй талаас нь түлхүү анхаарах нь чухал. Үүний дараа хүний мөнгө завшсан хүн эрүүгийн хэрэгт татагддаг зарчмын дагуу эрүүгийн хуулийн тогтолцоонд эрх зүйн талаас шинэ өөрчлөлт орж таарна. Ийм багц арга хэмжээг авч хэрэгжүүлж байж тэтгэврийн сангийн төрлүүд хөгжинө. Үүний үр дүнд мэргэжлийн дотоодын хөрөнгө оруулагчийн бүхэл бүтэн анги бүрэлдэж, хэт гаднын хөрөнгө оруулалтын эрсдэлээс хамгаалах нөхцөл бүрдэнэ. Миний бодлоор уг бэлтгэл ажил ойрын нэг, хоёр жилд хийгдэх байх.

-Тэтгэврийн сангийн бүх л үйл ажиллагаа шударга явагдах ёстой. Хүний мөнгө завших асуудлыг хуулиар хамгаалах эрх зүйн талын орчныг нэлээд сайн бодож, судалж

байж хийх хэрэгтэй байх л даа. Ер нь иргэдийн хувьд ч сэтгэлгээгээ шинэчлэх хэрэгтэй юм байна?

-Та өнөөдөр надад итгэх үү эсвэл миний ард байгаа санхүүгийн томоохон байгууллагад итгэх үү? Өөрөөр хэлбэл, томоохон тэтгэврийн санг ямар тоглогчид ирээдүйд бүрдүүлэх хандлагатай байдаг вэ гэхээр өнөөдрийн санхүүгийн зах зээл дээр өөрийн байр сууриа олсон, итгэл хүлээсэн томоохон байгууллагууд л бүрдүүлнэ. Үүнд, томоохон брокер, дилерүүд, дээрээс нь арилжааны банкинд сангийн менежер гэдэг бүхэл бүтэн том хэлтэс гарч ирж байна. Яагаад заавал томоохон байгууллага гэж онцлоод байна вэ. Миний мөнгийг авсан хүн зугтаад явчихгүй гэдэгт итгэл төрүүлэх нь хамгаас чухал. Хатуухан хэлэхэд буруу үйлдэл хийснийхээ төлөө санхүүгийн менежер шоронд орох хүртэл арга хэмжээ авахуулж, эрүүгийн хариуцлага хүлээнэ гэсэн үг. Ийм ойлголтыг менежерүүдийн тархинд суулгаж өгөхгүй хэдэн төгрөгөөр торгоод л өнгөрвөл энэ систем хөгжихгүй. Товчхондоо бол хариуцлагагүй үйлдлийнх нь төлөө хатуу шийтгэл хүлээлгэдэг системийг бүрэлдүүлэх шаардлагатай. Хүний мөнгийг завшиж, өөр зорилгоор хэрэглэсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой гэдэг талаар ярьж байгаа юм шүү. Гэхдээ тэтгэврийн сан зарим жил ашигтай, дараагийн удаад алдагдалтай ажиллах үе байна. Та сонгосон менежерээ муу ажиллаж байна гэж үзвэл мөнгөө татаад дансанд хадгалуулж болно. Эсвэл өөр менежерт өгч болно.

-Тэтгэврийн сан олон төрөл байдаг талаар та цухас дурьдсан. Тэр олон төрлөөс манай улсад яг аль төрөл нь илүү тохирох вэ?

-Тэтгэврийн сан олон янз гэсэн нь хөрөнгө оруулж болох салбарын тухайд авч үзсэн хэрэг. Тухайлбал, “California Pension” /Калифорния Пенсион/-д уул уурхай, эрүүл мэндийн салбарын хувьцаа юу болж байгаа талаар ажиглаж суудаг нэг, нэг хүн байна. Ер нь эдийн засгийн салбар бүрт энэ төрлийн судлаач, багууд байдаг. Тухайн улсын бүс нутгаар нь хөрөнгө оруулалт хийдэг баг ч бий. Өмнөд Америк, оросуудын хувьцааг судалж байдаг багууд ч бий. Тэтгэврийн сангийн төрлийг сонгохдоо ирээдүйд ямар салбарын хувьцаа эрэлттэй өсөх магадлалтай талаар надад нэг төсөөлөл байна аа даа. Тэрхүү салбартаа хөрөнгө оруулж, хувьцааг нь худалдан авдаг. АНУ

одоогоор ахимаг насны хүмүүс ихтэй байгаа учраас эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулах нь ирээдүйд ашигтай гэдэг ч юм уу. Тэр дундаа тэтгэврийн насны хүмүүсийг асардаг компаниудын хувьцааг сонирхож тухайн салбарт хөрөнгө оруулж болно.

Хэрвээ надад их хэмжээний мөнгө байгаа бол 30 хувийг эрүүл мэндийн салбарт хийх шийдвэр гаргана. Энэ мөнгө эрүүл мэндийн салбарын тэтгэврийн сангийн менежерийн хариуцсан сан дотор төвлөрнө. Нөгөө 30 хувиа Хятадын уул уурхайд хөрөнгө оруулалт хийе, үлдсэн 40 хувийн мөнгөөрөө магадгүй Засгийн газрын бонд худалдан авч болох юм. Ингээд миний мөнгөний 60 хувь нь эрсдэлтэй, 40 хувь нь эрсдэлгүй төрөл рүү орж байна. Эрсдэлгүй төрлийнхөө 20 хувиар компаниудын бонд авчихъя. Гэхдээ мэдээж зээлжих зэрэглэлийг нь харж байгаад 2 Б, 3 Б-гээс дээш зээлжих зэрэглэлтэй компанийн бондыг сонгоод үлдсэнээр нь Засгийн газрын 10 жилийн бонд авна гэдэг ч юм уу.

Энэ нь ямар үр ашигтай вэ гэхээр ганцхан төрлийн хувьцаа хараад шаналж суух шаардлагагүй болно. Таны хувьцааг та биш, тухайн тэтгэврийн сангийн мэргэжилтэн хянаад гурван сар тутамд тайлан өгнө. Сайн гүйлгээ хийж, таны мөнгийг өсгөж чадах эсэх нь тухайн мэргэжилтнээс хамаарна. Ямар хувьцааг ямар үед аваад ямар үед зарж ашиг олох нь мэргэжлийн менежерээс л ихэд шалтгаалах юм.

-Тэгэхээр боловсон хүчний асуудал маш чухал юм байна. Харин манайд энэ талын мэргэжилтэн байгаа юу, хэр бэлтгэж байна вэ?

-Миний хувьд хөрөнгийн биржийн төлбөрийн систем өөрчлөгдсөний дараа дээрх олон улсын тэтгэврийн сангууд Монгол Улсад орж ирнэ гэж харж байна. Эдгээр сан Монголд орж ирээд энд болж байгаа үйл явдлыг Америкаас ч юм уу, гадаадаас хянаад байж чадахгүй. Тиймээс хэн нэгэн монгол залууд энэ үүрэг ногдоно. Тухайлбал, гаднын мэргэжлийн хөрөнгө оруулагчид Монгол Улсын ТОП 20 байгууллагын индекс ямар байна, жижиг Тавантолгойн хувьцаа, Татварын хууль шинэчлэгдсэн эсэх зэрэг бүх талын мэдээллийг авах замаар шинэ боловсон хүчнийг бэлтгэнэ. Нөгөө хэсэг нь өөрсдийн хүсэл сонирхол, эрмэлзлэлээр бэлтгэгдэнэ. Сургуулиар заах боломжгүй. Харин хувийн аж ахуйн нэгжүүд томоохон тэтгэврийн санг бий болгож болох юм. Тухайлбал, “NewCom” групп / би ажиллаж байсан ▶

► болохоор тус компанийн нэрийг жишээгээр татъя/ 2000 ажилтантай гэж бодоход эдгээр ажилтан сар бүр нийгмийн даатгалын шимтгэл хэлбэрээр тэтгэврийн хураамж төлдөг. Яг үүнтэй адилхан цалингийн тодорхой хэсгийг компаниас нь гаргаад аль эсвэл хувь хүний сонголт дээр тулгуурлан энэ төрлийн хуримтлалыг бий болгож болно. Магадгүй Та 25 наснаас доош бол би улсад тэтгэврээ даатгахгүй гэдэг шийдвэр гаргаж болох юм. Эрүүлд мэндийн даатгалаа бол хийгээд явна. Ирээдүйд улсаас тэтгэврэр авах хаалга нээлттэй үлдэнэ. Харин энэ хоёр жилдээ өөрийн хуримтлалын мөнгийг хувийн сангийн менежерээр удирдуулна гэдэг ч юм уу. Ингээд тухайн компани 2000-гаад ажилтныхаа хувийн тэтгэврийн сангийн тогтолцоог бүрдүүлээд байгууллага дотроосоо ТУЗ-өө сонгоод тэр ТУЗ нь сангийнхаа менежерийн үйл ажиллагааг сар тутам хянаад явж болно.

-Тэтгэврийн сангийн тогтолцоо манайд хөгжсөнөөр хариуцлага улам өндөрсөх юм байна гэж ойлголоо.

-Ер нь тухайн нийгмийн үнэ цэнээс хамаарч үнэнч шударга байх асуудал яригдах байх. Түүнээс биш, тэтгэврийн сан нийгмийг эмчлэгч эмч биш л дээ. Нөгөө талаас тэтгэврийн сан нь эрсдэлтэй. Зарим талаараа банк бус санхүүгийн байгууллага шиг эрсдэл ч дагуулж болно. Тийм учраас хөрөнгө оруулагчид энэ талаас нь судалж үзэх нь зүй ёсны хэрэг. Хэрвээ судалж чадахгүй бол мэргэжлийн хүнээс зөвлөгөө авах хэрэгтэй.

АНУ-д боловсролгүй хүмүүс олон. Тэд хувьцааны тухай яриад байдаггүй. Яагаад гэвэл америкчууд мэдэхгүй, мэдээлэлгүй, мэдлэггүй зүйлийнхээ талаар ярьдаггүй. Тиймээс мэддэг хүнд нь даатгачихдаг. Жишээгээр ярьж л даа. “Кока Кола” компанийн тэтгэврийн сан хариуцсан мэргэжилтэн ажилтнууддаа “Та манайд ажилласнаар хувийн тэтгэврийн санд хамрагдах боломжтой. Энэ санг ийм чадвартай хүн хариуцдаг. Тус менежерийн тухайн жилийн гүйцэтгэл таалагдахгүй бол та өөр менежерээр сольж болно шүү” гэж ярьдаг. Амьдрал ингэж л явдаг. Түүнээс биш социализмын үеийнх шиг бүх нөхцөлийг нь эрсдэлгүйгээр хангадаг юм байхгүй. Ер нь хүн 25 нас хүртлээ сурч, сургуулиа төгсөөд ажиллаж гэж бодъё л доо. Тэгээд 25-65 нас, цааш нь 75 нас хүртлээ ажиллахад 40-50 жил амьдрах мөнгө хэрэгтэй. Тэгэхээр 40 жилийнхээ амьдралыг харж байгаад сүүлийнхээ 10 жилийн

амьдралын зардлыг инфляцитай уялдуулан тооцооноор сард хэдэн төгрөг зарцуулах математикийн тооцоо гараад ирнэ. Манай даатгалын компаниуд энэ тооцоог хийгээд явж байгаа.

Тэтгэврийн санг хөгжүүлэх хамгийн том хөшүүрэг иргэдийн орлогын түвшин. Өнөөдрийн манай иргэдийн цалингаас цалингийн хооронд явж байгаа үед тэтгэврийн сангийн талаар сонирхох боломжгүй юм шиг байна. Тэр дундаа монгол хүн өнөөдрөөс өнөөдрийн хооронд төлөвлөж амьдардаг нүүдэлчин ард түмэн. Бидний муу, сайнд биш л дээ. Зүгээр л манай ард түмний онцлог юм. Тэгэхээр биднээс 20 жилийн дараах нөхцөл байдлыг олж хараад төлөвлөж, инфляци нь ямар байх юм бэ гэх мэт төлөвлөлт, тооцоо ухамсрын том өөрчлөлтийг шаардана. Бид суралцаж, ухамсрын түвшинд өөрчлөлт хийх л шаардлагатай.

-2011 оны дэлхийн болоод дотоодын санхүүгийн зах зээлийн талаар дүгнэж товчхон хэлэхгүй юу?

-2011 оны наймдугаар сараас эхлээд хувьцааны зах зээл савлаж эхэлсэн тэр дундаа Европ, АНУ-д. Энэ нь Европын зарим орны хариуцлагагүй төсвийн бодлоготой холбоотой. Тухайлбал, Грек байна. Тус улс асар их хэмжээний зээл аваад тэр мөнгөө иргэдэд зүгээр л тараасан. Бодит байдал ийм л юм болсон. Энэ нь зарим талаараа Монголын өнөөгийн байдлыг санагдуулаад ч байгаа юм шиг. Гэхдээ би үгүй байх гэж найдаж байна. Үүний дараа Испани, Итали зэрэг орны төсөв, зээлжих зэрэглэлийн асуудлыг ярьж байна. Гэхдээ эдгээр орон дампуураагүй. Хөрөнгийн зах зээл дээрээс босгох мөнгө нь л илүү үнэтэй болсон.

Эндээс 2011 оныг дүгнэх юм бол төсвийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж улс орон муу үр дагавартай нүүр тулдаг, ялангуяа олон улсын хөрөнгийн зах зээлд санхүүжилтийн эх үүсвэр нь хамаардаг болсон энэ цагт ийм үр нөлөө дагуулдаг юм шүү гэсэн сургамжтай жил болж байна.

2012 оны хувьд таамаглахад мэдээж Европын холбоо эдгээр улсаа аврах байх гэж найдаж байгаа. Гэхдээ маш их хэмжээний мөнгөн дэмжлэг, хөрөнгө оруулалт Европын орнууд руу чиглэнэ. Энэ нь хөгжиж байгаа орны зах зээлд нийлүүлдэг мөнгө багасна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, өнөөдөр Грек, Испанийг аврах уу, Монголын хөгжиж

байгаа зах зээлд хөрөнгө оруулах уу гэдэг асуудалтай тулгарна. Гэхдээ Монголын зах зээл жижиг учраас хөрөнгө оруулалт нэлээд доогуур тавигдах нь ойлгомжтой. Яагаад гэвэл харьцангуй бага нөлөө үзүүлэх учраас.

Монгол Улсын хувьд аваад үзэхэд 2011 оны эдийн засгийн эх үүсвэр хоёр том уурхайгаас, тодруулбал, хоёр урсгалаас хамааралтай болсон. Нэгдүгээрт, Оюутолгойг дагасан хөрөнгө оруулалт, үйлчилгээ. Хоёрдугаарт, нүүрсний экспорт. Түүхэнд байгаагүй 25 сая тонн нүүрс олборлолоо. Энэ тоо жил ирэх тусам өөрчлөгдөнө. Нэг үгээр, БНХАУ-ын нүүрсний томоохон экспортлогч болсны баталгаа болж байна. Гэхдээ урд хөршийн жилийн нүүрсний нийт хэрэгцээний нэг хувийг ч хангаж чадахгүй байгаа, манай улс. Хятад улс жилд гурван тэрбум тонн эрчим хүчний нүүрс хэрэглэдэг бол манайх 25 сая тонныг нийлүүлсэн. Хятадын хувьд жижигхэн тоо ч манай улсын хувьд том тоо. Мөн дөрвөн сая тонн төмрийн хүдэр экспортолсон. Энэ бүгдээс хамаарч манай эдийн засаг өссөн. Гэтэл эдийн засаг 25 хувиар өсөөд байхад жирийн иргэдийн амьдрал яагаад дээшлэхгүй байна, миний бизнес яагаад өргөжихгүй байна гэж бодож байгаа хүн олон бий. Гэхдээ үүнийг жаахан тэнцвэртэй тайлбарлахад эдийн засгийн өсөлтийг авчирсан энэ хамаарал маань дээрх хоёр урсгалд л хамаатай.

2012 оны хувьд Оюутолгой орд ашиглалтад ороод, тус уурхайгаас олсон ашгаар Монгол Улсаас олимпийн Лондонгийн аварга тодорч, аварга маань эх орноосоо олборлосон алтаар хийсэн медиалаар энгэрээ мялаах байх гэж бодож байна. Харин Тавантолгойн хувьд үйл ажиллагаа нь жигдрээд хувьцааны зах зээлд гарна. Өөрөөр хэлбэл, бид бэлтгэл ажлаас илүү хийдэг ажил руугаа орж байна гэсэн үг. Энэ үед байдал өөрчлөгдөнө. Мөн иргэн бүр “Эрдэнэс Тавантолгой” компанийн хариуцлагатай хувьцаа эзэмшигч болно. Эргээд энэ нь нийгмийн компани гэх ойлголтыг бий болгох юм. Нэг хүний өмч биш олон хувьцаа эзэмшигчтэй нийгмийн компани болно. Тиймээс манай залуучууд төдийгүй олон нийт энэ талын мэдээ мэдээллээр тархиа цэнэглэх хэрэгтэй. Яагаад ТУЗ хуралдахгүй байна, яагаад харилцанхамааралтай гэрээний хэлцэл хийж байна гэсэн шинэ ойлголтуудын талаар ярих нь ээ. Мөн хувьцаа гэж юу юм, хувьцаа эзэмшигч гэж хэн юм, хувьцааг хэзээ зарж борлуулдаг, ►

▶ яавал ашигтай ажиллаж болох талаар холбогдох байгууллагуудаас сургалт, гарын авлага хийх зэрэг арга хэмжээг авч эхэлсэн байгаа нь сайшаалтай юм.

-2012 оны эрсдэлийг Та яаж харж байна вэ?

-Энэ эрсдэл БНХАУ-ын эдийн засгийн өсөлтөөс шууд хамааралтай. Мөн тус орноос сургамж авах хэрэгтэй. Бид Өвөр Монголын Ордос нутгийн талаар мэднэ. Тэнд урд хөршийн томоохон нүүрсний орд газрууд байдаг. Маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн газар. Өндөр өндөр байшингууд олноор баригдсан боловч худалдаж авах хүн олдохгүй байдалтай байна. Тэгэхээр үр ашиггүй бүтээн байгуулалт түүнд хөрөнгө оруулах нь эдийн засагт

сөрөг үр нөлөө үзүүлдэг гэдгийг ухаарах хэрэгтэй. Манай орны хувьд байгалиас заяасан эрдэс баялгаа ашиглаад түүнийгээ буруу зарцуулах юм бол олон өлсгөлөн жилүүд ирж, бүсээ чангалах хэрэгтэй болж магадгүйг анхаарах нь чухал.

-Та “Алтан Дорнод” компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаад удаагүй байна. Яагаад ажлаа сольсон талаар зарим нэг хүмүүс гайхаж байгаа байх. “Алтан Дорнод” бол нэр хүнд нь нийгэмд нэлээд унасан компани шүү дээ?

-Би урьд нь “NewCom” группт ажиллаж байсан. “Алтан Дорнод” компанийг миний бизнесийн хамтрагч Ганболд захирал худалдан авсан. Нэгдүгээрт, муу нэртэй оросоос

монгол залуугийн гарт, монголчуудын мэдэлд ирсэн өнцгөөс харах хэрэгтэй. Ганболд захирлын хамтран ажиллах саналыг би хүлээж авсан. Магадгүй хүмүүс хасах, муу дүнтэй компанийг худалдаж авсанд гайхаж байгаа. Мөн дээрээс нь татварын ч болоод зарим нэг өр төлбөр бий. Гэхдээ яагаад муу дүнтэй компанийг сонгосон нь ердөө л бизнесийн эрсдэл боломжийг харсан. Би өөрөө харьцангуй залуу хүн. Хийж бүтээх ид насан дээрээ үндэснийхээ компанийг хөл дээр нь зогсоож, олон нийтээс эерэг дүн авах хүртэл ажиллах нь миний гол зорилго. Ганболд захирлын хувьд ч нэлээд эрсдэл хүлээсэн тул бид хамтраад үндэсний манлайлагч алтны нэг компанитай болох хүсэл эрмэлзлэлтэй ажиллаж байна. ■

Зочин

Эдийн засгийн хурдацтай хөгжлийг Лондоны бирж алдахыг хүсдэггүй

Лондоны хөрөнгийн бирж Монголын хөрөнгийн биржийг дэлхийн хэмжээний хөрвөх чадвартай байгууллага болгохоор ханцуй шамлан ажилдаа орсон билээ. Үүнтэй холбоотой Лондоны хөрөнгийн биржийн Хувьцааны анхдагч зах зээлийн газрын захирал Трейси Пиерсийг саяхан Монголд айлчлах үеэр нь “Mongolian Economy” сэтгүүлийнхэн ярилцлаа.



-Та шинэ жилийн өмнөхөн Монголд ирж байна. Дэлхийн томоохон биржийн удирдлагын хувьд 2011 он дэлхийн санхүүгийн зах зээлд ямар үр өгөөжтэй жил байсан гэж бодож байна вэ?

-Өнгөрсөн жилүүдэд санхүү, эдийн засгийн хямрал, Японы Цунами болон Арабын бослого хөдөлгөөн гэх мэт дэлхий нийтийг цочроосон олон таагүй үйл явдлыг үзэж туулсан, зах зээлийн хүндхэн цаг үе байлаа. Саяхнаас АНУ болон Европын холбооны эдийн засгийн хямралын асуудал хөндөгдөж эхлэх болсон. Дээрх асуудлууд шийдвэрлэгдэж, зүг чигээ олох тал руугаа хандвал эдийн засгийн байдал тодорхой хэмжээнд тогтворжиж, зах зээлийн хувирамтгай байдал багасна. Үүнийг даган зах зээлд шинээр орж ирэх компаниудын тоо ч өсөх хандлага гарах болов уу.

-2012 он дэлхийн санхүүгийн зах зээлийн хувьд ямархан өнгөтэй жил байх бол. Таамаг хэлэхгүй юу?

Лондоны хөрөнгийн биржийг төлөөлж ирэх оны өнгийг би тодорхой хэлж чадамгүй байна. Гэхдээ миний зүгээс тодорхой хэлж чадах зүйл гэвэл бид 2011 оны эцэст ирээд, эргэн харвал 2010 оныг бодвол нөхцөл байдал харьцангуй сайжирсаныг ажиг

болохоор байна. Энэ онд зах зээлд 145 компани шинээр орж ирж, 74 IPO хийснээр 20 гаруй тэрбум паундын хөрөнгийг IPO болон бусад замаар босгож чадсан нь өмнөх онтой харьцуулбал 15 хувийн өсөлт гарч байгаа юм. Иймээс бид цаашид зах зээл дээр цаг агаар тогтуун байж, улам сайжраасай л гэж найдаж сууна. Зах зээлд орж ирж буй компаниудын ялангуяа Орос болон хуучин Зөвлөлтийн орнууд мөн Ази Номхон далайн бүсийн орнуудын урсгал эдийн засгийн хямрал өмнөх үеэс ширүүссэн байна. Гэвч энэ нь зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалдаг учир цаг хугацааны хувьд тааварлахад төвөгтэй асуудал юм.

-Евро бүсийн өрийн асуудал, Хятадын эдийн засгийн байдал дэлхийн санхүүгийн зах зээлд яаж нөлөөлөх бол. Лондоны хөрөнгийн бирж энэхүү хямралаас хэр хамгаалалттай байж чаддаг вэ?

-Улс орнуудын эдийн засгийн хямралт байдал зах зээлд тогтворгүй байдлыг үүсгэж байгаа учир цаашид ч нөлөөллөө үзүүлсээр байх хандлагатай байна. Лондоны хөрөнгийн биржийн нэгэн давуу тал бол компаниудад дэлхийн хөрөнгийн зах зээлийн маш өргөн хүрээллээс хөрөнгө оруулагчаа олж авах боломж олгодог явдал юм. Манайд бүртгэлтэй компаниуд

► Европ, Их Британий зэрэгцээ Хойд Америк болон Ази, Ойрхи Дорнодын орнуудад хөрөнгө босгох боломжтой учир дэлхийн санхүү эдийн засгийн хямралд харьцангуй бага өртдөг юм.

-Та Монголын хөрөнгийн биржийн өнөөдрийн үйл ажиллагаанд ямар дүн тавих вэ? Шинэчлэлтийн ажил ямар шатанд явна?

-Өнөөдөр бидний стратеги түншлэлийн гол зорилго бол хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг сайжруулан, Монголын хөрөнгийн биржийг олон улсын жишигт нийцүүлж, дэлхийн хэмжээнд хүргэх явдал юм. Бидний зүгээс төлбөр тооцооны техник технологи, зах зээлийн ажиглалт хяналт болон арилжааны дараах үйл ажиллагааг сайжруулах ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Монгол орон урьдчилсан төлбөр тооцоот тогтолцооноос Т+3 буюу хөрөнгө оруулагч хувьцаа авснаас гурав хоногийн дотор төлбөрөө хийж гүйцэтгэх загвар луу шилжиж байгаа нь маш том шинэчлэл юм.

Мөн бид зах зээлийн орчинг сайжруулах үүднээс бүртгэл, гишүүнчлэл, үйл ажиллагаа, арилжаа болон үнэт цаас, мэдээллийн ил тод байдлын журмыг шинэчлэн боловсруулж саналаа хүргүүлээд байгаа. Зах зээлийн оролцогч болон зохицуулагч талуудын мэдлэгийг дээшлүүлж, чадавжуулах ажлын хүрээнд Монголын хөрөнгийн биржтэй хамтарч олон төрлийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Ингэснээр тэдний зүгээс шинэ дүрэм журмыг мөрдөж ажиллахад төвөг учрахгүй байх юм.

Энэ бүх ажлын үр дүнд Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагаа чанаржиж, биржид бүртгэлтэй компаниудын тоо өсөх юм. Хамгийн гол нь дотоодын төдийгүй гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын түвшин дээшлэх гол ач холбогдолтой. Ингэснээр зах зээлийн гаднаас орж ирж буй мөнгөн урсгал, хөрөнгө оруулалтыг дэмжин, хөрвөх чадварыг нэмэгдүүлэхэд чухал алхам болох талтай. Арванхоёрдугаар сардаа багтаан "Millimium IT" төлбөр тооцооны системийг бүрэн ашиглалтад оруулна гэж төлөвлөж байгаа. Энэ бол дэлхийн хамгийн хурдан арилжааны систем юм.

-Та Монголын хөрөнгийн биржийн маргаашийг хэрхэн харж байна вэ. Бид ямар боломж, болоод саад бэрхшээлтэй нүүр тулах бол?

-Монгол оронд асар их нөөц боломж бий. Дэлхийн эдийн засгийн хамгийн хурдан өсөлттэй яваа орнуудын нэг. Тийм ч учраас үр өгөөжтэй хөрөнгийн

зах зээл хэрэгтэй. Миний бодлоор энэ бүх өөрчлөлт шинэчлэлтийн дараах Монголын хөрөнгийн биржийн ирээдүй гэгээлэг байна. Төлөвлөгөөний дагуу МХБ-ийн өмнө тулгарч болох сорилтуудыг сургалт, зохицуулалт болон дүрэм журмын хүрээнд шийдвэрлэх аргуудыг тусгаж өгсөн байгаа юм. Гэвч тэтгэврийн сан, даатгалын компанийг хамарсан дотоодын байгууллагуудын баазыг бий болгох, Монгол Улсад орж ирэх шууд хөрөнгө оруулалтыг зөв захиран зарцуулах асуудал бидний өмнө тулгарч буй томоохон сорилтуудын нэг яах аргагүй мөн. Үүнээс гадна энэ нь гадаадын зах зээлд Монголын өсөлтийн талаарх мэдээллийг хүргэж сурталчлах зарим талаар Лондон дахь хөрөнгө оруулагчдаараа дамжуулан таниулах учиртай юм. Бид Монголын нөөц боломжид тулгуурлаж зах зээлийг төлөвшүүлэх зорилгыг тавьж байгаа. Ирэх оны эхэнд хоёр ч ажил хийхээр төлөвлөсөн. Хамгийн түрүүнд хөрөнгийн биржид бүртгэлтэй байхын ач холбогдлыг Монголын компаниуд болон зөвлөх ажилтнуудад таниулах чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо хийх бөгөөд үүний дараагаар Лондон хотод "Хөрөнгийн зах зээл арга хэмжээг" Монголын компаниудыг олон улсын хөрөнгө оруулагчидтай уулзуулах зорилгоор тус тус зохион байгуулах гэж байна. Энэ бол зөвхөн Монголын хөрөнгийн биржийн хөрвөх чадвар, хөрөнгийг нэмэгдүүлэх урт хугацааны төслийн нэг хэсэг юм.

-Монгол Улсын иргэн бүр хувьцаа эзэмшигч болсон. Энэ үед Лондоны хөрөнгийн биржтэй хамтран ажиллаж байна. Тавантолгойн хувьцааг Лондоны хөрөнгийн биржид арилжаалах нээлттэй юү?

Монголд үнэт цаасны талаарх мэдлэгийг сайжруулж, биржийн хөрвөх чадварыг өсгөхийн тулд дотоодын бие даасан хөрөнгө оруулагчдын оролцоо зайлшгүй шаардлагатай. Тавантолгойн хувьд Монгол, Лондон болон Хонконг гэсэн дарааллаар хөрөнгийн биржүүдэд бүртгүүлж гадаадын хөрөнгө оруулагчдаас хөрөнгө босгох улмаар дотоодын хөрөнгийн биржид давхар бүртгэгдэж, бие даасан болон дотоодын байгууллагуудын хувьд шууд хөрөнгө оруулалт хийх боломжийг олгож байгаа юм. Монгол Улсын иргэд дотоодын зах зээлд шууд оролцож, хувьцаа худалдан авах, зарах боломжтой.

-200 гаруй жилийн түүхэн замналтай Лондоны хөрөнгийн бирж 20 гаруйхан жилийн хөгжлийн түүхтэй Монголын хөрөнгийн биржийг яаж "тоосон" бэ?

-Үнэхээр сайхан асуулт байна. Бидний

хувьд дэлхий дээр эдийн засгийн хөгжил нь хурдацтай явж буй орнуудын үйл ажиллагаанд шууд байдлаар оролцох нь ихээхэн чухал байдаг. Монголын хувьд байгалийн баялаг, уул уурхайн салбарын хөгжил ихээхэн анхаарал татсан юм. Лондонд уул уурхайн салбарт ажиллаж байсан арвин их нөөц, туршлага бий. Тиймээс бид энэхүү хоёр зах зээлийг холбох нь ихээхэн чухал ач холбогдолтой гэж үзсэн. Дахин хэлэхэд бидний харилцаа бол урт хугацааны төсөл, удаан жилийн түншлэл юм

-Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагааг сайжруулсны дараагаар хувьчлах тухай яриа гарах болсон. Үүнийг Лондоны хөрөнгийн биржтэй хамтарч ажилласантай холбон авч үзэх нь ч байгаа. Гэхдээ энэ бол зөвхөн монголчуудын л хардлага л даа. Та үүнд юу хэлэх вэ?

-Дээр дурдсан техник технологи, дүрэм журам, сургалтын асуудлыг хамарсан гурван жилийн гэрээг л байгуулсан. Түүнээс өөр хувьчлалтай холбоотой тусгагдсан ажил миний мэдэхээр байхгүй.

-Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, хувьцаанд итгэх итгэлийг сэргээх, компанийн засаглалыг сайжруулахад манайх юу хийх ёстой вэ?

-Энгийн иргэд болон зах зээлийн оролцогчдын мэдлэгийг зузаатгах олон арга бий. Бидний энэ чиглэлд нэн тэргүүнд Монголын хөрөнгийн зах зээлд олон түмний тэр дундаа хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхийг зорьж байна. Зах зээлийн мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд худалдааны фирмүүдэд танилцуулах сургалт уулзалтыг зохион байгуулсан бөгөөд цаашлаад Улаанбаатар болон Лондон хотод таниулан сурталчлах арга хэмжээг зөвлөх, хөрөнгө оруулагч, шинэ компаниудын дунд хийх гэж байна. Хөрөнгийн бирж дээр IPO хийхээр төлөвлөж байгаа байгууллагуудтай хамтарч ажилладаг сургалтын тусдаа Академи манайд бий. Тэдний үүрэг бол тус компаниудыг бүхий л үйл явцтай нарийн танилцуулах замаар дүрэм журам, санхүүгийн тайлан, компанийн засаглалын талаар ойлголт өгч, мэдлэгийг нь зузаатгаж өгдөг юм. Эдгээр санаачилгууд нь МХБ-тэй тогтоосон түншлэлийн хүрээнд хэрэгжээд явах юм.

-Та дахин хэзээ Монголд ирэх вэ?

-Би Монголд гурав дахь удаагаа ирж байна. Эхний удаа хавар, дараагийн удаа зун ирж байлаа. Харин энэ удаа төслийн ажлын хүрээнд өвлийн улиралд ирлээ. Удахгүй миний бие багийн гишүүдийнхээ



PPP түншлэл

Хөгжлийн төлөө хэрхэн түншлэх вэ

Х.Хулан

Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил нь зөвхөн Засгийн газарт хамааралтай биш аж. Харин хувийн хэвшлийн оролцоотой хамтарч бүтээх үйл ажиллагаа гэж хэлж болно. Учир нь манай хувийн хэвшлийн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 80 орчим хувийг үйлдвэрлэж, ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулахад жинтэй хувь нэмэр оруулсаар ирсэн. Иймээс харилцан ашигтай төр, хувийн хэвшлийн хоорондын түншлэлийг бүрдүүлэх, эдгээр хоёр түншийн хувь нэмрийг хослуулан хөгжүүлэх нь нэн чухал билээ.

Үндэсний хэмжээнд анх удаа “Хөгжилд хүргэх түншлэл” сэдэвтэй форумыг Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын ивээл дор Төрийн ордонд зохион байгуулсан. Энэхүү хэлэлцүүлгийг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо /ҮХШХ/, Төрийн өмчийн хороо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим /МҮХАҮТ/, Монголын ажил олгогч эздийн холбоо /МАОЭХ/, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /ГОУХАН/-ийн “Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр” хамтарч явуулсан юм.

Форумын нээлтэд Ерөнхий сайд С.Батболд оролцож төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны талаар Засгийн газрын байр суурь, оролцоо, бодлогыг танилцуулсан. Тэрбээр Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны тухай баримтлах бодлого, Концессын

тухай хууль, Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги, Компанийн засаглалын хөтөлбөр баримт бичгийг боловсруулан гаргаж, хэрэгжүүлж эхэлснийг тэмдэглэсэн. Түүнчлэн “Бүтээн байгуулалтыг зөвхөн төсвөөс бус харин хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, оролцоотой хийх зорилт Засгийн газрын өмнө тулгарч байна. Санхүүгийн эрх чөлөөг иргэн, аж ахуйн нэгжид олгохын төлөө ажиллана” гэж мэдэгдсэн.

Монгол Улсад 2011 оны зургадугаар сарын 30-ны байдлаар нийт 89000 хувийн хэвшлийн аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаа бөгөөд үүнээс 50000 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж.

Дөрвөн салбар хуралдаан болов

Хэлэлцүүлгийн үеэр төр хувийн хэвшил түншилж, хөгжилд хүрэхтэй холбоотой дөрвөн салбар хуралдаан болсон билээ.

• **Нэмүү өртгийн албан татварын шинэтгэл.** Гол тогтож ярилцсан асуудал нь НӨАТ-ын ялгавартай бодлого, шатлал бий болгох тухай байлаа. Нэг үгээр хэлбэл, НӨАТ-ын чөлөөлөлт, буцаан олголтын механизмыг төлөвшүүлэх нь чухал болохыг онцолсон. Татварын ерөнхий газрын дарга Б.Баттөмөр НӨАТ-ыг халах уу гэдэг асуултыг тал бүрээс нь авч үзэж тайлбарлав. Тэрбээр “Зарим хүмүүс НӨАТ-ыг огт байхгүй

болгох талаар санал хэлдэг. Энэ нь боломжгүй юм. Яагаад гэвэл улсын төсвийг бүрдүүлэх боломжгүйд хүрч болзошгүй. Олон улсын жишгээс харахад зарим НӨАТ-гүй орнууд энэ төрлийн татварыг нэвтрүүлэх арга замыг хайж байна. Тийм болохоор бид НӨАТ-ыг халах тухай ярих нь тохиромжгүй юм” гэж хэллээ.

• **Зээлийн батлан даалт.** Үүнд Зээлийн батлан даалтын тухай хуулийн төслийн асуудлуудаар түлхүү ярилцсан. Зээлийн батлан даалтын хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн барьсан байгаа бөгөөд энэхүү хууль батлагдаваас батлан даалтын үйлчилгээтэй холбоотой олон асуудал тодорхой болох юм байна. Мөн энэ үеэр банк зээл олгохдоо хэдэн зуун саяар үнэлэгдэх үл хөдлөх хөрөнгө барьцаалахаасаа илүүтэй залуучуудын сайн бизнес санаатай төслийг үнэлдэг байх, санхүүгийн өндөр сахилга бат, зээлийн сайн түүхтэй үйлчлүүлэгчид зээл өгдөг болмоор байна гэсэн шинэлэг зүйл яригдсан юм.

• **Төр, хувийн хэвшлийн хэлэлцэл /public private dialogue/.** Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэх шалгуур үзүүлэлтийн тухай нухацтай ярилцсан. Төр, хувийн хэвшлийн диалог буюу хэлэлцэл нь нэг талаас төр, нөгөө талаас хувийн хэвшил хоорондоо санал солилцохыг хэлнэ. Хоёр талын хэлэлцлийн үр дүнтэй механизмыг хөгжүүлэх асуудал чухлаар тавигдаж ▶

► байлаа. Мөн мэргэжлийн холбоод оролцоогоо сайжруулж, чадавхижих шаардлагатай байгааг тэмдэглэсэн.

• **Төр, хувийн хэвшлийн түншлэл /public private partnership/.** Нийгмийн салбар дахь төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, орон нутагт төр, хувийн хэвшлийн түншлэлийг эрчимжүүлэх тухай асуудлыг энд ярилцсан. Төр, хувийн хэвшлийн түншлэл ялангуяа эрүүл мэнд, боловсрол, соёл урлагийн салбарт бараг байхгүйтэй адил байгаа тухай холбогдох хүмүүс ярьж байсан. Түншлэлийн хүрээнд дэд бүтцийн салбарт 97 төсөл байхад, нийгмийн салбарт зургаа л байна. Энэ нь нийгмийн салбарын төслийг хэрэгжүүлэх арга зам, механизм тодорхой бус болохоор хэрэгжиж чадахгүй байна гэсэн саналыг дэвшүүлээ.

Үндэсний зөвлөлдөх хороо байгуулав

ҮХШХ-ны дарга Ч.Хашчулуун хувийн хэвшлийн салбарыг дэмжих үүднээс анх удаа Засгийн газар, хувийн хэвшил хамтарсан үндэсний зөвлөлдөх хороо байгуулагдаж байгааг форумын оролцогчдод танилцууллаа. Тус хороог Ерөнхий сайд ахлах аж.

2010 оныг Бизнесийн орчны шинэтгэлийн жил болгон зарлаж, бизнесийн орчныг сайжруулахад чиглэгдсэн 105 арга хэмжээг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хэрэгжүүлсэн байна.

Зээлийн батлан даалтын сан

Бизнесийн орчныг хүмүүс ихэнх тохиолдолд зээлийн орчин гэж авч үздэг. Тэгвэл бичил жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд тулгардаг хамгийн тулгамдсан асуудал бол санхүүжилт мөн. Гарааны шинэ бизнес ч бай, үйл ажиллагаагаа өргөжүүлэх сонирхолтой аж ахуйн нэгжийн хувьд хөрөнгө оруулалт амин чухал. Гэтэл зээлийн олдоц муу, банкны хүү өндөр, хангалтгүй барьцаа хөрөнгө нь бизнес эрхлэгчдийн толгойг гишүүнээр ирсэн асуудал юм. Банкны зүгээс жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд тавих босго өндөртэй шаардлагын улмаас олон сайхан, ирээдүйтэй бизнес санаа хэрэгжих боломжгүй болдог.

Зээлийн баталгааны тогтолцоод эерх асуудлыг шийдвэрлэх альтернатив арга зам мөн гэж хэлж болно. Арилжааны банкууд олон улсын байгууллагуудтай хамтарч зээлийн баталгаа гарган малчид, бичил жижиг, дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн батлан даалтын үйлчилгээг хүргэж байгаа нь бизнесийн

салбарт оруулж буй томоохон хувь нэмэр мөн.

Монголын анхны бие даасан батлан даалтын “Ногоон зээлийн баталгааны сан”-гаар дамжиж 710 сая төгрөгийн баталгаа гаргаж, 93 ажлын байр шинээр бий болгосон түүхтэй.

Удаах амжилттай хэрэгжиж байгаа зээлийн батлан даалтын үйлчилгээг ГОУХАН-ийн “Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр”-өөс туршсан юм. Энэхүү “Зээлийн батлан даалтын сан” нь банк, санхүүгийн байгууллагаас хүссэн, хөтөлбөрийн зорилтот гурван бүс болох Орхон, Дархан-Уул, Завхан аймгийн аж үйлдвэр эрхлэгчдийн зээлд батлан даалт гаргаж ажилласан байна. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд 140 орчим иргэн, аж ахуйн нэгжид 2.2 тэрбум төгрөгийн зээл авахад 854 сая төгрөгийн батлан даалт гаргажээ. Зээлийн эргэн төлөлт 98 хувьтай байгаа нь батлан даалтын үйлчилгээний үр дүн, хэрэгцээг харуулж байна.

“Хөгжилд хүргэх түншлэл” форум нь бизнесийн орчныг хэрхэн сайжруулах, хувийн хэвшлийн салбарын хөгжилд тулгамдсан асуудлыг тодорхойлж, түүнийг шийдвэрлэх арга замыг оролцогч талууд хэлэлцэн, төр, хувийн хэвшлийн цаашдын харилцан ашигтай хамтын ажиллагааны үндсийг тавьсан гэж хэлж болох.

Та төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны тухай юу хэлэх вэ?

С.Дэмбэрэл /МҮХАҮТ-ын дарга/:

-Эхлээд төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Хоёрдугаарт, эрх зүйн орчин өөрөө хангалттай биш. Үүн дээр хуульд хамааралгүй нэг зүйл байна. Тэр нь хоёр талын төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх гэсэн чин эрмэлзэл дээр суурилсан итгэл үнэмшлийн асуудал гэх юм уу даа. Гуравдугаарт төр, хувийн хэвшлийн хөгжүүлэх технологи нь байх ёстой.

Төр, хувийн хэвшлийн харилцан яриа, хамтын ажиллагааны тухай Монгол Улсын хууль гаргах ёстой гэж бодож байна. Энэ гаргасан хуулийг бусад салбарлах хуулиуддаа өөрчлөлт оруулах замаар эрх зүйн орчныг бүрдүүлбэл энэ маань сайн засаглал руу шилжих зөв алхам болно. Бизнес эрхлэгчдийн дуу хоолойг сонсдог байх хэрэгтэй.

Б.Бямбасайхан /“Ньюком” ХХК-ийн гүйцэтгэх захирал/:


-Төр, хувийн түншлэл гэдэг том

ойлголт Монголын нийгэм, эдийн засагт орж ирж байна. Бусад орны амьд жишээг харахад тийм амархан бүтдэг зүйл биш. Өнөөдөр Монгол Улсын эдийн засаг асар хурдацтай хөгжиж байна. Энэ жил 20, 2012 онд 25 хувийн өсөлт гарах төсөөлөл байгаа. Эдийн засгийн ийм өсөлтийг яаж хангах вэ гэвэл дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт зайлшгүй шаардлагатай. 2015 он хүртэл дэд бүтцийн салбарт 8.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хэрэгцээтэй гэсэн тооцоо гарсан. Энэ хөрөнгө оруулалтыг ямар зарчмаар хийх вэ гэвэл төр, хувийн хэвшлийн түншлэлийн механизмыг бий болгосны үндсэн дээр төслийг хэрэгжүүлнэ. Зөвхөн бодлого, хууль гараад бүх юм сайн болно гэсэн үг биш. Хуулийг хэрэгжүүлэхэд дүрэм журам шаардлагатай болно. Тодорхой ойлголтыг бий болгосноор ямар бэрхшээл байна гэдгийг ойлгож, тэрэндээ таарсан зохицуулалт хийх нөхцөл байдал үүссэн байна.

М.Чимэддорж /Монголын үндэсний зөвлөхүүдийн холбооны Удирдах зөвлөлийн дарга/:

-Форумын ач холбогдлын хувьд бизнесийн орчинтой холбоотой төрөөс гаргаж байгаа шийдвэрүүдийг боловсруулахад хувийн хэвшлийн салбарын саналуудыг хэрхэн тусгадаг вэ гэдгийг төрийн байгууллагын оролцоотой анх удаа ярилцаж байгаагаараа ач холбогдолтой. Өмнө нь дан хувийн хэвшил, холбоод энэ асуудлыг тавьсаар ирсэн. Төрийн зүгээс тэдний дуу хоолойг шийдвэртээ төдийлөн тусгаж байгаагүй.

Ер нь хэлэлцлийг төрийн шийдвэр гаргадаг механизмд оролцуулахад нэг удаагийн уулзалт, яриа ач холбогдол үзүүлж чадахгүй. Төр үүнийг жинхэнэ утгаар нь ойлгох ёстой. Одоо бол ярилцаж байгаа ч ойлголцохгүй байгаа. Ойлгоно гэдэг нь хувийн хэвшлийн саналуудыг нэгтгэдэг, цэгцэлдэг механизм бий болгох шаардлагатай. Тэр нь мэргэжлийн холбоодуудаар юм уу бизнесийн гишүүнчлэлтэй байгууллагуудаар дамжиж саналуудыг нэгтгэдэг мэргэжлийн дүгнэлттэй болсон байх хэрэгтэй. Төр түүнийг шийдвэртээ заавал авч үздэг, харгалзаж үздэг механизмыг бий болгох нь зөв. Ингэхийн тулд хоёр тал ойлголцож, тэр үндсэн дээр итгэж байх ёстой. ■



Шог зургийг А.Амарсайхан

Хууль

“Урт нэртэй” хуулийг удган бөөгөөс асуух ёстой юу

Б.Ууганбаяр

Эрт урьдын цагт хошуу нутагт нь газар нутаг, эд баялаг, өмч хөрөнгөөс үүдэлтэй янз бүрийн хэцүү асуудал тулгарахад шийдэж өгдөг мэргэн шүүгч хэмээн алдаршсан Соломон гэдэг хаан байжээ. Нэгэнтээ хоёр эмэгтэй хүүхдээ булаалцалдан, бөөн хэрүүл шуугиан тарьж, шийдэлд хүрэхгүй байсан тул мэргэн Соломон хаанд бараалхжээ. Нэг нь “Би энэ эмэгтэйтэй хамт амьдардаг юм. Бид хоёр нэгэн зэрэг хүүтэй болсон. Түүний хүү шөнө унтаж байгаад амьсгал хураасан байсан. Гэтэл ичгүүргүй энэ эм нас барсан хүүгээ миний өвөрт хийчихээд хүүг минь авчихсан. Өглөө босоод хүүхдээ хөхүүлэх гэтэл миний хүү биш байсан” гэж хаанд мэдүүлжээ. Харин хоёр дахь эмэгтэй энэ яриаг байнга няцаах аж. Тэгэхэд хаан “Илд авчраад наад хүүхдийг нь хоёр хуваа. Тэгээд тал талаар нь аваг” гэж зарлигджээ. Тэгсэн хоёр эмэгтэйн нэг нь тоосон шинжгүй “Тэг л дээ, надад ч түүнд ч бүү оногдог” гээд хэнэггүй байсан бол нөгөө нь “Үгүй ээ, хүүхдийг тэр авбал аваг. Гагцхүү амьд л үлдээж үзээч” хэмээн чарлав. Үүнийг сонссон Соломон хаан “Хүүхдийг амь үрэгдүүлчих вий гэж санаа нь ихэд зовсон эмэгтэйд өг. Тэр л жинхэнэ эх нь байна” гэж шүүн тунгаасан гэдэг.

Лицензээ хураалгахдаа тулаад буй бидэнд гүйцэтгэсэн үүрэг бий

Гол, мөрний урсац, бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилт дээрх үлгэр лугаа адармаатай байдал үүсгээд багагүй хугацаа өнгөрөөд байгаа билээ. Хэвлэл мэдээллийнхэн, олон нийт ч дээрх хуулийг гараад удаагүй байхад ам чилээх шахсан нэрийг нь хүртэл хэлэхээс төвөгшөөж “Урт нэртэй” хууль хэмээн нэрийдсэн. Уул уурхайн “Тулгуур хүч” төрийн бус байгууллагаас дээрх хуулийн хэрэгжилттэй холбоотой хурал зохион байгуулсан. Эдийн засагчид, уул уурхайн салбарынхан болоод холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид оролцсон уг хурлын үеэр ч “Урт нэртэй” хуулийн хэрэгжилт учир ургуулсан олон асуудал араасаа хөврүүлсээр байгаа шалтгааныг учирлах хүн ч цөөнгүй байсан. Харин хурал болсны маргааш нь нэгэн өдөр тутмын сонин дээр “Урт нэртэй хуулийн хэрэгжилтэд онц дүн тавилаа” гэсэн гарчиг бүхий нийтлэл гарсан нь бодит байдлыг арай буруу өнцгөөс харсан байх шиг байсан. Хурлын үеэр зарим холбогдох хүмүүсийн сэтгэгдлийг сонссоноо хүргэе. Тухайлбал, уг хуралд оролцож байсан ▶▶

► зарим нь “Төр, засаг арай ч ийм зүйл хийж, биднийг хөсөр хаяхгүй байлгүй дээ. Арай ч лицензийг цуцалж, үйл ажиллагааг зогсоох дээрээ тулахгүй байх” гэсэн итгэл тээсэн, цөхөрлийн үгийг ч урсгаж байсан. Монгол Улсын мэргэшсэн геологич Ц.Цэнд-Аюуш “1990 оны эхээр манай улсын эдийн засаг уналтад орж, лангуун дээр давс, гоймон хоёроос өөр зүйлгүй байсан тэр үед Засгийн газраас “Алт” хөтөлбөрийг санаачлахад одоо лицензээ хураалгахдаа хүрээд байгаа компаниудад л үүрэг даалгавар өгч, голлох үүргийг гүйцэтгэж ажилласан. Тухайн үед Засгийн газраас биднийг дэмжиж байсан болохоос биш, байгаль орчны хохирол тооцох талаар ямар нэг зүйл ярьж байгаагүй. Гэтэл “Өөх өгсөн хүнтэй өглөө босоод заргалдана” гэгчээр одоо бидэнд байгаль орчны хохирол, нөхөн сэргээлтийн өндөр зардал тооцож байгаа нь үнэхээр аргаа барсан өрөвдөлтэй хэрэг” хэмээн шүүмжилсэн.

Харин Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн тэргүүн Д.Дамба “Энэ хууль анхнаасаа л судалгаа, шинжилгээ үндэслэл муутай гарсан учраас шат шатандаа олон бэрхшээлтэй тулгарч, амь гарах төдий л хэрэгжиж байгаа юм. Хууль санаачлагчид нь ч нэгэнт амласан болохоор ямар ч байсан сонгуулийн өмнө хэрэгжүүлэхээр муйхарлаж байгаа. Муу хуулийн уршгаар 10 мянга орчим хүний ахуй амьдрал, өчнөөн олон хүний хөлс, хүч хөрөнгө шингээж босгосон ажлын байр ор мөргүй болж, өрөнд орохдоо тулаад байна. Уг нь ийм хэцүү нөхцөл байдлыг үүсгэлгүй хуулийг сайн судалгаа шинжилгээтэй хийж болох л байсан” гэв.

Алтны шороон ордын уурхайн төлөөлөл болж Увс аймгийн Тариалан сумын “Хар тарвагатайн” алтны орд болон нүүрсний уурхайн захирал Д.Сурмаажав ярихдаа “Байгаль орчноо хамгаалах хууль гаргаж байгааг буруутгахгүй байгаа. Гэхдээ компаниудад хамгийн хүндээр тусаж байгаа зүйл бол машин техник, тоног төхөөрөмж болон үйлдвэрлэлийн зээлийг үнэлэхгүй байгаа нь эдийн засгийн хувьд ихээхэн хохиролтой байна. Дээр нь нэмээд нөхөн олговорт өгөх мөнгөө байгаль орчны хохирлын үнэлгээндээ дүйцүүлж, харин ч их хэмжээний өрөнд орж байгаа нь биднийг үнэхээр туйлдуулахад хүргээд байгаа юм. Компанийн эздэд энэ нь хүндээр тусаж амиа хорлох ч хүн

гарахыг үгүйсгэх аргагүй. Миний хувьд 1997 оноос эхэлж анх энэ бизнест хөл тавьж, зун нь ажилгүй байдаг 70 орчим иргэнийг ажлын байраар хангахын зэрэгцээ аймгийнхаа Дулааны станцыг ч хэвийн ажиллахад нэмэр тус болдог гэж боддог. Хууль дүрэм ард иргэдийн эрхийг хамгаалсан байх ёстой атал энэ хууль олон хүнийг ажилгүй болгохын зэрэгцээ манай аймгийн хувьд дулаан цахилгаан тасалдахад ч хүргэж магадгүй нь харамсалтай” хэмээн бодит байдлаа хатуухан хэллээ. Алтны шороон ордуудын нөхөн олговорт компаниудын улсад төлсөн татвар, бүтээгдэхүүн борлуулж эхэлснээс хойших цэвэр ашиг, уурхайн ажиллагаатай холбоотой нөхөн сэргээлтийн зардал зэргийг багтаасан аж. Харин нөхөн олговорт техник тоног төхөөрөмжийн үнэлгээ, зээлийг яагаад оруулаагүйг ЭБЭХЯ-ны Геологийн бодлогын газрын орлогч дарга С.Баттулгаас тодруулахад “УИХ-аас л ийм шийдвэр гарсан шүү дээ. Би мэдэхгүй” гэсэн юм.

“Бухын доод талыг харж үнэг турж үхнэ” гэгч болжээ

Мөн “Нуухыг нь авах гээд нүдийг нь сохлов” гэгчээр “Урт нэртэй” хуулийн хэрэгжилт “нинжа” нарын тоог хэдэн мянгаар нэмэгдүүлж байгаль орчны асуудал бүр ч хүндэрч, хяналтаас гарах магадлал өндөр гэдгийг ч олон хүн сануулж байлаа. Үүн дээр нэмээд уул, уурхайн компаниуд лицензээ барьцаалаад банкуудаас их хэмжээний зээл авсан байдаг учраас “Урт нэртэй” хууль санхүүгийн салбарт ч хүнд цохилт учруулахыг Монголбанкныхан сануулсан. Энэ талаар С.Баттулга “Бид одоогийн байдлаар судалгаа хийж байгаа. Шороон ордны хэчнээн компани зээлтэй байгааг тодруулахаар Монголбанк руу хүсэлтээ явуулсан” гэж хариуллаа.

Хууль хэрэгжүүлэх галт тэрэг нэгэнт хөдөлсөн болохоор алтны шороон ордынхон нөхөн олговор авах хүсэлтээ даруй гаргаж өгөх ►►


“Урт нэртэй” хуулийн хүрээнд ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газартай давхцсан тусгай зөвшөөрлийн тоо

Үзүүлэлтүүд	Тоо	Тусгай зөвшөөрлийн нийт талбайн хэмжээ, сая гектар	Үүнээс давхцсан талбайн хэмжээ, сая гектар
Давхцсан тусгай зөвшөөрөл	1782	18.3	3.8
Ашиглалтын	391	0.27	0.08
Хайгуулын	1391	18.05	3.7
Бүхэлдээ давхцалтай	311	0.2	0.2
Ашиглалтын	167	0.03	0.03
Хайгуулын	144	0.18	0.18
Хэсэгчилсэн давхцалтай	1471	18.1	3.6
Ашиглалтын	224	0.23	0.045
Хайгуулын	1247	17.9	3.5

Хориглосон газартай давхцалтай 890 аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулалтаар ангилбал



Ашиглалтын 391 тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын төрлөөр нь ангилбал



Эх сурвалж: АМГ Геологи, уул уурхайн кадастрын хэлтэс

шаардлагатайг албаныхан онцолсон. “Нөхөн олговор авах аж ахуйн нэгжүүд Засгийн газрын 299 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу материалаа бүрдүүлэн 90 хоногийн дотор буюу ирэх оны нэгдүгээр сарын 9-ний дотор манайд өгөх ёстой. Сар гаруйхан хугацаа үлдчихээд байхад энэ сарын байдлаар манайд хоёр л нөхөн олговор авах хүсэлт ирээд байна. Хэрэв материалаа хугацаандаа бүрдүүлж өгөөгүй тохиолдолд нөхөн олговрыг тэглэж, олгогдохгүй” хэмээн Ашигт малтмалын газрын Уул уурхайн албаны дарга М.Ариунбаяр сануулсан юм. Түүнчлэн хүсэлтээ өгсөн аж ахуйн нэгжүүдэд хоёр жилийн дотор нөхөн олговрыг өгнө гэж журамдаа заажээ.

Энэ асуудал дээр компанийн төлөөллүүд нэгдүгээрт, энэ чиглэлийн мэдээлэл дутмаг, хоёрдугаарт, О.Чулуунбат тэргүүтэй УИХ-ын гишүүдийн санаачлагын дагуу хууль шинэчлэгдэх байх гэсэн горьдлого тээсээр нөхөн олговрын хүсэлтээ өгөлгүй өнөөдрийг хүргэсэн гэдгээ ч нуугаагүй. “Урт нэртэй” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар О.Чулуунбат, Я.Батсуурь тэргүүтэй УИХ-ын зургаан гишүүн өнгөрсөн оны нэгдүгээр сард зургаан зүйл бүхий хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан удаатай. Үүний гол агуулга нь “ашигт малтмалыг олборлох, хайх, ашиглахыг хориглосон газарт үйл ажиллагаа явуулж буй аж, ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хориглох биш нөөц нь дуусаж, нөхөн сэргээлтээ өөрсдөө бүрэн хийх хүртэл хязгаарлах” гэсэн агуулгатай байсан ч УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэгдээд сураг нь тасарчээ.

Дээрх үлгэрт гарч буй хоёр эмэгтэй шиг энд нэг талд нь байгаль орчноо хамгаалах хууль санаачлагчид болон хэрэгжүүлж буй яам, агентлагууд байгаа бол нөгөө талд хуулийг хэрэгжүүлснээр уул уурхайн олборлолтод цөөнгүй жил зарцуулсан хөлс хүч, хөрөнгө мөнгөө салхинд хийсгэж байгаагаас ялгаагүй зүйл болно гэсэн болгоомжлолтой уурхайн эзэд байгаа юм. Үлгэрт гарч буй мэргэн Соломон хаанд бараалхах л үлдээд байх шиг. Одоо хуулийн хэрэгжүүлэлт талаас нь холбогдох хүмүүсийн байр суурийг сонирхуулья.

“Урт нэртэй” хууль 2009 оны долдугаар сард батлагдан гарахад байгаль орчин, гол усаа хамгаалсан хууль гарч байгаад олон хүн сайшаалтай хандаж байсан. Сүүлийн

арав гаруйхан жилийн дотор дэлхийн уур амьсгалын өөрчлөлт хүчтэй явагдаж, шинжлэх ухааны таамаглалаас бодит үнэн болон хувирсан. Мөн хүний буруутай үйлдлээс болж ус ихээр бохирдож, дэлхий нийтийн цэвэр усны нөөц хомсдох аюул тулаад байгаа юм. Манай улсад ч мөн сүүлийн жилүүдэд гадаргын ус багасах болсон. Энэ нь гол, мөрний эхэд уул, уурхайн олборлох үйл ажиллагаа явуулж буйтай шууд холбоотой. Тиймээс алсаа харсан шийдвэр гаргаж “Урт нэртэй” хуулийг бид ихээхэн ач холбогдол өгч хэрэгжүүлж байгаа” хэмээн БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын ахлах мэргэжилтэн С.Эрдэнэцэцэг тайлбарлалаа.

Хуулийн дагуу ашигт малтмал ашиглах, хайх, олборлохыг хориглосон газарт үйл ажиллагаа эрхэлж буй нийт 890 аж ахуйн нэгжийн 1782 тусгай зөвшөөрөл байгаа юм. Үүний 276 буюу 70 гаруй хувь нь алтны шороон орд, үлдсэн нь барилгын материалын, нүүрсний, бусад төрлийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд багтсан аж. Энэ дотроос алтны шороон ордынхон хамгийн азгүй хүмүүс гэх үү дээ. Хуулийн хэрэгжилттэй холбоотой юун түрүүнд Засгийн газраас өнгөрсөн оны арав, арваннэгдүгээр сард 138 аж ахуйн нэгжийн 246 алтны шороон ордын тусгай зөвшөөрлийн асуудлыг цэгцлэхээр шийдсэн. Үүний тулд хуулиар хориглосон газруудын Хил заагийг тогтоох 174, Байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн сэргээлтэд зарцуулах мөнгийг тооцож, тогтоох 264, Нөхөн олговрын хэмжээг тогтоох 299 дүгээр тогтоолыг тус тус гаргасан.

“Манайх мэргэжлийн баг гарган тооцон үзэхэд алтны шороон ордуудын хийх ёстой нөхөн сэргээлтийн зардалд нэг их наяд төгрөг, хөрс, ургамлын сан хөмрөг, ойн нөөц, амьтны аймагт, гадаргын ус болон агаарын тоосжилтод нөлөөлсөн байдлыг нь шалгуур болгон байгаль орчинд учруулсан хохирлыг нь тооцоход гурван их наяд төгрөг гарсан” хэмээн БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын орлогч дарга Д.Саран хэллээ.


Ийнхүү алтны шороон ордууд байгаль орчинд учруулсан хохирол болон нөхөн сэргээлтээ хийгээгүй тохиолдолд нөхөн сэргээлтийн зардлыг тэдэнд олгох нөхөн олговроос шууд суутган авна гэдгийг ч тэрбээр сануулав. Харин алтны шороон ордуудын нөхөн олговрын асуудлыг

Засгийн газрын 299 дүгээр тогтоолын дагуу ЭБЭХЯ, Сангийн яам, БОАЖЯ, АМГ зэрэг холбогдох байгууллагаас тооцон гаргажээ. Энэ талаар ЭБЭХЯ-ны Геологийн бодлогын газрын мэргэжилтэн Г.Цолмонгоос тодруулахад “Бидний тооцоолсноор 1782 тусгай зөвшөөрөлд шаардагдах нөхөн олговрын зардал таван их наяд төгрөг гарсан бол 246 алтны шороон ордын тусгай зөвшөөрөлд олгох нөхөн олговрын хэмжээ 511 тэрбум төгрөг гарсан. Энэ судалгааг компаниудаас авсан нөхөн олговрын нэхэмжлэлийн дүнг нэгтгэж гаргасан тул эхний судалгаанаасаа илүү бодитой болсон” гэлээ. Гэхдээ энэ тоо багсана уу гэхээс нэмэгдэхгүй гэдгийг ч тэрбээр мөн хэлсэн. Учир нь хэрэв татвараас зайлсхийсэн, зарим үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг биелүүлээгүй зэрэг хууль зөрчсөн тохиолдолд нөхөн олговрыг олгохгүй хэмээн хуульчилжээ. 246 алтны шороон ордын нөхөн олговроос байгаль орчны хохирол болон нөхөн сэргээлтийн зардал нь найм дахин их буюу дөрвөн их наяд төгрөгт хүрч байгаа нь компаниудынхныг ихээхэн бухимдахад хүргээд байгаа юм.

“Урт нэртэй” хуулиар хориглосон газруудад хамаарах тусгай зөвшөөрлийг хууль хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллагынхан бүтэн давхцалтай, хэсэгчилсэн давхцалтай гэж ангилж авч үзжээ. Энэ ангиллаар бол дээрх тусгай зөвшөөрлийн 134 нь бүхлээрээ, 112 нь хэсэгчилсэн давхцалтайд хамрагдхаар байна. Энэхүү ойлгомж муутай ангиллыг тайлбарлах нь учиртай. Нэг ёсондоо бүхлээрээ давхцалтай хэсэгт хамаарах тусгай зөвшөөрөлтэй компанийнхан шороон ордоо бүхлээр нь алдаж юу ч үгүй болно гэсэн үг.

Харин хэсэгчилсэн давхцалтай нь үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах маягыг бөглөж, ашиглах боломжтой аж. Эхнээсээ судалгаа, шинжилгээ муутай хууль баталснаас болж хэрэгжүүлэхэд ч хэцүү, хэрэгжүүлэхгүй байхад ч хэцүү байдалд ороод байгааг сануулах хүн олон байна.

Нэгэнт үлгэрт гардаг шиг мэргэн хаан байхгүй учраас хэрэгжүүлэх нь зөв үү, буруу юу гэдгийг хэн шийдэж чадах вэ. Нэгэнт эхэлсэн ажлыг хэл ам хэрүүл тэмцэл багатай шиг урагшлуулах учир байна уу гэж удган бөөгөөс асуух ёстой юу? ■



Хүн бүрт шинэ жилийн баярын тухай амьдрал хөглөсөн сайхан дурсамж байдаг. Бид энэ дугаартаа салбар салбарын төлөөллийн шинэ жилийн тухай тэр л сайхан дурсамжаас нь хуваалцсан юм.

Цагийн зөрүүг далимдуулж шинэ жилийг хоёр удаа тэмдэглэхдэг байж билээ

Д.Жаргалсайхан / “FSCO” корпораци”-ийн гүйцэтгэх захирал/:

-Шинэ жил болохоор л Москва хотын уул уурхайн дээд сургуульд сурч байсан үе маань санаанд ордог. Цагийн зөрүүг далимдуулж арван хоёрдугаар сарын 31-нд хоёр удаа шинэ жил тэмдэглэхдэг байж билээ. Цас ороод л, хүн бүхэн нүүрэндээ инээмсэглэл тодруулаад шинэ жил гэдэг тийм л гоё баяр. Москвагийн цагаар цаг 19:00 болж байхад Монголд 00:00 цаг болдог болохоор Монгол оюутнууд оргилуун дарс буудуулж ууж, идэж хэрэндээ л баярлачихна.

Харин Москвагийн цагаар 00:00 цагт оросуудтай хамт дахиад л шинэ оноо гаргаж бөөн юм болдог байж билээ. Тэгээд шинэ жилийн баярын маргаашнаас дараа оны арван хоёрдугаар сарын 31-нийг тэсэн ядан хүлээдэгсэн.



Шинэ жилээр үнэг болохыг их боддог байсан

Б.Сарантуяа / МУГЖ/:

Шинэ жил бүхэн өөрийн гэсэн дурсгалтай, дахин давтагдашгүй сайхан байдаг. Хүүхэд байхдаа анхны цаснаас эхлээд л шинэ жилийн баярыг тэсэн ядан хүлээдэгсэн. Би цэцэрлэгт явж байгаагүй учраас янз бүрийн амьтан болж үзээгүй. Тийм болохоороо ч тэр үү, шинэ жилээр үнэг болохыг их боддог байж билээ. Гэхдээ үнэг болж үзээгүй л дээ. Бас би багадаа шинэ оны цаана өвлийн өвөө шиг царайтай, ид шидтэй хэн нэгэн нууцмагдал хүн байдаг гэж боддог байсан. Яагаад ч юм бэ бүү мэд.

Харин дуучин болсноос хойш миний хамгийн дурсгалтай шинэ жил бол 2003 оных.

Учир нь, би Куба улс явж дууны клип хийлгээд “Алтан микрофон”-оос “Шилдэг аялагч” шагнал авсан. Мөн “Пентатоник”, “Алтан сарнай” зэрэг шагнал авсан мөчүүд шинэ оны баяр дээр баяр нэмсэн гоё үйл явдлууд байсан даа.



“Үгүй ээ..., нөгөө..., бишээ...”

С.Түмэнгэрэл / “Өгөөж чихэр боов” компанийн захирал/:

Миний багад шинэ жилийн баяраар багш, сурагчгүй чин сэтгэлээсээ багт наадамдаа бэлтгэнэ. Зургадугаар ангид байсан жил, сургуулийн урлагийн наадам өмнөх жилүүдийнхээс илүү өргөн хэмжээний боллоо. Сургуулийнхан дээр доргүй хичээгээд л. Хамгийн сайн гэсэн хүүхдүүдээ шилж сонгоод урлагийн үзлэгтээ бэлдлээ. Би ч ёс юм шиг шүлэг унших үүргээ авсан байв. Их л хичээж амьхандаа л сайн цээжилсэн юм. Багш нар ч дүрдээ ингэж орж унш, энэ үгэн дээр тэгж өргөлт ав гээд л. Урлагийн үзлэг ч боллоо. Тэгээд л тайзан дээр гараад, дүрдээ ороод л шүлгээ уншаад л байлаа. Тэгээд дуусдгийн даваан дээр шүлгийнхээ нэг мөрийг нь ор тас мартчихдаг юм байна. Хүмүүс нирхийтэл алга ташаад би тулгамдсандаа “Үгүй ээ..., нөгөө..., бишээ...,” гэж түгдрээд шүлгээ дахиад л эхнээс нь уншиж билээ. Тэгээд бөөн инээдэм болсон.



Аан тийм, ганц л удаа сармагчин болж байсан

М.Болд /“Тэнгэр санхүүгийн нэгдэл” ХХК-ийн гүйцэтгэх захирал/:

-Шинэ жил бүхэн гоё. Өнгөрсөн ондоо хийж бүтээсэн ажлаа дүгнэж, ирээдүйд хийх итгэл зориг төгс он цагийн зааг. Тэр утгаараа хувийн ажил амьдрал, албан ажил бүгд үр бүтээлтэй байсан оны шинэ жил дурсгалтай байдаг. Харин бага насны минь дурсамж бүхэн л шинэ жилтэй салшгүй холбоотой. Өвлийн өвөө, ууттай бэлэг, цасан охид бүгд бага насанд минь ид шид мэт санагддаг байсан одоо ч тэгж л санагддаг. Арван жилд байхад шинэ жилийн урлагийн үзлэг болно. Тэр урлагийн үзлэгийг их хүлээдэг байж. Гэхдээ би ямар нэгэн амьтан болж, эсвэл дуу дуулж, шүлэг уншиж байсан удаагүй. Аан тийм, ганц л удаа сармагчин болж байсан юм байна./инээв/



Дараа жилийн хамгийн том зорилго санаанд буудаг

Ш.Наран /СТА дуучин/:

-Санаанаас гардаггүй олон шинэ жил бий. Гэхдээ хамгийн сайхан нь хүүхэд ахуй насны минь шинэ жил юм даа.Шинэхэн гацуурын үнэр гэрээр нэг ханхалсан өвлийн орой... Бүтэн жил хүсэн хүлээсэн энэ л мөч гэрэл ойсон томоос том шилэн чимэглэлүүдийг, нов ногоон гацуурын мөчирт догдлон өлгөж, гэрийнхэнтэйгээ хамт зогссон багын минь баяр хөөр одоо ч нүднээ илхэн.

Шинэ жил дөхөөд ирэхээр Орт-1 сувгаар үлгэрийн кинонууд гарч, гудамж талбайгаар зөрөн алхах хүмүүсийн царай гэрэлтээд л, ямар нэг гайхамшигт зүйл болох гэж буй мэт сэтгэгдэл цаанаасаа ундран гардаг.Орой бүр өөрийн зассан гацуурын дэргэд ороо засаад, унтахаар хэвтэхэд, түмэн өнгөөр солонгорох шилэн боргоцой, байшин, элдэв амьтдын дүртэй тоглоомууд эргэлдэн, тэдний дундаас томоос том шүрэн улаан бөмбөлөгийн гялгар гадаргуун дээр царай минь ойсныг харах үнэхээр гайхамшигтай. Бүх зүйл илбэ шид, үлгэрийн ертөнцийн үүд хаалгыг нээсэн мэт санагдаад л...



Тэр үеэс хойш туршлагатай “шинэ он” болдог болсон доо

Ж.Алдаржавхлан / “Орон сууцны санхүүжилтийн корпорци”-ийн гүйцэтгэх захирал/:


-Би багадаа гэр амьтай, их даруухан хүү байсан санагддаг юм. Шинэ жилийн баяраар ч гэсэн гэртээ л он гаргахыг илүүд үзнэ. Миний багад өнөө үе шиг ийм элбэг хангалуун байгаагүй. Тэр утгаараа шинэ жилийн үеэр идэж байгаа бүхэн амттай, өмссөн бүх хувцас хорвоогийн хамгийн чамин, тансаг зүйл мэт санагддаг байж билээ. Энэ нь өөрийн гэсэн үнэ цэнийг бий болгож, жил бүрийн шинэ жил дахин давтагдашгүй байдагсан. Тэр үеийн гацуурын гэрэл одоогийнх шиг ийм олон янз байгаагүй. Би сургуулийнхаа шинэ жилийн арга хэмжээнд жил бүр “шинэ он” болдог байсан юм. Шинэ оны тухай шүлэг цээжлээд их бэлдэнэ ш дээ. Нэгдүгээр ангид байхдаа анх удаа шинэ он болсон юмдаг. Дээл өмсөөд тайзан дээр гарах гэсэн чинь бүс байдаггүй. Тэгэхээр нь сандарсандаа хүүхдийн ороолт бүслээд гарчихаж билээ. Тэр үеэс хойш туршлагатай “шинэ он” болдог болсон доо.



Орос мандарин үнэртэхээр л шинэ жилийн хамаг дурсамж сэргэдэг

Л.Болдгэрэл / “New voice” ХХК-ийн захирал/:

Орос мандарин үнэртэхээр л шинэ жилийн хамаг дурсамж санагддаг юм. Гацуур мод, цасан ширхэг, өвлийн өвөө, цасан охид бүгд нүдний өмнө харагдаад эхэлнэ шүү дээ. Шинэ жилээр бүх зүйл үлгэрийн мэт сонихон санагддаг. Тэр тусмаа бага байхад өвөл ид шидийн улирал мэт санагдаж, өвлийн өвөөг өөрийн эрхгүй хүлээдэг байж билээ. Миний багад шинэ жилийн багт наадамд хүн бүр чин сэтгэлээсээ оролцоно. Би ихэнхдээ багт наадмаар туулайн бүжин болдог байж билээ. Нэг удаа бага ангид сурдаг байсан санагдаж байна. Бүжингийн багаа зүүгээд, урдаа гараа авчихсан дэгдээд үсэрч байсан чинь өмссөн хувцсандаа түүртээд яг унахын даваан дээр багшийнхаа хөлнөөс тэврээд авч билээ. /инээв/ ■



Хууль

Компанийн тухай шинэ хуульд хүмүүс ам сайтай байна

Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж байгаатай холбоотойгоор Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болсон. Тиймээс цаг үеийн шаардлагаар тус хуульд өнгөрөгч арваннэгдүгээр сарын 23-нд нэмэлт, өөрчлөлт оруулж баталсан. Компанийнханд ирэх оны долдугаар сарын 1-нийг хүртэл хуультайгаа танилцаж, өөрсдийн байгууллагын дүрэм, журмаа шинэ хуулийн зүйл заалтуудтай нийцүүлж

Улсын бүртгэлд бүртгүүлэх ёстой юм байна. Ингэхэд ямар нэгэн хураамж төлбөр авахгүй гэнэ. Манай улсад одоогийн байдлаар 60 гаруй мянган аж ахуйн нэгж, компани байгаагаас 90 орчим хувь нь ХХК хэлбэрээр байгаа гэсэн статистик бий. Компанийн тухай шинэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар холбогдох мэргэжилтэн, судлаач, зарим бизнесийн байгууллагын төлөөллөөс тодрууллаа.

Д.Баалыхүү /Төрийн өмчийн хорооны зөвлөх/:



Хуулинд ойролцоогоор 400 орчим нэмэлт, өөрчлөлт оруулж, иргэдэд илүү нээлттэй ил тод, нөгөө талаас компаниудын хариуцлагын тогтолцоог нарийвчлан гаргаснаараа онцлог болсон гэж бодож байгаа. Хуулийг аль болох өнөөгийн компанийн дэлхий нийтийн жишигт нийцүүлэхийг зорьж, ил тод, олон нийтэд нээлттэй, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан нөгөө талаасаа бизнес эрхлэгчдэд урт удаан хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах орчныг бүрдүүлснээрээ давуу талтай юм. Жишээлбэл, хуулийн хамгийн их маргаантай байдаг ТУЗ-ийн эрх үүрэг, илүү нээлттэй ил тод болгож өгсөн. Ингэхдээ компаниуд санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор буюу ирэх оны гуравдугаар сарын 1 гэхэд хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийж, санхүүгийн тайлангаа

ирүүлэх ёстой. Үүнийг зөрчсөн тохиолдолд тус компанийн ТУЗ-ийн бүх гишүүдийг гурван жилийн хугацаанд ажлаас нь чөлөөлөхөөр хуулинд тусгасан байгаа. Мөн хувьцаат болон төрийн өмчийн компанийн ТУЗ нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдний гуравны нэгээс доошгүй хувь том хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх албан тушаалтнаас хараат бус хүн байхаар зааж өгснөөрөө онцлог юм. Түүнчлэн урд нь байнга хөндөгддөг байсан хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хууль эрх зүйн хүрээнд илүү хамгаалж өгсөн. Өмнө нь зөвхөн хувьцааны нэг хүртэл хувийг эзэмшдэг хүн ямар нэг гомдол гаргах эрхтэй байсан бол шинэчилсэн хуулиар хувьцааны хувь хамаарахгүйгээр хүссэн хүн бүхэн гомдол гаргах эрхийг нь олгосон. Мөн хариуцлагын тогтолцоог гаргаж өгснөөрөө онцлог болсон. Ингэхдээ буруутай албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин, байгууллагыг 15-30 дахин өсгөж торгохын зэрэгцээ учруулсан хохирлыг төлүүлэх, захиргааны хариуцлага тооцно.

Д.Зоригт /УИХ-ын гишүүн, эдийн засгийн байнгын хорооны дарга/:



Манай улсын эдийн засаг өсч байна. Үүнийг дагаад гадаад, дотоодын хөрөнгө оруулалт ч сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэх болсон. Гэхдээ Компанийн тухай хуулинд ил тод байдал алдагдсан, компанийн сайн засаглал дутагдалтай тул хөрөнгө оруулалтад саад болдог. Тиймээс энэ хуулийн хэрэгжилт амжилттай болсноор манай эдийн

засгийн салбарт томоохон боломжууд шинээр гарч ирэх үүд нээгдэнэ. ХК-ийн хувьд ТУЗ-ийн 50 хувь хараат бус гишүүн байх, хурлаа хийхдээ бүх хувьцаа эзэмшигчдэдээ зар товыг хүргэж байх гэх мэт тэдний эрх ашгийг хамгаалахад анхаарсан. Цаашлаад компаниудын үүрэг хариуцлагын тогтолцоог чангатгаж өгснөөрөө шинэлэг болсон. Гэхдээ хууль цаасан дээр сайн батлагдан гарсан ч үр дүнтэй хэрэгжүүлэх нь л хамгийн чухал асуудал юм.

Б.Лхагважав /Үндэсний “Соёмбо” хөдөлгөөний тэргүүн/:



Өмнө нь мөрдөж байсан компанийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байсан. Бараг тийм хууль байдаг эсэхийг мэдээгүй өнгөрсөн гэж хатуухан хэлэхэд болно. Ер нь энэ хуулийн хүрээнд өмчийн

харилцааг зүй зохистой зохицуулах асуудал л чухал. Өмчийн маргаанаас болж маш олон компани дампуурсан түүх бидэнд бий. Одоо л манай улс барууны хэв маягаас суралцаж эхэлж байна гэхэд болно. Компанийн тухай шинэчилсэн хуулийг нь он гарахаас өмнө олоод танилчихаж болох байлгүй дээ. ▶

► **Т.Жамбаажамц /СЗХ-ны Үнэт цаасны газрын ахлах хянан шалгагч/:**



Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаас бидний хүлээж буй үр дүн бол товчхондоо Монголд компанийн сайн засаглалын орчинг бүрдүүлж, дэлхийн жишигт нийцүүлэхэд түлхэц болоход байгаа юм. Хуулинд олон улсын шалгагдсан компанийн засаглалын шилдэг туршлагауудыг хэрэгжүүлэх талаар тодорхой тусгасан. Үүний нэг нь ТУЗ-ийн хүлээх үүрэг, байр суурийг нарийн тусгаж өгсөн. Ингэхдээ компанийн ТУЗ мэргэжлийн чиглэлийн хороотой байх шинэ зохицуулалт оруулж ирсэн. Ялангуяа хувьцаат компани заавал гурван /аудитын, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын/ хороотой байх бөгөөд гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус байх юм. Мөн хорооны үйл ажиллагааных нь чиглэл, эрх үүргийг тодорхой зааж өгснөөрөө онцлог. Ингэснээр хувьцаа эзэмшигчдэд илүү нээлттэй ил тод үйлчлэхийн зэрэгцээ компанийн үйл ажиллагаа тогтворжих, цаашид өсөж дэвших үндэс болж өгөх юм.

Өөр нэг орж ирсэн шинэлэг өөрчлөлт бол компанийн

нэгдэл гэсэн ойлголтыг шинээр оруулж ирсэн. Үүнд бидний хэлдгээр групп болон өргөжсөн толгой компани охин компанитайгаа нэгдсэн тайлан гаргах зохицуулалт оруулсан. Мөн толгой ба охин компани хоорондын харилцаа, үйл ажиллагаанаас үүсэх үр дагавар, хүлээх хариуцлагын зохицуулалтыг өөрчилсөн. Тухайлбал, толгой компанийн шийдвэрийн улмаас охин компани төлбөрийн чадваргүй болсон бол толгой компани хамтран хариуцна. Харин толгой компанийн шийдвэрээс болж охин компани алдагдалд орсон бол хохирлыг толгой компаниар төлүүлэхээр шүүхэд хандах эрхийг олгосон. Үүнтэй холбоотойгоор компанийн төрөл хэлбэрийг илүү нарийн тодорхой гаргаж өгсөн юм. Ингэхдээ ХК-ийг Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлж, түүгээрээ дамжуулж хувьцаагаа нийтэд чөлөөтэй арилждагийг нь нээлттэй, харин дээрх байгууллагад бүртгэлгүй, хувьцаагаа үнэт цаасны хадгаламжийн байгууллагад бүртгүүлэн, биржээс гадуур арилжаалдаг бол хаалттай гэж ангилсан. Харин ХХК-ийн хувьд хувьцааны захиран зарцуулах эрх нь хууль дүрмээр зохицуулагдаж, үнэт цаасыг хаалттай гаргахаар тогтоосон.

М.Мөнхжаргал /“Бодь” группын Хуулийн хэлтэс, үйл ажиллагааны газрын хуульч/:



Компанийн тухай шинэчлэгдсэн хуульд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан, компанийн хэлбэрийг тогтоосон, илүү ил тод, нээлттэй болсон зэрэг шинэлэг, цаг үеэ олсон зохицуулалтуудыг оруулж өгсөн санагдсан. Жишээ нь компанийн нэгдэл гэдгийг тодорхойлж өгсөн. Энэ нь охин болон толгой компани хоёрын хоорондох харилцааг нарийн тодорхойлж эрх үүргийг нь гаргаж өгсөн нь тун зүйтэй юм. Нэг ёсондоо энэ нь манайх шиг групп болон өргөжсөн компаниудын стастусыг тодорхой болгож өгсөн гэсэн үг. Тиймээс бидний үйл ажиллагааг ихээхэн хялбаршуулж байгаа. Мөн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл авах эрхийг хуульчилж өгсөн нь зүйтэй санагдсан. Түүнчлэн өмнө нь хувьцаа эзэмшигч ногдол ашиг хаанаас авах, хэдийг авах эсэх тодорхойгүй байдаг байсан бол үүнийг илүү тодорхой болгон хуульчилсан байсан. Ингэхдээ ТУЗ санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол

авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргаж, хэзээ олгох, хэчнээн хэмжээтэй байх вэ гэдгийг мэдээлэх ёстой юм билээ. Хувьцаа эзэмшигч ногдол ашгаа аваагүй хоцорсон тохиолдолд компанийн өр болгон нягтлан бодох бүртгэлдээ хадгалж, анхны шаардлагаар нь буцаан олгох нөхцөлөөр заагдсан нь тун зүйтэй юм. Гэхдээ зарим талаар хууль боловсруулагчдын хувийн ашиг сонирхол орсон тал ажиглагдсан. Жишээ нь, ТУЗ-ийн гишүүн, нарийн бичиг нь заавал мөнгө төлж, сургалтад суун гэрчилгээ авах ёстой гэсэн нь нэг талаараа бизнесийн шинжтэй заалт юм. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийсэн иргэдээ нийтэд заавал мэдээлэх ёстой гэж заасан нь ХХК-д тохирохгүй. Уг нь хууль хэлэлцэж байх үеэр дээрх заалт зөвхөн ХК-д хамааралтай гэж байсан бол одоо ХХК-д хамааралтай болж байгаа нь зөв зүйл биш юм. Би хуулийн бүх заалтуудыг хуучинтай нь тулгаж үзээд, энэ долоо хоногтоо багтаад захирал, удирдах албан тушаалтнуудаа танилцуулах юм. Тэгээд байгууллагын дүрэм, заалтууддаа ямар ямар өөрчлөлт оруулж, хуульд нийцүүлэхээ шийднэ.

Хуан Карлос Фернандес /ОУСК-ийн Зүүн Ази, Номхон далайн компанийн засаглал төслийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн/:



Дэлхийн олон улсын байгууллагуудаас улс орнуудад эдийн засагт таатай орчин байгаа эсэх судалгааг явуулахад Монгол 86-д жагсжээ. Энэ нь дундаж л түвшин юм. Тиймээс компанийн сайн засаглалын дэлхийн шилдэг туршлагауудыг Компанийн тухай хуульд ихээхэн нэвтрүүлж өгсөн. Үүний тод жишээ бол ТУЗ-ийг зөв зохистой зохион байгуулах,

санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллээ олон нийтэд ил тод олгох, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг ардчилсан тэгш байдлаар хангах чиглэлийг барьснаас харж болно. Мөн компанийн эрх, үүрэг, хүлээлгэх хариуцлагын тогтолцоог ч нарийвчилж өгсөн. Бид бүхний зүгээс энэ хууль Монголд амжилттай хэрэгжиж, үр дүн авчраасай гэж хүсэж байна. Нэг талаасаа байгууллага, хувь хүн хариуцлагаа бүрэн ойлгож дагаж биелүүлж, нөгөө талаас төр засаг, хяналтын байгууллагууд хуулийн хэрэгжилтэд хатуу хяналт тавьж байх нь хууль хэрэгжиж чухал хөшүүрэг болж өгнө. ■

Уншигчийн булан

Иргэдийн эдийн засгийн боловсролд хөрөнгө оруулалт хийх үйлсээ арвижуулаарай

А.Шагдарсүрэн/“Номин холдинг” ХХК-ийн зөвлөх, Монгол Улсын худалдааны гавьяат ажилтан/:

Сүүлийн хэдхэн жилийн дотор манай улсын данс аривжиж, эдийн засгийн хувьд өндөр өсөлттэй байх болсон. Үүнтэй холбоотойгоор компанийн эзэд, бизнес эрхлэгчид болон ард иргэдэд эдийн засгийн энгийн ойлгомжтой, цаг үеэ олсон мэдээлэл их хэрэгтэй болдог билээ. Танай сэтгүүл энэхүү орон зайг нөхөж, хүмүүст эдийн засгийн чиглэлийн мэдээллийг үнэн бодитой, энгийн хэлбэрээр хүргэж байгаад их баяртай байна.

Ер нь хүн бүхэн л эдийн засгийн мэдлэгтэй байх хэрэгтэй. Наад зах нь олсон хэдэн төгрөгөө амьдрал ахуйдаа яаж зарцуулах вэ, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалыг

төлснөөр ямар хэрэгтэй вэ, тэтгэвэр тэтгэмж, хувьцаа эзэмших гээд л энгийн өдөр тутмын амьдралд мэдэж, ашиглах шаардлага тулгардаг. Харин компаниудын хувьд дэлхийн болон Монголын эдийн засаг хаашаа чиглэж байна, ямар томоохон хууль эрх зүйн шийдвэрүүд гарч байгаа зэрэг мэдээллийг авах бололцоог олгодог учир бидний ажилд их тус болдог.

Цаашдаа илүү үр өгөөжтэй мэдээллийг нийтэлж, хувь хүн бүрийн эдийн засгийн боловсролд хөрөнгө оруулалт хийх үйлсээ арвижуулаарай гэж хэлье. Та бүхний ажилд амжилт хүсье.

“Амьдрал” булан надад хамгийн их таалагддаг**А.Түвшинбаяр/МУБИС-ийн Түүх нийгмийн ухааны сургуулийн филисофи, улс төр судлалын III ангийн оюутан/:**

-Эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг судалгаатай, эх сурвалж сайтай нийтэлдэг болохоор их таалагддаг. Мөн улс орны хүрээнд шийдэгдэж буй томоохон бодлого, хөрөнгө оруулалт, гэрээ хэлэлцээр УИХ, Засгийн газраас гарч буй хууль, шийдвэрүүдийг ч нарийн задлан ойлгомжтой, мэргэжлийн түвшинд нийтэлж байгаа нь оюутан бидэнд ч хэрэгтэй байдаг. Миний хувьд сургуулийнхаа илтгэх урлаг, парламентын мэтгэлцээний “Эйдос” клубыг хариуцдаг. Тиймээс байнга сүүлийн үеийн нийгэм, эдийн засгийн шинэлэг мэдээллийг ашиглан клубын гишүүддээ хичээл заах эсвэл өөрөө мэтгэлцээний тэмцээнд оролцох үедээ зайлшгүй ашиглах шаардлага гардаг. Энэ орон зайг “Mongolian Economy” сэтгүүл нөхөж, бидэнд мэдлэг, мэдээлэл өгч байдаг нь их баярладаг.

Дээр нь “Амьдрал” булан надад хамгийн их таалагддаг. Өнгөрсөн сарын дугаарт орсон Цэнгэл хэмээх хараагүй

залуугийн амьдралын талаар “Харанхуй дундах гэрэл” нийтлэл үнэхээр сургамжтай санагдсан. Хараагүй мөртлөө англи хэл бие даан хичээнгүйлэн сайн сурч, хараагүй хүмүүст багшилж байгаа Цэнгэлийн тухай уншаад эрүүл саруул мөртлөө англи хэл сурахыг бараг л “мөрөөдөл” болгож, хойш нь тавьж байгаа өөрийгөө болон үеийхнээ хараад үнэхээр ичмээр санагдсан. Нөгөө талаас хүн нэг л олдох амьдралынхаа эзэн нь байхын тулд тууштай байж, шаргуу хөдөлмөрлөвөл юунд ч хүрч болдог гэдгийг тод харуулж өгсөн байсан.

Мөн сэтгүүл англи, монгол хэлээр гардаг байдаг болохоор монголтой нь тулган уншиж, хэлний мэдлэгээ дээшлүүлэх боломжийг олгож байгаагаараа ихээхэн ач холбогдолтой. Эрдмийн буян эрхэм дээд гэсэн үг байдаг. Монголын ирээдүйг атгалцах оюутан залуусынхаа оюунд хөрөнгө оруулалт хийж буй та бүхэнд өөрийнхөө болон үеийн залуусынхаа өмнөөс баярлаж буйгаа илэрхийлье.

Өөртөө тусгаж авч, амьдралдаа хэрэгжүүлэхээр зүйл олон байдаг**Ч.Чулуунболд /“Үндэстэн” фото сайтын сэтгүүлч/:**

-Эдийн засгийн мэдээ, мэдээллийг хүн бүхэнд энгийнээр ойлгуулахад чиглэсэн болохоор манайд үгүйлэгдэж буй томоохон орон зайг нөхөж гарч ирсэн гэж санагддаг. Тиймээс нийтлэл бүртээ нухацтай хандаж, өргөн мэдээлэлтэй, хүртээмжтэйгээр бичдэг тул би нэг удаа уншаад орхих биш байнга давтан уншиж, мэдээллээр нь өөрийгөө цэнэглэдэг. Мөн хүснэгт, график өргөн ашигладаг нь мэдээллийг илүү ойлгомжтой болгосон санагддаг.

“Шинжээч бичиж байна”, Д.Энхбатын болон Ч.Отгочулуугийн булангууд сонирхолтой шүү. Жишээ нь, аравдугаар сарын дугаарт Д.Энхбатын “Атомшикуудтай маргах нь” нийтлэл атомын цахилгаан станцын талаар дэлгэрэнгүй, ойлгомжтой бичсэн нь их таалагдсан. Энэ нийтлэлийг ямар ч хүн уншаад атомын цахилгаан станцын

талаар бүрэн мэдээллийг авч болохоор юм билээ. Тиймээс танин мэдэхүйн ихээхэн ач холбогдолтой юм.

Түүнчлэн “Нэг өдөр” буланд “Зөв газраа зөрүүд зангаа гаргаж яваа хүн” материал нь наанаа хүний нэг өдрийн хэмнэлийг харуулсан юм шиг мөртлөө цаанаа залуучуудад ажил, амьдралаа төлөвлөх, зохион байгуулах, өөрийгөө хөгжүүлэхийн ач холбогдлыг харуулж өгснөөрөө үлгэр дууриалтай. Нэг ёсондоо баян, ядуу, сайн, муу гэж ялгалгүй хүн бүхэнд өдөрт 24 цаг ногддог. Түүнийг хэр үр дүнтэй ашиглаж байгаагаас хамаарч хүний амьдралын хувь заяа шийдэгддэг гэдэг. Тэгвэл нэг өдрийн үнэ цэнийг яаж үр ашигтай, бүтээмжтэй өнгөрүүлж байгааг эндээс харж, өөртэй тусгаж авмаар санагдсан. ■

MONGOLIAN
ECONOMY

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ,
БИЗНЕСИЙН СЭТГҮҮЛ

"Mongolian Economy"

СЭТГҮҮЛ

14

хоног тутамд

ТАНД ХҮРНЭ



Нэг өдөр

Өдөрт хоёр удаа шинэ ажлын өглөөтэй золгодог захирал

Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал 29-хөн настай Хангайн Алтай” хэмээн “Financial Times” сэтгүүл түүнийг “Boomtown Mongolia” нийтлэлдээ онцолсон удаатай. Манай сэтгүүл энэ удаа орчин үеийн их хөгжлийн хэмнэлтэй хөл нийлүүлэн алхаж, тэр чинээгээрээ улсынхаа хөгжлийг урагшлуулахад өөрийн хүч оюун, хөдөлмөрөө зориулж яваа ажил хэрэгч залуусын нэг өдөр хэрхэн өнгөрдгийг сонирхлоо. Манай “Нэг өдөр” булангийн зочноор Монголын хөрөнгийн биржийн захирал Х.Алтай уригдлаа. Тэрбээр “Би ямар сонгуульд оролцох гэж байгаа биш миний хэрэг байна уу” хэмээн инээмсэглэн биднийг угтсан.

Бага үд

Наран мандах цаг хойшилсон өвлийн улиралд жихүүн салхитай өглөө айлчлан ирнэ. Гэгээ орж гэрэлт ертөнц өнгөөр туяарах агшинтай уралдан Х.Алтай захирал ажил руугаа орж харагдана. Түүний ажил үүр цүүрээс үдшийн бүрий хүртэл тасралтгүй үргэлжлэх ажээ. Ширээнийхээ ард тухлан сууж, өнөөдрийн ажлаа жагсаан бичээд нямбай гэгч нь танилцсаны эцэст Алтай захирлын ажлын шинэ өдөр эхэлнэ. Лондоны хөрөнгийн биржтэй байгуулсан түншлэлийн хүрээнд манай хөрөнгийн биржид өөрчлөлт шинэчлэл өрнөөд хөл хөдөлгөөн ихтэй байгаа билээ. Өөдлөх айл үүднээсээ гэдэгчлэн МХБ гаднах өнгөө өөрчилж, гангараад амжиж. Лондоны хөрөнгийн биржтэй хамтран Арилжаа, хяналт, хадгаламжийн шинэ системээ суурилуулж байгаа тэд туршилтын ажлаа эхэлчихсэн тул тун завгүй. Х.Алтай, үгүй ээ тэд гэж ярих ёстой юм байна. Учир нь МХБ-ийн захирал “Би” биш “Бид” гэж ярих дуртай. Шинэ системийнхээ туршилтын явцыг хэлэлцэхээр товчхон бөгөөд тодорхой хурал хийв. Гарч ороод л үнэндээ түүний ажил барагдахгүй юм. Түүний энэ өдрийн шил дараалсан олон уулзалтын хамгийн чухал нь Монголбанкинд болох арга хэмжээ юм. Тус уулзалтын үеэр Алтай захирал Үнэт цаасны төлбөр тооцоог гүйцэтгэх, хугацааг өөрчлөх, олон улсын жишигт хүргэх талаарх шинэчлэлтэй холбоотой танилцуулга хийсэн. Таван хором ч тайван суух завгүй түүнээс сонирхсон зүйлээ тухтайхан асуухад ч хэцүү санагдах.

Тэрбээр Орос 14 дүгээр сургуулийг дүүргэсэн орос хүмүүжилтэй залуу захирал. Хангайн Алтай гэж дипломат албатай эцгийнх нь нэрээр түүнийг тодотгож ч ярих дуртай юм билээ, хүмүүс. “Financial Times”-ийн сэтгүүлч хүртэл түүний тухай нийтлэлдээ Хангайн Алтай гэж онцолсон байх жишээтэй.

МУИС-д эрх зүйч мэргэжлээр сурч байхдаа зуны амралтаараа зүгээр суулгүй орчуулагч хийж, жуулчид дагуулан, Монголын үзэсгэлэнт олон газраар аялсан нь түүний оюутан насных нь сайхан дурсамжуудын нэг. Тэрбээр сургуулиа төгсөөд Швейцар улсын MRI уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалдаг компанид жил гаруй хугацаанд дадлагаар ажиллажээ. Үүний дараагаар “Бороо гоулд”-ын Засгийн газартай харилцах ажилтан, С.Баярын шадар туслахаар тус тус гүйцэтгэж байжээ. Харин одоо Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал бас Ерөнхий сайдын орон тооны бус зөвлөхийн албыг хашиж байгаа юм.

Жин үд

Нар эгц дээрээс тусах авч элчээ харамлан жихүүцүүлнэ. Өвлийн өдрүүд энэ л цагт сэтгэл сэргээж дотор бүлээцүүлэх юм даа хэмээн Монголбанкнаас хөрөнгийн бирж рүү буцах замд бодогдох. Үнэт цаасны арилжаа ажлын өдөр бүр 11.00-13.00 цагийн хооронд явагддаг. Энэ том байгууллагыг удирдаж байгаа хүний хувьд өнөөдөр хэдэн төгрөгийн арилжаа явагдах бол, компаниудын маань хөрөнгө ▶



► босгох үйл ажиллагаа хэр амжилттай яваа бол гэх мэт санаа зовних зүйлс олон ажээ. Түүний завсаргүй шахам болох уулзалт, хурал нь дуусахгүй үргэлжилсээр. Түүнд маргааш гэж хойшлуулах цаг зав, зуршил гэдэг зүйл байдаггүй бололтой. “Хийхгүй бол болохгүй юм чинь амжуулах л ёстой” гэж боддог аж. МХБ-ийн шинэчлэлийн ажлын явцын талаар Ерөнхий сайдад танилцуулах тул Алтай захиралд өдрийн цайндаа ч орох зав олдсонгүй. Өдрийн хоолоо идэхгүй байх тохиолдол цөөнгүй гардаг гэсэн. “Өгөг тэгээд амттай байдаг юм” гээд л хоолны оронд “Sneakers” идчихнэ. Зуучлалын үйл ажиллагаа явуулахаар МХБ-ийн гишүүн болох гэсэн олон тооны компанийн материал түүний ширээн дээр овоорчээ. Энэ асуудлыг хэлэлцэхээр тэрбээр захирлуудтайгаа тун ч удаан хуралдлаа.

Алтай захирал эхнэр, дэрсхэн төрсөн хүү, охиныхоо хамт амьдардаг. Хэдийгээр их ажилтай ч хүүхдүүдээ цэцэрлэг, сургуульд нь хүргэж өгөхийг байнга хичээдэг. Монголын хөрөнгийн бирж гэгч энэ их айлын хойморт сууснаас хойш түүнд өөрийн гэр бүлдээ зориулах цаг ахархан болсон хэдий ч амралтын өдрүүдэд тэдэнтэйгээ хамт гадуур явж кино үзэх, тоглуулахаар амласнаа аль болох хойшлуулахгүйг бодно. Амралтын өдрөөр малгайтай цамц, саравчтай малгай өмсчихөөд явж байх түүнд тааламжтай санагддаг ч албаны хувцсандаа илүү дасчихсанаа мэдэрдэг гэнэ.

Их үд

Наран ургасан зүгээсээ нүүрээ буруулж, ертөнцийн нөгөө чигт яаран тэмүүлсээр жарган одлоо. Өвөл цагийн өдөр богино хэдий ч өнгө өнгийн гэрэл өөрийгөө гайхуулан солонгорно. Ажлын цаг дууссан ч Алтай захирлын хувьд дөнгөж эхэлж байгаа мэт хийх зүйл ундарсаар. Таны ажил дуусах болоогүй юу гэхэд “Бид Лондоны хөрөнгийн биржтэй хамтарч ажиллаж байгаа болохоор цагийн зөрүүнээс хамаараад Монголд ажлын цаг дуусаж байхад Монголын хөрөнгийн биржийнхний

хувьд ажил дахин эхдэг” гэсэн юм. Яг одоо Лондонд өглөөний 11 цаг болж байгаа. Тэгэхээр Алтай захирал өдөрт хоёр удаа шинэ ажлын өглөөтэй золгодог ажээ. Найзуудтайгаа оройн хоол идэж, ажлаа ярих нь Алтай захирлын өнөөдрийн төлөвлөгөөнд туссан сүүлийн ажил. Түүний гэртээ харих цаг ихэнхдээ 21.00 цаг гэж бодохоор Алтай захирал өдөрт 12 цаг тасралтгүй ажилладаг юм байна.

Тэрбээр ажлын алжаалаа хөгжим сонсож, ном унших, баримтат кино үзэх зэргээр тайлдаг. Уран зохиолын гэхээсээ илүү бодит түүх, хүний намтар унших дуртай. Яг одоо уншиж байгаа номнууд дундаас хамгийн сонин нь зохиолч Эдвард С Радзинскийгийн “Сталин” хэмээх түүхэн намтар зохиол. Харин сонсох дуртай хөгжмийн урсгал нь “Алтернатив”. Тэрбээр анх хүүхэд байхдаа “Beatles” хамтлагийн дуунд дурлаж, үгийг нь ойлгохыг хүссэн учраас англи хэл маш шаргуу сурч эхэлсэн ажээ. Харин одоо түүнд “Keane”, “Kate Rusby”, “Radio Head” хамтлагийн дуунууд таалагддаг. Гарч орж, бичиг цаастай ноцолдсон энэ их ажлын дундуур хэдий заванд нь амжуулдаг юм бол оо гэж асуумаар зүйл түүнд зөвхөн ном уншихаар хязгаарлагдахгүй. Бялдаржуулах төвд очиж хичээллэхээс гадна цаг зав, цаг агаарын байдлаас хамааран хааяа хөлбөмбөг тоглохоо ч мартдаггүй гэсэн.

Өөрийнхөө талаар “Би бол” гэж ярих дургүйг дээр хэлсэн. “Хүн өөрийгөө дүгнэж цэгнээд сууна гэдэг ерөөсгөл” гэж боддог гэнэ. Олон таван юм нуршиж яриад байхыг хүсдэггүй, харин хийж буй ажлаараа өөрийгөө харуулахыг зорьдог залуухан захирал юм гэж дүгнэхэд хүргэв. Нойрмог байдалтай Монголын хөрөнгийн биржийг олон тоглогчоор хүрээлүүлсэн хөрөнгийн захын сонгодог хөгжилд аваачих нь түүний хэтийн зорилго. Гэхдээ Алтай захирал ийм сайхан үед эх орондоо энэ ажлыг хийж яваагаа их хувь тавилан гэж боддог. Одоо түүнд зорьсон ажлаа дуусгах маргаашийг хүлээх л үлдлээ. ■

Шинэ санаа яаж төрдөг вэ?

Аливаа бизнесийн анхны алхам юу байдаг вэ? Хэрвээ Та ажлын байр, хүний нөөц, банкны зээл, хөрөнгө оруулалт гэж бодож байгаа бол андуурч байна. Бичил, жижиг, дунд, том, өргөжсөн өргөжөөгүй бизнес бүрийн анхдагч нь ердөө л шинэ санаа байдаг юм. Нэгэнтээ төрчихсөн санааг сайтар усалж тордвоос мөрөөдлөөс бодит амьдралд ажил хэрэг болон цэцэглэж, үр өгөөжөө өгч эхэлдэг.

Оросын “Форбес” сэтгүүл таван бизнес эрхлэгчээс ямар тохиолдолд хамгийн сайн, ашигтай санаа хүний толгойд буудаг талаар асуусныг хөрвүүлэн танилцуулж байна.

Олег Тиньков /“Тинькофф. Зээлийн тогтолцоо” банкны ТУЗ-ийн дарга/:

-Сайн бизнес санаа олж авахыг хүсэж байвал ажлын талаар огтхон ч бодох хэрэггүй. Би 3-4 цаг дугуй унаж толгойгоо сэргээх дуртай. Ингэсний дараа сэтгэх үйл явц мэдэгдэхүйц сайжирдаг. Ер нь амжилтад хүргэх санаа янз бүрийн нөхцөл байдлаас урган гардаг. “Дарья” нэртэй баншны бизнесийг би Петербургт саунд орж байх зуур банш хэвлэдэг тоног төхөөрөмж зардаг грек залуутай танилцах зуур бодож олсон юм. Мөн шийдвэр гаргахдаа мэргэжлийн хүмүүстэй уулзаж, тэднээс зөвлөгөө авахыг хичээдэг. Миний хувьд бизнес санааг номноос эрж хайдаггүй ээ.

Дмитрий Буряк/В&S холдингийн үүсгэн байгуулагч/:

-Аж ахуй эрхлэгч, менежер хоёрын хооронд үүсэх маргаанаас жинхэнэ сонирхолтой бизнес төслүүд төрсөн байдаг. Миний бодлоор, эрсдэлийг тооцоолоход хэцүү ажлыг хөдөлгөх ганцхан арга нь чухам энэ мөн. Манай дарга математикч, санхүүч мэргэжилтэй. Тэгээд намайг аливаа зүйлд сэтгэл хөдлөлтэй хандахад тэрбээр бүхнийг “тоогоор” илэрхийлдэг. Бид хоёрын хамтын ажиллагаанд энэ нь



сайнаар нөлөөлдөг. Миний сэтгэл хөдлөлтэй бодол санааг тэрбээр дандаа ухаалгаар зөв зүг рүү жолоодож өгдөг. Би бол харин байнга л ямар нэгэн юмыг эрэлхийлж, сүйтгэж, шийдвэр гаргах цаг хугацаа хүртэл санаанд таардаггүй. Дарга маань харин энэ бүхэнд зохицуулалт хийдэг.

Андрей Коркунов/Одинцовын чихрийн үйлдвэрийг үүсгэн байгуулагч/:

-Би хамт ажилладаг хүмүүсийн гаргасан санаан дээр тулгуурлаж ажиллахыг чухалчилдаг. Тэгэхийн тулд би “оюуны дайралт” хийж, хүмүүсийг нэг дор цуглуулдаггүй. Харин хагас сар, нэг сар орчим тэдний санал бодлыг зүгээр л сонсож, асуулт асуудаг. Тэрхүү мөчид миний толгойд ямар нэгэн хэрэгтэй санаа орж ирж байдаг. Төлөвлөгөөг боловсруулсныхаа дараа харин хүмүүсийг дуудаж, юу хийх талаар танилцуулдаг. Зүйр цэцэн үгэнд байдаг даа “Бүгдийн санааг сонс, гэвч өөрийнхөөрөө шийдвэрлэ” гэж. Үүнтэй адил би хүмүүсийн хэлснийг хэдийгээр сонсдог ч шийдвэрээ өөрөө л гаргадаг. Яг ийм аргаар санаачилсан бүтээгдэхүүн л манай борлуулалтын 50 хувийг бүрдүүлж байна.

Александр Шустер/“Мастерфарм” компанийн ТУЗ-ийн дарга/:

-Бизнес санаа хэрхэн төрдөг талаар би өөрөө ч сайн хэлж мэдэхгүй юм. Миний хувьд ямар нэгэн санааг хэрэгжүүлэхийн өмнө тухайн салбарын уран зохиол, нийтлэл, сэтгүүл уншдаг. Оросын уншигчид бараг мэдэхгүй “Yellow Script” нэртэй сэтгүүлийг баруунд харин их уншдаг юм байна лээ. Тэрхүү сэтгүүлийн эхнээс авахуулаад сүүлчийн хуудас хүртэл эмийн зах зээлд дэлхийн түвшинд дүн шинжилгээ хийсэн байдаг. Маш сонирхолтой бөгөөд хэрэгтэй мэдээллүүд л дээ. Бизнесийн шинэ санаа толгойд орж ирсэн тохиолдолд би маркетингийн тоог олж, өөрөө зах зээлд анализ хийж, үүний дараа мэргэжилтнээс зөвлөгөө авдаг. Эцэст нь хамтран ажилладаг түнштэйгээ нийлж тэрхүү бизнесийг хэрэгжүүлэх эсэхээ шийддэг.

Сергей Выходцев/ “Велле” компанийн захирал/:

-Зэлүүд алслагдсан газарт очсон үед миний толгойд хамгийн ихээр санаа орж ирдэг. Тийм ч учраас би Байгаль нуур дээр газар худалдаж аваад эдлэнтэй болсон. Төмөр зам хүртэл 100 км, ямар ч утасны сүлжээ барьдаггүй тийм л газар юм эргэцүүлэн бодоход надад хамгийн тохиромжтой байдаг. Велле овьёосон бүтээгдэхүүний санаа тэнд л төрсөн. Гэхдээ хийж байгаа ажлын минь хагас боловсруулсан эх үүсвэр оффист “оршдог” гэж хэлж болно. Надад “оюуны дайралт”-ын арга их таалагддаг. Манай ажилтнууд бүтээлч сэтгэлгээтэй, тиймээс би тэднийг шинэ санаагаар буцалж, дүүрэн байлгахын тулд байнга дэмжин ажилладаг. ■

Цахим дүүрэг

Та хэрвээ Хан-Уул дүүргийн иргэн бол анхааралтай уншаарай. Танай дүүргийн Тамгын газар, сургууль, цэцэрлэг, эмнэлгүүд, тэр ч байтугай хороод мэдээллийн технологийн давуу тал, боломжуудыг нэвтрүүлж танд үзүүлдэг үйлчилгээгээ сайжруулж байна.

Та төрийн ямар нэг үйлчилгээг авахдаа хамгийн анхан шатны нэгж болох харьяа хороон дээрээ очдог. Тэнд таны өрхийн бүртгэл, цэргийн алба хаасан эсэх зэрэг бүх бүртгэл бий. Хорооны ажилтнууд хэдэн мянган айл өрхийн гишүүд тус бүрийн бүртгэлийг тэд явуулж бүртгэж байдаг. Хороондоо гарсан өөрчлөлт, шилжин суурьшилт, хүн амын бүртгэл, малын бүртгэл гэх мэт бүх зүйлийнхээ тайлан мэдээг БХЯ, Статистикийн ерөнхий газар, УБЕГ-т гаргаж өгөхөөс гадна дүүргийнхээ Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс гээд шууд холбоотой ажилладаг олон газар бий.

Тэгвэл “Цахим дүүрэг” хөтөлбөрийн хүрээнд Хан-Уул дүүргийн бүх хороо дүүргийнхээ Тамгын газартай өндөр хурдны шилэн кабелиар холбогдож, бүх компьютер нь шинэчлэгджээ. Хүүхдийн тань сурдаг сургууль, хүмүүжжиг буй цэцэрлэг, таны үзүүлэхээр очиж буй эмнэлгүүд бүгд ялгаагүй Тамгын газартайгаа өндөр хурдны шилэн кабелиар холбогдсон. Ингээд тэд хоорондоо одооны жирийн хурдаар интернэт авахаа байж, өндөр хурдаар интернэтийн үйлчилгээг авч, ямар ч мэдээлэл, өгөгдлийг шуурхай, найдвартай дамжуулж чаддаг болжээ. Зүйрлүүлбэл тэд хоорондоо мэдээллийн хурдны замтай боллоо гэсэн үг.

Дараа нь бүх үйл ажиллагааг зангидан багцалж хялбаршуулсан, цахим харилцааг бий болгосон систем буюу цогц програм хангамжтай болсон. Эхлээд хороо бүр “e-Khoroо” гэсэн програмтай болов. Өмнө нь хорооны ажилтнууд бүртгэлүүдээ тус тусдаа таван төрлийн программ дээр хийж, тэр бүртээ нэг хүний мэдээллүүдийг давхар давхар оруулдаг байса тул ажилтнуудад ажлын ачаалал үүсгэдэг байж. Жишээ нь нэг програм дээр өрхийн бүртгэл, нөгөө програм дээр цэргийн бүртгэл, бас нэг дээр малын бүртгэлийг хийхийн тулд Бат гэдэг хүний овог нэр, ам бүл, оршин суугаа хаяг гэсэн тогтмол мэдээллийг давхар оруулахад хүрнэ гэсэн үг. Харин “e-Khoroо” бол энэ бүгдийг нэгтгэсэн цогц програм бөгөөд ямар ч бүртгэл тайлангуудыг гаргаж, өнөө мэдээллийн хурдны замаараа шууд харьяа газрууд руугаа явуулж болох юм. Үр дүнд нь хорооны ажилтан олон хийдэг байсан ажлаа нэг хийж, ажлын цаг хэмнэгдэн, бүтээмж нь өснө.

Түүнчлэн хорооны компьютерт байгаа тэр бүх програм тус бүр дээр таны өрх, амьжиргаатай холбоотой статистик, малын бүртгэлийг харуулсан

мэдээлэл, цэргийн бүртгэлийн програм, иргэний бүртгэл мэдээллүүдийн бааз бий. Энэ бааз нэгдсэн хамгаалалт байхгүй тул мэдээлэл алга болох, алдагдах өндөр эрсдэлтэй. Мөн Стандарт хэмжил зүйн үндэсний төвөөс албан хэргийг компьютерийн програм дээр хөтлөхдөө Unicode форматаар хөтөлнө гэсэн байтал дээрх олон программ энэ форматыг дэмждэггүй учраас үсгийн фронт арзайж, танигддаггүй ажээ. Дээр нь хорооны ажилтан статистикийн мэдээг Статистикийн газар руу, Иргэний бүртгэл мэдээллийг УБЕГ руу, цэргийн штабынхан мэдээгээ Батлан Хамгаалах яам руу гэх мэтээр тус бүртээ яам, агентлаг руу тайлагнаж өгөхдөө файл хэлбэрээр зөөж аваачдаг нь мөн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал талаасаа эрсдэлтэй байсан юм. “e-Khoroо” энэ бүгдийг бүрэн шийджээ.

Танай хүүхдийн сурч буй төрийн өмчит бүх сургуульд “e-School” программыг нэвтрүүлж, сургууль, сурагч, эцэг эх, багшийн хооронд цахим харилцаа архив үүсэж, бүх сурагчдын нэгдсэн мэдээлэл тэнд бүрдэнэ. Хан Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл болон бүх өрхийн эмнэлгийн дотоод сүлжээг сайжруулж, нийт компьютерийнх нь 30 хувийг шинэчилжээ. Эмч хоорондын үзлэгийн карт ч электрон болох мэтээр цахим харилцаатай болсон.

Цахим харилцаа үүснэ гэдэг нь хэн нэгэнтэй биеэр уулзах, цаас, бичиг дамжуулах, үүрэг даалгавар өгөх зэрэг үйлдлийг электрон хэлбэрт шилжиж, илүү боловсронгуй болж буй хэрэг.

Эцэст нь дүүргийн Засаг даргын Тамгын газарт ямар ч ажлаар хандсан хурдан, чирэгдэлгүй, хүнд сурталгүйгээр таны ажил бүтэх ёстой. Тиймээс Тамгын газрын ажилтнуудын бүх үйл ажиллагаа, харилцаа, процессыг электрон болгожээ. Ямар нэгэн захирамж гаргаж батлуулъя гэвэл дор хаяж 3-4 дарга дамжиж гарын үсэг зуруулж цаг алдаж, ажил удаашрах нь бий. Харин одоо бол аль дарга дээр хэд хоносон нь харагдаж, хэн гэдэг ажилтан өнөөдөр ямар ямар ажил хийсэн гүйцэтгэлүүд, бусад тайлан төлөвлөлт нь шат шатандаа хяналттай болжээ. Жишээ нь, иргэдээс ирдэг маш их өргөдөл гомдол дээр хүртэл тусгай систем боловсруулсан байна.

Энэ бүгдийн хамгийн эцсийн үр дүн бол төрийн үйлчилгээг иргэн танд түргэн шуурхай, хүнд сурталгүй, төвөг чирэгдэл учруулахгүйгээр хүргэх бөгөөд түүний төлөө Хан Уул дүүргийнхэн өөрсдөөсөө эхэлж, үйл ажиллагаагаа орчин үеийн мэдээллийн технологийн тусламжтайгаар шинэ түвшинд гаргаж ирж байна. Урт хугацаанд хэрэгждэг, маш том хөрөнгө оруулалтаар босдог, олон зүйлийг шинэчилж буй энэ хөтөлбөрийг дүүргийн удирдлагууд эхлүүлж, өмнөх процессыг өөрчлөн шинэчлэхээр зориглож, үнэхээр бодитой ажил болгожээ. Цахим дүүргийн иргэн болсон танд ч гэсэн баяр хүргэе. ■


Бизнесийн завсарлага

Таны амьдралд өөрчлөлт авчирсан номоо нэрлэхгүй юү?

Өөрийгөө үнэлж, тууштай байх зан чанарыг энэ номноос олж авсан С.Ганбаатар /МҮЭ-ийн ерөнхийлөгч/:

Stephen Covey "First Things First" ном нь миний ертөнцийг үзэх үзэл, хандах хандлагыг ихээхэн өөрчилж чадсан. Учир нь энэ хорвоо дээр хүн яах гэж ирсэн болон хэрхэн аз жаргалтай болох вэ гэдгийг л хамгийн энгийнээр ойлгуулсан. Мөн амьдралаа хэрхэн удирдаж жолоодох, цагаа яаж үр бүтээлтэй зохион байгуулах болон өөрийгөө үнэлэх, дотоод хүнээ хөгжүүлэх сэдлийг энэ ном надад өгсөн юм. Тиймээс ч би одоо ажил, амьдралд алинд ч хүнд хэцүү үе, тэвчээр шалгасан үе ирэхэд дотоод хүнтэйгээ аль болох ярилцаж зөв шийдлийг олохыг зорьж, өөрийгөө дайчилдаг. Нэг ёсондоо энэ номноос өөрийнхөө хамгийн чухал буюу өөрийгөө үнэлж, тууштай урагшлах ёстой

гэдэг зан чанарыг олж авсан гэж хэлж болно. "Ер нь боломж зөвхөн хүлээж авахад бэлэн болсон хүнд л ирдэг" гэдэг. Тиймээс өөрийнхөө амьдрал, эх орныхоо ирээдүйд хувь нэмрээ оруулахын тулд хүн бүр дор бүрнээ хичээж, чадах чинээгээрээ зүтгэх нь зүйтэй юм. Харин эдийн засгийн ухааны хувьд Peter Drucker-ын бизнес, эдийн засгийн чиглэлийн номнууд маш ойлгомжтой, энгийн илэрхийлэлтэй байдаг болохоор байнга уншдаг.




Дюйшин багш миний үлгэр дууриал Ц.Оюунгэрэл /МАЭХ-ны тэргүүн/:

Миний амьдралд том номнууд гэхээсээ үлгэр домог, өгүүллэгүүд их нөлөөлсөн. Багаасаа л эмээ, өвөөгөөсөө үлгэр, домог сонсож өссөнтэй ч холбоотой болов уу. Үзэл санаанд минь хамгийн их нөлөөлсөн өгүүллэг бол Чингиз Айтматовын "Анхны багш" хэмээх зохиол юм. Энэ өгүүллэгийг анх дөрөвдүгээр ангид байхдаа уншсан. Тэр үеэс Дюйшин багш миний үлгэр дууриал авдаг хүн болсон, одоо ч энэ зохиолын баатраар өөрийгөө хүмүүжүүлдэг.

авчирдаг вэ гэдгийг энэ номонд харуулсан байдаг. Түүнчлэн олж авсан эрдэм мэдлэгээ чадах чинээгээрээ бусадтайгаа хуваалцах нь амьдралыг ямар сайхан аз жаргалтай болгохыг уншсан хүн бүхэн олж мэдэх болно.

Сайхан нийгмийг бүтээхийн тулд хүн бүхэн байнга өөрийгөө боловсруулж, цаг ямагт суралцаж байх хэрэгтэй. Бидний ирээдүй хүүхэд, залуучууд маань оюунлаг, эрч хүчээр дүүрэн тэмүүлэлтэй байж л сайхан ирээдүйг авчирна. Бид гэрлийг хайх биш, өөрсдөө гэрэлтэж, эргэн тойрондоо гэрэл гэгээг бий болгож байх ёстой. Ийм ч учраас хүн бүхэн сурахаа хэзээ ч зогсоохгүй, сурснаа үргэлж бусадтайгаа хуваалцаж байгаасай гэж хүсье.



Унших бүртээ би шинэ мэдээлэл олж авдаг

С.Эрдэнэболд /Ерөнхийлөгчийн Тамгын газрын Олон нийттэй харилцах, мэдээлэл боловсруулах албаны дарга/:

Амьдрал, үзэл бодолд минь нөлөөлж, шинэ санаа, сэдлийг өгч байдаг олон сайхан ном бий. АНУ-ын Макалейстрийн их сургуулийн профессор Жак Уэтерфордын бичсэн "Genghis Khan and the making of the modern world" буюу "Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Эзэн Чингис хаан" ном 2004 онд хэвлэгдэн гарч манай улсын түүхийг дэлхий дахинд таниулж өгсөн гэж хэлж болно. Би энэ номыг анх 2007 онд уншаад үнэхээр бахархал, ухаарал хоёр зэрэг төрж байсан. Энэ номыг дахин дахин уншдаг. Дахин унших бүртээ шинэ мэдээлэл, шинэ утга агуулга, төсөөллийг олж авч, шинэ асуултууд урган гарч байдаг юм. Мөн энэ номыг уншсанаар би түүхийг илүү сонирхож, судлахад нөлөөлсөн.

гайхамшигтай нэвтрүүлж байсан гэдгийг дэлхий дахинд харуулж өгсөн юм.

Зохиогч эл номоо бичихийн тулд Чингис хааны байлдан дагуулалт өрнөсөн өдгөөгийн 30 гаруй орнуудаар явж, торгоны замын дагуу олон удаагийн аялал зохиож судалгаа хийж ирсэн юм билээ. Түүнчлэн одоо судалгааны түвшинд хэрэглэгдэж байгаа баримтуудад түшиглэж, түүхийг нүдэнд харагдтал сонирхолтойгоор дүрсэлсэн нь онцлог юм. Жишээ нь Чингис хааны зүс царайг бид хараагүй, арай бодитой гэх зураг хөрөгч ховор шүү дээ. Харин энэ номыг уншсанаар Чингис хааны сэтгэл санаа, хүсэл тэмүүлэл, зориг эрмэлзлэлийг мэдэрч зүс царай, үйл хөдлөл нь хүртэл төсөөлөгдөх шиг болдог. Аливаа ард түмэн өнгөрсөн түүх рүүгээ хэдий чинээ алсыг харж ухаажина, ирээдүйгээ төдий чинээ хол харж хөгждөг жамтай. Энэ ном бидэнд өвөг дээдсийн маань оюуны цараа, сэтгэлгээний гайхамшиг, эр зоригийг мэдрүүлж урам зориг, ухаарал өгөх сайхан бүтээл юм. ■

